

# Диахона



**Санваарын талаарх  
дөрвөн асуултын  
хариулт, 18-р хуудас**

**Цагаа дэмий үрэхээргүй үзвэр  
үйлчилгээг сонгох нь, 14-р хуудас**

**Амьдардаг газраа Сионыг  
байгуулах нь, 30-р хуудас**





“Эцэг нь хүүхдүүддээ зааж, тэднийг адислан, сайн мэдээний ёслолуудаар хангаж мөн санваарын өөр бусад бүхий л шаардлагатай хамгаалалтаар хангах эрх мэдэл хийгээд үүрэг хариуцлагатай байдаг. Тэрээр хайр, үнэнч байдал, хүндлэлийг ээжид нь үзүүлснээр хүүхдүүд нь тэрхүү хайрыг харах боломжтой.”

Ерөнхийлөгч Бойд К.Пакэр, Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч, “Миний мэддэг зүйлс,” *Лиакхона* 2013 оны 5-р сар, 7.



## ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Ажлыг яаравчлуулах нь Ерөнхийлөгч Томас С.Монсон
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Тохинуулагч

## ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 14** Ашиг тустай мэдээллийн хэрэгсэл  
Катрин Нэлсон  
*Бид үзвэр үйлчилгээтэй харьцахдаа зорилготой байж, тэдгээрийг сонгох сонголтуудаар адислагдаж болно.*
- 17** Эцэг эх байх нь мөн бүх зүйлээ салгах нь  
Жан Пинбороу  
*Бид Аврагчийг дагаж мөн хүүхдүүдээ болгоох үедээ анхаарал сарниулах зүйлсийг унтраан, салгаж, таслах болно.*

- 18** Санваарын хүч—бүгдэд хүртээмжтэй  
Линда К.Бертон  
*Санваар нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс ба хүүхдүүдийг адислахын тулд өгөгдсөн ариун итгэл бөгөөд үүгээр дамжуулан бид гэр бүлээрээ Бурхантай мөнхөд хамт амьдарч чадна.*

- 24** Газар бүрийн анхдагчид: Итали дахь хожмын үеийн гэгээнтнүүд: Итгэлийн өв  
Лиa Маккланахан  
*Италид ариун сүм барьсан нь итгэлтэй гэгээнтнүүдийн урт удаан түүхийн үр дүн юм.*

- 30** Христтэй адил байх дуудлага  
Ахлагч Жэффри Р.Холланд  
*Бид хэдийгээр Вавилонд байсан ч одоо бол байгаа газартаа Сионыг байгуулах цаг үе юм.*

### ХАВТСАН ДЭЭР


Нүүрэн талд: Гэрэл зураг чимэглэлийг Жэрри Гарнс. Хавтасны дотор талд: Гэрэл зураг чимэглэлийг Брэдли Слэйд.

## АЛБАД

- 8** Бид Христийн тухай ярьж байна: Есүсийн хайранд өлгийдөгдөн гайхширахуй  
Сисэр Лима Эскалантэ
- 10** Бидний гэр орон, бидний гэр бүлүүд: Бэрхшээл бол адислал юм  
Рачел Харрисон
- 12** Хуучин Гэрээний бошиглогчид: Самуел
- 13** Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Аравны нэг ба өргөлүүд
- 38** Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзалт: Хэзээ гэдэг үгээс ирдэг хүч  
Кэлли Луи Урари  
*24 цагийн дотор нөхөр маань үхлүүт өвчтэй болов. Нэг л үг биднийг хөтөлж байлаа.*



42



**42** Аз жаргалд хүргэх замыг дага

Бишоп Жэралд Коссэй

*Эдгээр гурван зарчим нь өөрсдийнхөө аз жаргалын уран барилгачин байхад та нарт туслах болно.*

**47** Сайн мэдээг интернэтээр хуваалцах нь

Мариа Махонри Иггразил  
Ардуо Андака

*Би итгэдэг зүйлийнхээ тухайд үргэлж л ичимхий байдаг байсан, гэвч нэгэн шинэ арга техник нээлттэй байхад минь надад тусалсан.*



**Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Сануулга: Торонд юу байна вэ?**



57

**48** Сонголт ба хариултууд: Илчлэлтийг таньж мэдэх нь

Ахлагч Ричард Г. Скотт  
*Өсөж хөгжихийн тулд бид зөв сонголт хийх чадвартаа итгэх ёстой.*

**52** Хэрэв би цээжин дотроо шатах мэт мэдрэмжийг мэдрэхгүй бол яах вэ?

Рачел Нийлсэн

**56** Намуухан өдөөлтүүдийг дага

**57** Дүүд минь өгсөн адислал

Жэссэ Жоунз

*Дүү минь мотоциклийн осолд орж, эмнэлэгт байв. Би сандарсандаа өвчтэй юм шиг л болсон байлаа.*

**58** Асуулт, хариултууд

*Би ариун ёслолын туршид юуны тухай бодож байх хэрэгтэй вэ?*

**60** Залуучуудын бат бөх байдлын төлөө: Аравны нэг дотоод хүч чадлаар хангадаг

Ахлагч Антони Д. Пэркинс

*Аравны нэгээ төлөх нь Их Эзэн Өөрийнхөө бүх амлалтыг биелүүлдэг гэдгийг мэдэхэд тань тусална.*

**62** Сүмдээ эргэж ирэх арга замаа олох нь

Дауг Бояак

*Нэгэн аялалд явтлаа мөн аравны нэгийг надад заах хүртэл сүм надад хэрэггүй гэж би боддог байсан.*

**63** Зурагт хуудас: Эвдэршгүй



66

**64** Ээжид зориулсан адислал

Сюзан Баррэтт

*Ээжийн нурууны өвчин нь түүнийг шаналгаж байв. Рубэн хэрхэн тусалж чадах байсан бэ?*

**66** Онцгой гэрч: Би одоо хэрхэн номлогч шиг байж чадах вэ?

Ахлагч Нийл Л. Андерсэн

**67** Бишрэл хүндэтгэлийн Хурга

Ахлагч Скотт Д. Вайтинг

*Би наадаг цаас авахдаа бишрэлтэй байхыг хүссэн боловч илүү сайн нэг зүйл тохиолдсон юм.*

**68** Дэлхий даяар найзуудтай болох нь: Би Италийн

Лорэдана байна

Эми Жэйн Лэвитт

**70** Зурагтай үйл ажиллагаа: Италийн Массимо

**71** Есүсийг дагах нь: Тусч бай

**72** Угандад хөгжим тоглох нь

Дэвид Диксон

**74** Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: Санваарын ёслолууд ба ариун сүмийн ажил гэр бүлийг минь адисалдаг

Жэннифер Мадди

**76** Бидний хуудас

**78** Бага насны хүүхдүүдэд зориулав

**81** Бошиглогчийн хөрөг: Гордон Б. Хинкли



## 2014 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН ДУГААР 15 NO. 3 ЛИАХОНА 10986 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,  
Дийтр Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулга:** Боид К.Пакэр,  
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,  
М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,  
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,  
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

**Эрхлэгч:** Крэйг А.Кардон

**Зөвлөхүүд:** Хосе Л.Алонсо, Мэрвин М.Арнольд, Шэйн  
М.Бөүэн, Стэнли Г.Эллис. Бага Кристоффэл Голдэн

**Удирдах захирал:** Дэвид Т.Варнэр

**Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:**  
Винсэнт А.Ваун

**Сүмийн сэтгүүлийн захирал:** Алан Р.Лоиборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх захирлын туслах:** Раян Карп

**Редакцийн баг:** Бриттани Бийти, Дэвид Диксон, Дэвид  
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая Фрийдмэн, Лори  
Фүллэр, Гаррэт Х.Гарфф, Ларин Портер Гаунт, Жэннифер  
Грэйс Жөүнс, Майкл Р.Моррис, Салли Жонсон Оджөрк,  
Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни, Пол  
Вандэнбэрг, Марисса Виддисон

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:**

Ж.Скотт Кнудсэн

**Зураглал чимэглэлийн удирдагч:** Тэдд Р.Петрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жанэтт Эндрьюс, Фэй  
П.Андрус, Мэндэл М. Бэнтли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,  
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан  
Лофгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брад Тизери,  
П.Никол Вокэнорст

**Оюуны өмчийн зохицуулагч:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэлийн захирал:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэх баг:** Кэвин К.Банкс, Конни Бөүторп Бриж, Жүүли  
Бурдэтт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,  
Гэйл Тэйт Раффэрти

**Хэвлэлийн захирал:** Крэйг К.Сэдвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсэн, Нэгдсэн  
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн  
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,  
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернет вэбсайт**  
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA  
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар  
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”  
буюу “заалач”) албани, англи, армен, бислам, болгар,  
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,  
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,  
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,  
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,  
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,  
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр  
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр  
байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэн хувиран олшруулж  
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual  
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:  
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

**For Readers in the United States and Canada:**

June 2014 Vol. 15 No. 3. LIAHONA (USPS 311-480) Mongolian  
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,  
June, July, October, and December) by The Church of Jesus  
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,  
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake  
City, Utah. Sixty days' notice required for change of address.  
Include address label from a recent issue; old and new address  
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt  
Lake Distribution Center at address below. Subscription help  
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,  
American Express) may be taken by phone. (Canada Poste  
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).  
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to  
Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,  
Salt Lake City, UT 84126-0368, USA.

# Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаанууд  
багтсан. Хоёр жишээг дор харуулав.



**“Санваарын хүч—бүгдэд хүртээмж-  
тэй,”** 18-р хуудас: Гэр бүлийн үдэш хий-  
хээс өмнө энэ өгүүлэл дэх Бертон эгчийн  
асуусан дөрвөн асуултыг уншина уу. Гэр  
бүлийн үдэшт зориулан жижиг чийдэн  
авчирч (чийдэнгээ асаахгүй авчирна), гэр  
бүлийн өөр өөр гишүүдээр үүнийг асаал-  
гах оролдлоо хийлгэ. Чийдэнг асаахад  
хэрэгтэй цахилгааныг санваарын хүчтэй  
жишээрэй. Чийдэнг залгаж асаагаад бид  
бүгдээрээ хэрхэн чийдэнгийн гэрлийн  
ашиг тусыг хүртэж эсвэл санваарын  
хүчийг олж болох тухай ярилцана уу.  
Санваараар дамжуулан хэрхэн адислагд-  
сан тухай гэр бүлийн гишүүдээр бодуул.  
Та нар Бертон эгчийн хүссэнээр Сургаал  
ба Гэрээ 84 дэх судруудыг цээжилж  
эхэлж болно.

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон сүмийн бусад материалуудыг [languages.lds.org](http://languages.lds.org) вэбсайтаас олон  
хэлээр үзэх боломжтой.

## ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.

**Аз жаргал, 42**

**Анхдагчид, 24**

**Аравны нэг, 13, 60, 62**

**Ариун Сүнс, 48, 52, 56, 67**

**Ариун сүм, 10, 24, 74, 78**

**Ариун ёслол, 8, 58**

**Бишрэл хүндэтгэл, 67**

**Бошиглогчид, 12, 41, 81**

**Бүхнээ зориулах нь, 14**

**Гэр бүл, 10, 17**

**Гэр бүлийн түүх, 4, 6, 38**

**Гэрлэлт, 10**

**Дуудлагууд, 72**

**Дуулгавартай байдал,**

18, 56

**Дуу хөгжим, 72**

**Есүс Христ, 7, 8**

**Залбирал, 48**

**Зарлигууд, 30**

**Илчлэлт, 18, 41, 48, 52, 56**

**Итгэл, 80**

**Мацгийн өргөлүүд, 13, 60**

**Мэргэн ухааны үг, 40**

**Найдвар, 80**

**Номлогчийн ажил, 24,**

30, 47, 66

**Санваар, 18, 64, 74**

**Сион, 30**

**Сонгох эрх, 14, 48**

**Сэтгэлийн хямрал, 39**

**Үйлчлэл, 71, 72**

**Хинкли, Гордон Б., 81**

**Хувь хүний үнэ цэнэ, 42**

**Хуучин Гэрээ, 12**

**Хэвлэл мэдээллийн**

**хэрэгсэл, 14, 17, 47**

**Хөрвөлт, 24, 62**

**Цагаатгал, 8, 58**



Ерөнхийлөгч  
Томас С.Монсон

# АЖЛЫГ ЯАРАВЧЛУУЛАХ НЬ

Сэргээгдсэн сүм 100 гадастай болох үедээ 98 настай байсан гэдгийг та нар мэдэх үү? Гэхдээ гуч хүрэхгүй жилийн дараа гэхэд сүм хоёр дахь 100 гадсыг зохион байгуулсан байсан. Үүнээс ердөө наймхан жилийн дараа сүм 300 гаруй гадастай болсон байна. Өнөөдөр бид 3000 гаруй гадастай болж, илүү хүчирхэгжээд байна.

Яагаад ийм хурдацтай өсөж байна вэ? Энэ нь бид илүү сайн танигдсан учраас уу? Аль эсвэл бид хараа булаам сайхан сүмийн барилгуудтай учраас тэр үү?

Эдгээр нь чухал зүйл боловч сүм өнөөдөр өсөн тэлж байгаагийн шалтгаан нь Их Эзэн Сургаал ба Гэрээнд “Болгоогтун, бибээр өөрийн ажлыг зохих цагт нь яаравчлуулах болно” хэмээн хэлсэн учраас тэр юм.<sup>1</sup>

Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн хувьд бид энэ агуу ажлыг яаравчлуулахад оролцохоор энэ цаг үед дэлхий рүү илгээгдсэн юм.

Түүний ажил мөнх бус байдлаар хязгаарлагддаг хэмээн Их Эзэн хэлж байсныг би санахгүй байна. Харин Түүний ажил мөнх оршихуйг бүрхдэг. Тэрээр сүнсний дэлхийд Өөрийн ажлыг яаравчуулж байгаа гэдэгт би итгэдэг. Мөн Их Эзэн тэнд буй үйлчлэгчдээрээ дамжуулан сайн мэдээг хүлээн авахад олон сүнснийг бэлтгэж байгаа гэдэгт би итгэдэг. Бидний ажил бол нас барагсдаа эрж хайн, ариун сүмд очиж, хөшигний цаана байгаа хүмүүст бидэнд байгаатай адил тэгш боломжийг авчрах ариун нандин ёслолуудыг гүйцэтгэх явдал юм.

Сүнсний дэлхийд байгаа сайн хожмын үеийн гэгээнтэн бүр завгүй байгаа гэж ерөнхийлөгч Бригам Янг хэлжээ (1801–1877). “Тэд тэнд юу хийж байгаа вэ? Тэд номлож байгаа, цаг үргэлж номлож мөн ариун сүмүүдийг энд болон газар сайгүй барих ажлыг яаравчлуулахад бидэнд туслах арга замыг бэлтгэж байгаа.”<sup>2</sup>

Гэр бүлийн түүхийн ажил нь амархан биш юм. Скандинаваас ирсэн хүмүүсийнхтэй адил бухимдал надад ч байдаг. Жишээлбэл, швед гаралтай өвөөгийн маань нэр Нэлс Монсон байсан ба харин түүний аавын нэр Монсон биш харин Монс Окесон байсан. Монсын аавын нэр Окэ Пэдэрсон, түүний аавын нэр Петр Монсон гээд буцаад Монсон болж эхэлж байна.

Их Эзэн та нарыг болон намайг гэр бүлийн түүхийн ажлаа сайн хийгээсэй хэмээн хүсэн хүлээдэг. Өөрсдийнхөө ажлыг сайн хийхийн тулд бидний хамгийн эхэлж хийх ёстой зүйл бол Тэнгэрлэг Эцэгийн Сүнстэй хамт байх явдал гэж би бодож байна. Бид хэрхэн амьдрахаа мэддэг шигээ зөв шударга амьдрах юм бол Тэрээр хичээнгүйлэн, чин сэтгэлээсээ бидний эрэлхийлдэг адислалуудыг хүлээн авах арга замыг нээж өгөх болно.

Бид алдаа гаргах болно, гэхдээ бидний хэн нь ч алдаа гаргахгүйгээр гэр бүлийн түүхийн мэргэжилтнүүд болж чадахгүй. Тиймээс бид нэлээн өгсүүр авиралтад бэлтгэж, энэ ажилд ханцуй шамлан орох ёстой. Энэ нь амар ажил биш ч гэсэн Их Эзэн үүнийг та нарт ч, надад ч мөн даалгасан билээ.





Гэр бүлийн түүхийн ажилд шаргуу оролцох үед та нарт арга мухардах үе ирэх бөгөөд тэр үед та нар өөрсдөдөө “Миний хийж чадах зүйл дууслаа” хэмээн хэлэх болно. Та нар ийм үе ирэхэд өвдөг сөгдөж, Их Эзэнээс арга зам нээж өгөхийг хүсвэл Тэрээр та нарын төлөө үүнийг нээж өгөх болно. Энэ нь үнэн гэдгийг би гэрчилж байна.

Тэнгэрлэг Эцэг таныг мөн намайг хайрладаг шигээ сүнсний дэлхий дэх Өөрийн хүүхдүүдийг ч бас хайрладаг. Нас барагсдаа аврах ажлын талаар бошиглогч Иосеф Смит “Одоо Бурханы агуу зорилгууд биелэлт

### ЭНЭ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Гэр бүлийн түүхээсээ дуртай нэг түүхээ сонгоод айлчлан очих хүмүүстэйгээ хуваалцаарай. Та айлчилж очих хүмүүсээ түүхээ хуваалцахад нь урамшуулан дэмжихийн тулд Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг (6-р хуудас) дэх хүүхдэд зориулсан хэсгийн асуултуудаас ашиглахыг хүсч болно. Сургаал ба Гэрээ 128:15-ыг уншиж мөн өвөг дээдсийнхээ өмнөөс ариун сүмийн ёслолуудыг хийлгэхийн ач холбогдлын тухай ярилцах талаар бодож үзээрэй.

рүүгээ яаравчилж, бошиглогчдоор яригдсан зүйлүүд гүйцэлдэж мөн Бурханы хаант улс газар дэлхий дээр байгуулагдан, зүйлүүдийн эртний дэг жаяг сэргэж буй энэ үед Их Эзэн бидэнд энэ үүрэг ба онцгой эрхийг үзүүлээ” хэмээн хэлжээ.<sup>3</sup>

Сайн мэдээний мэдлэггүйгээр нас барсан бидний өвөг дээдсийн талаар ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918) “Тэдний төлөөх бидний хүчин чармайлтаар тэдний боолчлолын гинж мултран унаж, тэднийг хүрээлсэн харанхуй арилан, гэрэл тэдний дээр гийж мөн сүнсний дэлхийд хүүхдүүдийнх нь тэдний төлөө хийсэн ажлын тухай тэд сонсож, эдгээр үүргүүдээ биелүүлэхэд тань та нартай хамт баясах болно” хэмээн хэлжээ.<sup>4</sup>

Нас барж, сүнсний дэлхий рүү явахаасаа өмнө Христийн нэрийг хэзээ ч сонсож байгаагүй Тэнгэрлэг Эцэгийн сая сая сүнсэн хүүхэд бий. Харин тэд одоо сайн мэдээг заалгасан ба та биднийг эрэл хайгуул хийн, Их Эзэний өргөөнд очиж; биднийг өөрсдийнх нь төлөө, хийж чадахгүй ажлыг нь хийхийг хүлээж байгаа билээ.

Ах, эгч нар аа, бид энэхүү ажлыг хүлээн авч мөн хариу үйлдэл хийх үед Их Эзэн биднийг адислах болно гэдгийг би гэрчилж байна. ■

### ЭШЛЭЛҮҮД

1. Сургаал ба Гэрээ 88:73.
2. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Бригам Янг [1997], 280.
3. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит (2007), 409.
4. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Жозеф Ф.Смит (1998), 247.

## Индексжүүлэлт хийх нь надад таалагдах болов уу?

Эмма Абрил Толедо Циснерос

**Б**и 50000 нэр индексжүүлэх зорилго тавьсан гадасныхаа ажилд оролцсон юм. Эхлээд энэ нь хэцүү байлаа. Хэд хэдэн удаа миний татаж авсан бүлэг нэрс ойлгоход хэцүү гар бичмэлээр бичигдсэн байдаг байсан ба би заримдаа үүнийгээ буцааж өгөөд өөр нэгийг татаж авахыг хүсдэг байлаа. Тэгээд хэрэв хүн бүр над шиг бодолтой байвал тэдгээр нэрс хамгийн сүүлд үлдэх болно гэдгийг би ойлгосон юм. Би сүнсний дэлхий дэх дараалан зогсох олон хүнийг төсөөлөн бодож чадсан тул тэрхүү нэрсийг үргэлжлүүлэн уншиж,

тэдгээрийг алдаа мадаггүй бичиж авахаар шийдсэн юм.

Би тэдгээр хүмүүсийг хайрлах талаар мэдэж авсан. Тэдэнд үнэхээр тусламж хэрэгтэй гэдгийг мөн бидэнд тэдний тусламж хэрэгтэйг ч би ойлгосон. Тэнгэрлэг Эцэгийн төгс төлөвлөгөө хүн бүрийг адил тэгш үздэг гэдгийг би илүү сайн ойлгож авсан юм. Бид Түүний сонгосон удирдагчдын илчлэлт, удирдамжуудыг дагах үед Түүний нигүүлсэл болон хязгааргүй хайрыг баттай мэдрэх болно.

Индексжүүлэх ажил нь миний хувьд гайхалтай туршлага байсаар ирлээ. Би гэр бүлийн түүхийн талаар олон зүйлийг үнэлж мөн хайрлаж сурсан. Би индексжүүлэх ажилд оролцох гэх мэт энгийн зүйлд дуулгавартай байснаараа Их Эзэнээс агуу үнэ цэнэтэй бэлгүүдийг олж авсан.

*Энэ өгүүллийг бичигч Мексикийн Веракрузэд амьдардаг.*

## ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

### Өөрийнхөө түүхийг олж мэд

**Э**цэг эх, эмээ өвөө нар чинь зөндөө адал явдалтай учирч байсан бөгөөд заримыг нь чи огт мэдэхгүй. Тэдний зарим түүх чиний инээдийг хүргэж мэдэх ч Тэнгэрлэг Эцэгтээ итгэх итгэлтэй болоход чинь тусалж чадна. Заримдаа насанд хүрсэн хүмүүс ч гэсэн ичимхий байдаг. Тэдний дуртай зарим түүхийг санахад нь туслахын тулд эдгээр асуултыг ашиглаж, хариултуудыг нь бичиж ав эсвэл зурж болно.





Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдээж авахаар эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь таны Түүнд итгэх итгэлийг хэрхэн нэмэгдүүлж мөн айлчлагч багшлалтаар дамжуулан харж ханддаг хүмүүсийг тань хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org)-аас үзнэ үү.

## Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Тохинуулагч

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиа-суудын нэг хэсэг юм.

**Б**ид бусдад үйлчлэх үедээ бидний үлгэр жишээ болсон Есүс Христийн жинхэнэ дагалдагчид болдог. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бидний эргэн тойронд тусламж хэрэгтэй хүмүүс байна. . . . Бид Түүний энэ дэлхий дээрх хүүхдүүдийг өргөх, тэдэнд үйлчлэх үүргийг хүлээсэн Их Эзэний мутар юм” гэж хэлжээ.<sup>1</sup>

Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон “Бид Бурханы хүүхдүүдэд үйлчлэх үед бидний хүн нэг бүр Аврагчтай илүү адил болж чаддаг. Бид бие биедээ илүү сайн [үйлчилж] сурахад маань тус болох дөрвөн үгийг санаж явахыг би санал болгох гэсэн юм: “Эхлээд ажигла, тэгээд үйлчил.” . . . Хэрэв бид ингэж үйлчлэх юм бол бид гэрээгээ сахих бөгөөд бидний үйлчлэл ерөнхийлөгч Монсоныхтой адил байж, биднийг ч мөн дагалдагч гэдгийг маань нотлох болно” гэж заажээ.<sup>2</sup>

Бид өглөө бүр бусдад үйлчлэх боломжуудыг таньж мэдэхийн төлөө залбирч чадна. “Тэнгэрлэг Эцэг чамайг хөтлөн удирдаж, тэнгэр элчүүд чамайг дэмжих болно. Чамд



бусдын амьдралыг адислах болон бодгалиудыг аврах хүч өгөгдөх болно” гэж Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Дэвид Л.Бэк хэлсэн.<sup>3</sup>

### Судруудаас

Матай 20:25–28; 1 Нифай 11:27–28; 3 Нифай 28:18

### ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 86.
2. Линда К.Бертон, “Эхлээд ажигла, тэгээд үйлчил,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 78, 80.
3. Дэвид Л.Бэк, “Та нарын үйлчлэх ариун үүрэг,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 56.
4. Люси Мисэрв Смит, *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society (Миний хаант улсын охид: Халамжийн Нийгэмлэгийн түүх ба ажил)* (2011), 36–37.
5. Жорж Албэрт Смит, *Daughters in My Kingdom (Миний хаант улсын охид)*, 77.



Итгэл, гэр бүл, халамж

### Бидний түүхээс

1856 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) гар тэрэгтэй анхдагчид аялалаа үргэлжлүүлсээр байгаа гэдгийг зарласан бөгөөд хүн бүрийг тэдэнд зориулан хэрэгцээтэй зүйлсийг даруй бэлтгэх үүрэг өгчээ. Люси Мисэрв Смит энэ талаар: эмэгтэйчүүд “яг энд табернеклд урт банзал, оймсоо тайлан мөн илүүчилж болох бүх зүйлээ цуглуулж, [тэдгээрийг] морь тэргэнд ачив” хэмээн бичжээ.

Аврагдсан анхдагчид Солт Лэйк хотод ирж эхлэх үед Люси “Би амьдралдаа хийж байсан ямар ч хөдөлмөрөөс ийм их сэтгэл ханамжийг авч байгаагүй бөгөөд нэгдмэл байдлын мэдрэмж маань давамгайлж байлаа. Би дэлгүүрт ороод хүсэж байгаа зүйлээ хэлэхэд л хангалттай байсан ба би даавуу хүссэн л бол надад үнэггүйгээр хэмжиж өгч байсан” хэмээн бичжээ.<sup>4</sup>

Ерөнхийлөгч Жорж Албэрт Смит (1870–1951) бусдад тохинуулах талаар: “Бидний мөнхийн аз жаргал нь бусдад туслахын тулд өөрсдийгөө зориулах явдалтай шууд хамааралтай байх болно” гэж хэлжээ.<sup>5</sup>

### Үүнийг эргэцүүлэн бод

1. Залбирал биднийг Их Эзэний мутар дахь зэмсэг байхад хэрхэн удирдаж чадах вэ?

2. Бусдад тохинуулах нь биднийг гэрээнүүдээ сахихад маань хэрхэн тусалж чадах вэ?

# ЕСҮСИЙН ХАЙРАНД ӨЛГИЙДӨГДӨН ГАЙХШИРАХУЙ

Сизэр Лима Эскалантэ

Нэгэн ням гарагт ариун ёслолын өмнө бишоп над дээр хүрч ирээд “Та ариун ёслолыг адислахад тусалж чадах уу?” гэж асуухад би тэгэлгүй яахав гэж хэлэв.

Би дууллын номоо аваад дараа нь ариун ёслолын ширэнд суухаасаа өмнө гараа угаалаа. Дууллын номоо нээгээд миний хамгийн эхэнд харсан дуулал нь “Би гайхширна” (*Сүмийн дуулал*, 22-р хуудас) байлаа. Цуглаан хараахан эхлээгүй байсан учраас би “Би Есүсийн хайранд өлгийдөгдөн гайхширч байна” гэсэн нэгдүгээр бадгийг уншив. Тэр даруйд би зүрхэндээ маш хүчтэй хайрыг мэдэрч билээ.

Өмнөх орой нь би Библи дэх Есүс Христийн амьдралын төгсгөлийн үйл явдлууд—сүүлчийн зоог, Гетсеманы цэцэрлэг болон Түүний нас баралт ба амилалтын тухай уншиж байсан юм. Би Есүсийг тамлагдаж, цохиулж мөн цэргүүдэд доромжлуулж байгаагаар төсөөлөн бодсон. Түүнчлэн би Есүсийг дагалдагчдаа унтаж байх үеэр Өөрийн цагаатгагч золиослолыг Гетсеманы цэцэрлэгт гүйцэтгэж байгаагаар төсөөлөн харав.

Энэ мөчид би Түүний биеийг мөн цусыг төлөөлдөг талх, усыг адислах дөхөж байгаагаар анзаарлаа. Ариун ёслол нь бидэнд баптисм хүртэх үедээ хийсэн Түүнийг үргэлж дурсан санаж, Түүний зарлигуудыг

сахиж мөн Түүний нэрийг өөрсөд дээрээ авах гэрээгээ шинэчлэх боломжийг бидэнд олгодог.

Ариун ёслол эхлэхэд эдгээр бодол миний толгойд байв. Есүс бидний төсөөлж чадахаас ч илүү их өвдөлтийг мэдэрч, байж боломгүй арга замаар зовсон гэдгийг би хүчтэйгээр мэдэрсэн юм. Дараа нь Тэрээр гагцхүү бидэнд болон надад хайртай учраас л зовлон шаналалыг тэвчсэн гэсэн бодол орж ирэв.

Би Их Эзэн намайг ямар их хайрладгийг мэдэрч, нулимсаа барьж

чадсангүй. Би Аврагчийн миний төлөө хийсэн зүйлийг хүртэхүйц зохистой биш гэсэн мэдрэмж надад байв. Гэвч Түүний намайг хайрлах хайр нь төгс гэдгийг би мэдэрсэн. Найз хүн найзынхаа төлөө амиа зориулна (Иохан 15:13-ыг үзнэ үү). Ариун ёслолын дуулал эхлэхэд ёслолыг эхлүүлэхээр би нэг ахтай хамт бослоо.

Бид талхыг бүтээсэн үзэмжтэй цагаан бүтээлгийг хойш нь эвхлээ. Би талхыг гартаа барих үедээ үүнийг ёслолын нэг хэсэг болгон эмтэлж



## СҮНСЛЭГЭЭР ЦЭВЭРШҮҮЛЭХ ТУРШЛАГА

“Ариун ёслолыг долоо хоног бүр сүнслэг ариусгалын цаг болгохын тулд бид ариун ёслолын цуглаанд ирэхээсээ өмнө өөрсдийгөө бэлдэх ёстой. Бид өдөр тутмын ажлаасаа амарч, зугаа цэнгэл, дэлхийн бодол санаа болон асуудлуудаа орхисноор өөрсдийгөө бэлтгэж болно. Ийн үйлдсэнээр бид өөрсдийн оюун бодол, зүрх сэтгэлд Ариун Сүнс орших зайг гаргаж өгдөг. . . .

“Ариун ёслолын дууллыг дуулж, Түүний бие махбодын болон урсгасан цусны бэлэг тэмдгээс хүртсэнээр бид залбиралтайгаар гэм нүгэл, алдаа дутагдлуудаа өршөөлийг эрэлхийлдэг. Бид хийсэн амлалтуудаа болон эдгээр амлалтаа өмнөх долоо хоногт хэрхэн биелүүлснээ бодож, ирэх долоо хоногт Аврагчийг дагана гэсэн хувийн, тодорхой амлалтуудыг Түүнд өгдөг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс “Өөрсдийгөө таньж мэдэх нь: Ариун ёслол, ариун сүм, үйлчлэлийн золиос,” *Лиахона*, 2012 оны 5-р сар, 34.





жигиглэх үүрэгтэй гэдгээ мэдэж байсан боловч тээнэгэлзэж эхлэв. Талх Христийн биеийг төлөөлдөг. Би Их Эзэнийг өвтгөж байсан цэргүүдийг бодоод талхыг эмтэлмээргүй байлаа. Эхний хэсэг талхыг эмтлэх үедээ би Есүсийн үхэхээсээ өмнө амссан зовиур ба доромжлол—өргөст титэм, ташуурдалт, зовлон шаналал зэргийг бодлоо. Талхыг бэлтгэх үед нулимс хацрыг минь даган урссаар байв.

Дараа нь эдгээр зовлон шаналал болон доромжлол нь зайлшгүй шаардлагатай байсан гэсэн бодол надад төрж билээ. Тэдгээр нь Есүс Христийн цагаатгагч золиослолын нэг хэсэг байсан ба Тэрээр надад болон бидний хүн нэг бүрд хайртай учраас золиослол хийсэн юм.

Би агуу амар амгаланг болон баяр баяслыг мэдэрч эхлэв. Би талхны хэсэг нэг бүрийг хянамгай бөгөөд алгуур эмтлэн жигиглэж, миний гарт байгаа энэ зүйл нь нэгэн онцгой зорилгын улмаас мөдхөн адислагдаж мөн ариусагдан, маш үнэ цэнэтэй, гайхамшигтай ба ер бусын зүйлийг төлөөлөх болно гэдгийг мэдэж байлаа. Би энэ ёслолыг гүйцэтгэх агуу үүрэг хариуцлагыг мэдэрсэн бөгөөд үүгээр дамжуулан

цуглаанд оролцож байгаа хүмүүс Их Эзэнтэй гэрээгээ шинэчилж мөн Цагаатгалын адислалуудыг хүлээн авах боломжтой болдгийг ойлгосон юм.

Биднийг ёслол гүйцэтгэж дуусахад би эмтэлсэн талхаар дүүрсэн царуудыг харсан. Энэ нь гайхамшигтай бөгөөд сүр жавхлантай байлаа. Хамтрагч маань залбирал хэлэв. Би “тэд Таны Хүүгийн биеийг төлөөлөн дурсаж, үүнийг идэж болохын тулд” (С ба Г 20:77) гэж хэлдгийг урьд өмнө нь хэзээ ч ийм тодорхой ойлгож байгаагүй юм.

Би талхнаас хүртэх үедээ Аврагчийн хайрыг дахин мэдрэв. Би хамгаалагдан, даруусгагдаж мөн зөвийг хийхээр сэтгэл шулуудсан мэт мэдрэмжтэй байсан. Би амьдралаа эргэн харж мөн хийсэн бүх буруу зүйлээ наманчлахыг хүсч билээ.

Би Есүс Христийн намайг хайрлах хайранд талархдаг. Бид нүглүүдээсээ өршөөгдөж мөн Тэнгэрлэг Эцэгтээ буцаж очих боломжийг өгөх Түүний Цагаатгалын адислалуудыг хүлээж авах боломжтой байгаадаа би талархдаг. ■

*Энэ өгүүллийг бичигч Мексикийн Мехико хотод амьдардаг.*

## **БОДОЖ ТУНГААХ АСУУЛТУУД:**

Би ариун ёслолоос хүртэхэд илүү сайн бэлтгэхийн тулд долоо хоногийн турш юу хийж болох вэ? Ариун ёслолын турш би юу бодох ёстой вэ? Би ариун ёслолоос хүртэх үедээ уучлагдсанаа мэдэрч мөн илчлэлт хүлээж авдаг бил үү?

# БЭРХШЭЭЛ БОЛ АДИСЛАЛ ЮМ

Рачел Харрисон

*Ариун сүмд гэрлэснээс улбаалсан  
бэрхшээлүүд гэж бодож байсан маань  
гайхалтай адислалууд болон хувирсан*

**Б**и нэгэн сайн найзтайгаа ариун сүмд гэрлэснээс ирдэг адислалуудын тухай ярилцаж байлаа. Би үүнтэй холбоотой цөөн хэдэн адислал ирдэг харин нэлээд их бэрхшээл байдаг хэмээн тоглоом шоглоомоор хэлсэн юм. Гэтэл найз минь “Гэхдээ тэдгээр нь адислалууд ч юм бил үү!” хэмээн хэлэв.

Түүний зөв гэдгийг би мэдэж байлаа.

Ариун сүмд лацдагдан холбогдсон нь намайг гэрлэлт ба гэр бүлийн талаар мөнхийн талаас нь харах хараагаар адисалсан. Ариун сүмд хийсэн гэрээнүүд маань шинэхэн гэрлэсэн хос болох нөхөр, бид хоёрын хувьд өмнөө байгаа

сонголтуудыг харах “нүдний шил” болсоор байгаа билээ.

## Мөнхийн талаас нь харах хараа

Бид гэрлэхдээ мөнхийн гэдэг талаас нь харсан бөгөөд бид гэр бүлд маань ирэх хүүхдүүдийн тоог хязгаарлах эсвэл хүүхэдтэй болохыг азнах ёсгүй гэсэн мэдрэмжтэй байлаа. Ам бүл нэмэгдэхийн хажуугаар нөхөр маань дээд боловсролоо үргэлжлүүлж байв. Түүнийг ажлын гараагаа эхлэхэд бид таван хүүхэдтэй болсон байлаа. Би гэртээ хүүхдүүдээ асрахын тулд хагас цагаар сурч байв. Эргээд бодоход тэдгээр эхэн үеийн он жилүүд дотно санагдаг. Тэдгээр он жилүүд гайхалтай байсан! 2 хүүхэд маань ой ч хүрээгүй байсан бөгөөд бид жижигхэн байранд оюутны тэтгэмжээр тарчигхан амьдарч, маш их махан таташ (гамбургер) иддэг байлаа.

Гэрлэлтийнхээ энэ эхэн үеийг би бидний анхдагч он жилүүд хэмээн үздэг ба бид боловсрол олж авах, гэр бүлээ зохиох, хязгаарлагдмал санхүүгийн эх үүсвэрээр амьдрах гэх мэт “тал хөндийгөөр” аялж байв. Би Мартины гар тэрэгний аялалаас амьд үлдэгдэгсдийн нэгэнтэй бага ч болов адил мэдрэмжтэй байлаа. Тэрээр аялалынхаа талаар: “Бидний хүн нэг бүр Бурхан амьдардаг гэсэн баттай мэдлэгтэй болж ирсэн юм. Учир нь бид зовлон бэрхшээлийнхээ дунд Түүнтэй танил болсон” хэмээн хэлсэн байдаг.<sup>1</sup>

Гэрлэлтийнхээ эхний жилүүдэд бидний хийсэн сонголтууд нь

дэлхийн нүдээр харахад ойлгомжгүй байсан юм. Хүүхэдтэй болохын тулд төгсөлтөө хойшлуулан, нэг хүний орлогоор амьдарч мөн зарим тансаг хэрэглээг золиослох нь тэнэг зүйл мэт харагдсан байж болно.

Гэвч Их Эзэн Исаиад

“Учир нь миний бодол санаанууд бол та нарын бодол санаа биш. Миний зам нь та нарын замаас өөр” гэж Эзэн айлдаж байна.

“Тэнгэр нь газраас өндөр байдаг шиг, Миний зам та нарын замаас, Миний бодол та нарын бодлоос өндөр билээ” хэмээн хэлжээ (Исаиа 55:8–9).

Гэр бүлийнхээ төлөө Тэнгэрлэг Эцэгийн хүслийг дагахын тулд дэлхийн зорилгуудыг золиослох нь бидний амьдралд даруусгасан адислал болсон юм.

## Бэрхшээлүүдтэй хамтдаа нүүр тулах нь

Сургаал ба Гэрээнд бид “гэрээнүүдээ золиослолоор дагахад бэлэн байгаа тэд . . . [Их Эзэнээр] хүлээн зөвшөөрөгддөг” хэмээн уншдаг.

“Учир нь Их Эзэн, бибээр үнэт үр жимс нэн ихийг ургуулдаг, цэвэрхэн горхины дэргэд сайн газарт таригддаг мод лугаа адил тэднийг урагш авчрах болгоно” (С ба Г 97:8–9). Таван хүүхэд маань бидний үнэт үр жимс юм. Тэд бол ямар ч эргэлзээгүйгээр бидний хамгийн агуу адислал юм.

Цаг хугацаа өнгөрөх тусам нөхөр бид хоёр гэр бүл дотроо олон бэрхшээлтэй тулгарч байсан ч энэ

**Г**эрлэлт нь амьдралын хамгийн чухал үүрэг хариуцлагуудыг болон хамгийн баяр баясгалантай мөчүүдийг авчирдаг. Бид таны гэрлэлтийн баяр баясгалантай мөчүүдийн талаар сонсохыг хүсэж байна. Өөрийн түүхийг [iahona.lds.org](http://iahona.lds.org) хаягаар хуваалцана уу (“Submit Your Work” гэдэг дээр дарна уу) эсвэл [iahona@ldschurch.org](mailto:iahona@ldschurch.org) хаягаар э-мэйл илгээнэ үү.





бүхнийг эргэж хараад би тэдгээр бэрхшээлүүдэд талархаж байгаагаа шударгаар хэлж чадна. Их Эзэн биднийг хувь хүнийх нь хувьд сайжруулахын тулд мөн биднийг Өөр рүүгээ болон хань ижил рүү маань эргүүлэхийн тулд бэрхшээлүүдээр адисалдаг.

Ариун сүмийн гэрлэлт нь өргөмжлөлийн агуу гэрээ юм. Энэ гэрээг сахисан үед энэ нь биднийг селестиел хаант улсын хамгийн дээд түвшин буюу мөнх амьдрал, мөнхийн өсөлт хөгжилт рүү аваачдаг (С ба Г 131:1–4-ийг үзнэ үү). Ийм агуу шагнал байгаа учраас бид ариун сүмийн гэрлэлт биднийг сорьж, мөн чанарыг маань өөрчлөх болно гэсэн бодолтой явах ёстой.

Далын гишүүн асан, ахлагч Брүс С.Хафэн “Бид тав тухтай байхын тулд гэрлэсэн байж болно. Гэвч асуудлууд гарч ирдэг. Бид тэдгээрийг шийдвэрлэхийн тулд чин сэтгэлээсээ хичээх үедээ тав тухтай байхгүй байж мэдэх ч бид өсч хөгжих болно. Тэр үед бид зөвхөн тав тухтай байхын төлөө бус

харин баяр хөөртэй байхын төлөө гэрлэсэн байх болно.”<sup>2</sup> Хамтдаа асуудлуудаа шийдвэрлэх нь тийм ч таатай байгаагүй, гэхдээ энэ нь үнэхээр бидэнд баяр хөөрийг авчирсан.

### Шаргуу хөдөлмөр ба баяр баясал

Эх хүн байх нь миний хийж байсан зүйлүүдээс хамгийн хэцүү нь. Хүүхэдтэй болохоосоо өмнө би эх хүн байх гэдэг нь ихэнхдээ аз жаргалтай байж, цөөн тохиолдолд шаргуу ажиллах ёстой зүйл гэж боддог байлаа. Харин энэ нь эсрэгээрээ болохыг би ойлгосон юм. Бидний гэрлэлт, нөхөр бид хоёрын хоорондын мөнхийн харилцаа, эцэг эх байх зэрэг нь Тэнгэрлэг Эцэгтэй адил болох лаборатори болсон юм. Энэ амьдралд эцэг эх байх үүрэг хариуцлага нь “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Моисе 1:39) Тэнгэрлэг Эцэгийн маань ажил болон алдар суутай төстэй юм. Эхнэр ба эх хүн байх нь бурханлаг тэвчээр,

хүч чадал болон хайрыг шаарддаг. Эх хүн байх нь мөн чанар, хүсэл мөн боломжуудаараа Бурхантай илүү адил болоход минь надад тусалж байна.

Ариун сүмийн лацдан холболт нь төсөөлж байгаагүй арга замуудаар намайг адисалсаар ирсэн. Энэ нь миний хувьд хүч чадлын, хүүхдүүдийн маань хувьд тогтвортой байдлын эх сурвалж юм. Энэ нь өвөг дээдэстэй маань холбосон холбоос бөгөөд би тэдний өмнөөс ариун сүмийн ажил хийх үед тэд адислагдаж байдаг. Ариун сүмийн гэрлэлт нь ямар ч золиослолоос илүү үнэ цэнэтэй бөгөөд энэ нь агуу адислалууд авчирдгийг би мэднэ. ■

*Энэ өгүүллийг бичигч Шинэ Зеландад амьдардаг.*

### ЭШЛЭЛҮҮД

1. Францис Вэбстэр, Вилиам Р.Палмэр, “Pioneers of Southern Utah (Өмнөд Ютагийн анхдагчид),” *The Instructor*, 1944 оны 5-р сар, 217–218.
2. Брүс С.Хафэн, *Covenant Hearts: Marriage and the Joy of Human Love (Гэрээний гол утга учир: Гэрлэлт ба хүмүүний хайраас ирэх баяр баясал)* (2005), 13.

## САМУЕЛ

*“Их Эзэний дуудлагад хариулсан Самуел хөвгүүний туршлага нь надад үргэлж урам зориг өгсөөр ирсэн” —Ерөнхийлөгч Томас С.Монсон<sup>1</sup>*

Миний ээж Ханна хүүхэдтэй болдоггүй байсан бөгөөд хүүтэй болохын төлөө ариун сүмд очиж залбиран, хүүгээ Их Эзэнд өгнө хэмээн андгайлжээ. Бурхан түүний залбиралд хариулж, ээж маань намайг төрүүлэв. Намайг бага балчир байхад ээж минь намайг Бурханд үйлчлүүлэхээр ариун сүмд авчирсан. Тэнд санваартан Ели намайг халамжилж мөн надад заасан юм.<sup>2</sup>

Хүүхэд байхдаа би нэг орой хэн нэгэн нэрээр маань дуудахыг сонсов. Би гурвантаа Ели рүү очсон боловч тэр намайг дуудаагүй байв. Их Эзэн чамайг дуудаж байна гэж тэр хэлсэн. Дөрөв дэх удаагаа нэрээ сонсох үедээ би Елигийн зөвлөгөөг дагаад “Айлдаж хайрла. Боол тань сонсож байна” гэж хариулав.<sup>3</sup> Их Эзэн надад хандан ярьсан бөгөөд намайг өсөн торних үед Тэр надтай хамт байлаа. Тэр намайг Өөрийнхөө бошиглогч байхаар дуудсан.

Би өсөж том болоод хөвгүүдээ

Израилын дээрх шүүгчид болгон томилов. Миний хөвгүүд зөв шударга бус байсан учраас Израилын ахлагчид хаантай болохыг хүссэн юм. Би хүмүүст хаантай байхын аюулын талаар сэрэмжлүүлсэн боловч тэд үргэлжлүүлэн гуйсаар байлаа. Их Эзэн надад “тэдний дуу хоолойг сонс” хэмээн зарлиглав.<sup>4</sup>

Их Эзэн Саул—хэмээх “шилдэг сайхан залууг” над руу илгээж<sup>5</sup>— мөн би түүнийг “Израилыг захирах ноён” болгон тослов.<sup>6</sup> Тэр тэдний хаан болов. Гэсэн хэдий ч Их Эзэн Саулд амаликайчуудыг болон тэдэнд байгаа бүхнийг устгахыг зарлиглахад тэр дуулгавартай дагасангүй.

Тэрээр амаликайчуудын малыг авч үлдэж мөн тэднээр тахил өргөв. Би Саулд “дуулгавартай дагах нь тахил өргөхөөс илүү, сонсож дагах нь хуцын өөхнөөс илүү” хэмээн заав.<sup>7</sup>

Саулын дуулгаваргүй байдлаас болж Их Эзэн надад Иессегийн хөвгүүдээс нэгийг нь шинэ хаан

болгон тослохыг зарлиглав. Иессе өөрийнхөө долоон ууган хүүг надад танилцуулав. Гэвч Их Эзэн тэднийг сонгосонгүй.<sup>8</sup> Түүний отгон хүү Давид хаан болох ёстойг Их Эзэн надад илчлэв. Гадаад төрх болон бие бялдраараа Давидын ах нар ирээдүйн хаад шиг харагдсан байж болох юм. Харин Их Эзэн Өөрийнхөө хүмүүсийг удирдуулахаар энэ хоньчин залуу хөвгүүнийг сонгожээ. Энэ туршлагаас би “Учир нь Бурхан хүнтэй адил хардаггүй. Хүн гаднах төрхийг нь хардаг бол Эзэн зүрхийг нь хардаг” гэдгийг мэдэж авсан юм.<sup>9</sup> ■

## ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “The Priesthood in Action (Үйлдэл дэх санваар),” *Ensign*, 1992 оны 11-р сар, 47.
2. 1 Самуел 1–2-ыг үзнэ үү.
3. 1 Самуел 3:10.
4. 1 Самуел 8:22.
5. 1 Самуел 9:2.
6. 1 Самуел 9:16.
7. 1 Самуел 15:22.
8. 1 Самуел 16:10-ыг үзнэ үү.
9. 1 Самуел 16:7.





## АРАВНЫ НЭГ БА ӨРГӨЛҮҮД



**Х**үүхдүүд аравны нэг болон өргөлүүдийг төлснөөрөө Их Эзэн Өөрийн амлалтуудыг биелүүлдэг гэдгийг мэдэж авч чадна.

Энэ дугаарын 60–61-р хуудас дээрх өгүүлэлд Давын гишүүн, ахлагч Антони Д.Пэркинс өсвөр насны хүүхэд байхдаа олсон орлогоо үрэхээсээ өмнө аравны нэгээ төлөх нь хэрхэн хүсэл ба хэрэгцээгээ ялгаж сурахад нь тусалсан тухай өгүүлдэг.

Энэхүү зарлигийг сахиснаар “миний итгэл илүү хүчтэй болж мөн [Их Эзэний] бусад зарлигуудыг сахих хүсэл минь ч бас хүчирхэг болсон” гэж ахлагч Пэркинс хэлжээ. Тэр *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд заагддаг “Аравны нэгээ төлөхөд та нарын хандах хандлага чухал байдаг. . . . Талархалтайгаар мөн хүсэлтэйгээр төл” ([2011], 38) хэмээх зарчмыг хэрэгжүүлсэн байна.

### Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- Өсвөр үеийнхэн ихэнх тохиолдолд бусдын үлгэр жишээнээс суралцаж чадна. “Аравны нэгийн адислалууд” (*Лиахона*, 2013 оны 3-р сар, 26) өгүүллээс аравны нэгээ төлснөөр адислагдсан таван хүний талаар уншина уу. Аравны нэг танай гэр бүлийг хэрхэн адисалсан талаар ярилцана уу. Та мөн

аравны нэг ба өргөлүүд нь сүмийн бүх гишүүдийг хэрхэн адисалдаг талаар ярилцахыг хүсэж болно.

- *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын (38–39-р хуудас) аравны нэг ба өргөлүүдийн тухай хэсгийг хамтдаа унших талаар бодож үзээрэй. Та мацаг барих ба мацгийн өргөлүүд нь хоорондоо хэрхэн холбоотойг мөн танай гэр бүл мацгийн өргөлийг хэрхэн төлдөг талаар ярилцаж болно.

### Хүүхдүүдэд заах зөвлөмж

- Дараах үзүүлэн хичээлийг ашиглах талаар бодож үзээрэй: Ширээн дээр 10 зоосон мөнгө тавь. Хэрэв та гэр бүлийн гишүүддээ есөн зоосыг өгөөд үлдсэн нэг зоосыг нь Их Эзэний хаант улсыг байгуулахад зориулан хадгална гэж хэлбэл ямар санагдах байсныг тэднээс асуу. Тэд энэ саналыг хүлээж авахад бэлэн байх болов уу? Та тэгээд энэ нөхцөл байдал ба аравны нэгийн хуулийн хоорондох адил төстэй талуудыг тайлбарлаж болно.
- Та 2011 оны 8-р сарын *Лиахона* (70–72-р хуудас) дахь “Бага насны хүүхдэд зориулав”

### ЭНЭ СЭДВИЙГ АГУУЛСАН СУДРУУД

Левит 27:30, 32

Дэд хууль 26:12

Нехемиа 10:38

Малахи 3:8, 10; мөн

3 Нифай 24:8,

10-ыг үзнэ үү

Лук 18:12


Алма 13:15

Сургаал ба Гэрээ 64:23;

97:10–12; 119:3

хэсэгт өгүүлдэг, өгч буй хандив нь ганцхан зоос байсан ч гэсэн аравны нэг төлөх нь сайн сонголт гэдгийг ойлгосон нэгэн хөвгүүний бодит туршлагыг ашиглаж болно. Мөн та үүнтэй холбоотой үйл ажиллагаануудыг хүүхдүүдтэйгээ хамт хийснээр дуусгаж болно. ■

Лиахона *сэтгүүлийн өмнөх дугааруудыг* [iahona.lds.org](http://iahona.lds.org) хаягаар уншиж болно.



*Ашиглаж буй бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл тань та нарт нөлөөлж байдаг. Таны сонгосон хэвлэл мэдээллийн хэрэгсэл сургамж өгөхүйц, чиг зорилготой байж бас сүнслэгээр нөлөөлдөг үү?*



**Д**аниел, Шадрах, Мешах, Абед-него нар Небухадне-зар хааны өмнө авчрагдахад тэдэнд хааны махнаас нь идэж, дарснаас нь уу хэмээн хэлжээ. Гэвч тэд ногоо идэж (үр тариагаар хийгдсэн хоол) мөн ус уухаар шийджээ. 10 өдрийн дараа “хааны амттан шимт-тэнээс хүртсэн бүх залуусаас тэд илүү тарган цатгалан, царай зүс нь илүү өнгөлөг байв. . . . Энэ дөрвөн залууд Бурхан уран зохиол ба мэргэн ухааны бүх салбарт мэд-лэг ба оюуны чадварыг өгөв. Даниел бүх төрлийн үзэг-дэл хийгээд зүүдийг ойлгодог байлаа” (Даниел 1:15, 17).

Хэдийгээр бид энэ түүхийг мэргэн ухааны үг болон бидний *шууд* иддэг хоол хүнсний талаар чухал зарчмыг заахдаа ашигладаг ч гэсэн энэ нь бидний *оюун санаанд* нөлөөлдөг зүйлсийн тухай зарчмыг мөн заадаг. Энэ нь бидний үзвэр

үйлчилгээнд ашиг-ладаг—урлаг, ном зохиол, бүжиг, хөгжим, цахим ба олон нийтийн мэдээллийн хэ-рэгсэл гэх мэт бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэ-рэгслийг багтаасан байдаг. Даниел ба түүний найзууд хааны ордон дахь үйлчлэлээс өөр-сдийгөө хол байл-гах мөн хэрэгтэй шим тэжээлийг нь үл өгөх элбэг

дэлбэг, хүнд хоолноос зайлсхийх шийдвэр гаргасны ади-лаар бид ч бас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс хамгийн сайныг нь эрэлхийлэх ёстой (С ба Г 25:10-ыг үзнэ үү).

Дараах зөвлөгөө нь энэ сорилтын амьдралд бидний үнэт цагийг дэмий үрэхгүй байх үзвэр үйлчилгээг сонго-ход бидэнд тусална.



**Хөнгөн хуумгай байдлаас зайлсхий**

Бид өдөр тутмын ачааллаасаа амсхий-хийн тулд үзвэр үйлчилгээг ашигладаг. Энэ нь амарч, гэр бүлийнхэнтэйгээ болон найзуудтайгаа хөгжилдөж мөн сайхан ярилцах цаг байж болно.<sup>1</sup> Эдгээр үйл ажиллагаанаас ирдэг эрч хүч нь Ариун Сүнсний нөлөөнөөс ирдэг бөгөөд түүний үр жимс нь “хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал юм” (Галат 5:22–23). Алжаал тайлах үйл ажиллагааны дараа эрч хүчийг мэдрэхийн тулд бид өөрсдийг маань Ариун Сүнсний нөлөөнд болон эдгээгч

хүчинд нээлттэй байлгах үзвэр үйлчилгээг сонгох ёстой.

Ариун Сүнсний нөхөрлөлийг алдахаас мөн өөр-сдийнхөө сүнсийг гэмтээхээс зайлсхийж болохын тулд бидэнд “Бүдүүлэг, ёс суртахуунгүй, хүчирхийлэл бүхий болон садар самууныг сурталчилсан аливаа зүйлийг үзэх эсвэл тийм үйл ажиллагаанд оролцох” ёсгүй хэмээн зөвлөсөн байдаг.<sup>2</sup> Гэвч ёс бус агуулгагүй мэт санагдах хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ч мөн зарим тохиол-долд амьдралын зорилгоос анхаарлыг маань сарниулах аюултай байж болно.

Ач тустай үзвэр үйлчилгээ нь бидний зүрх сэтгэлийг хөнгөн болгодог бол бусад төрлийн үзвэр үйлчилгээ нь биднийг хөнгөн хуумгай болгодог. Сургаал ба Гэрээнд Их Эзэн: “Өөрсдийнхөө бүхий л хөнгөмсөг үг яриа-

наас, бүх чанга инээдээс, бүхий л тачаангуй хүс-лүүдээс, бүхий л бардамнал хийгээд хөнгөм-сөг зангаасаа . . . болигтун” (С ба Г 88:21) хэмээн бидэнд зарлигла-даг. Зарим үзвэр үйлчилгээ нь Ар-ванхоёр Төлөө-лөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүксийн дүрс-лэн хэлснээр залуу бодлууд хийгээд дэмий

# АШИГ ТУСТАЙ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

зүйлүүдээр бидний оюун санааг дүүргэж, биднийг авра-лын төлөвлөгөөний зорилгоос холдуулдаг.<sup>3</sup> Иймэрхүү бодлогогүй үзвэр үйлчилгээ нь биднийг урхинд түргэн оруулж, “ариун нандин зүйлүүдийг бохир болгож мөн цаашлаад Бурханыг доромжлоход хүргэдэг зохиомол хүндэтгэл бишрэлгүй байдал” болж хувирдаг.<sup>4</sup>



**Идэвхтэй сонгогч бай**

Хэдийгээр идэвхгүй байснаасаа болоод сонсож, үзэж мөн уншиж буй зүйлээ нягтлахгүйгээр зүрх сэтгэл, оюун санаандаа оруулах нь амархан боловч өөрсдийнхөө төлөө сонгогчид байж, “өөрсөд дээрээ үйлдүүлэх бус харин [өөрсдийн] төлөө үйлдэх”-эд суралцах явдал бол амьдралын амин чухал нэг хэсэг нь юм (2 Нифай 2:26). Жинхэнэ сонгогч болохын нэгээхэн хэсэг нь ашигладаг үзвэр үйлчилгээгээ хянуур сонгох явдал мөн.

Үзвэр үйлчилгээндээ хэвлэл мэдээллийн хэрэгслийг амар ч бодлогогүйгээр оруулахын оронд бид үүнд хэр

их цаг зарцуулж байгаага болон энэ нь ил эсвэл далд байдлаар ямар захиас өгч байгааг мэддэг байх ёстой. Бид “технологийг зорилготой ашиглаж” мөн “үүний бүх үр дагаврыг” сайтар бодож үзэх ёстой гэж Бригам Янгийн Их Сургуулийн цахим мэдээллийн хэрэгслийн группийн захирал Райн Холмэс тайлбарлажээ.<sup>5</sup> Бригам Янгийн Их Сургуулийн театр, дэлгэцийн урлагийн тэнхимийн эрхлэгч Эми Питэрсэн Жэнсэн “идэвхтэй мэдээллийн хэрэгслийн харилцан ярианд оролцохыг сонгож мөн идэвхгүй мэдээллийн хэрэгсэл ашиглахаас зайлсхийх” нь маш чухал гэж хэлсэн юм.<sup>6</sup>



### Цагийг ухаалаг ашигла

Илүү идэвхтэй сонгогч болохын нэг хэсэг нь үзвэр үйлчилгээнд хэр их цаг зарцуулж байгаага мэддэг байх явдал мөн. Сонгож болох маш олон зүйл байдаг учраас “мессеж, э-мэйл, мэдээлэл, бичлэг болон зар зэрэг олон хэлбэрээр ирдэг зүйлүүдэд”<sup>7</sup> цаг зарцуулах нь маш амархан байдаг. Гэвч бид үүнийг хийх үедээ бидэнд илүү хүчтэй, илүү мэргэн мөн Есүс Христийн илүү энэрэнгүй төлөөлөгч болоход тусалдаггүй, цаг гарзасан үйл ажиллагаануудаар “сорилтын өдрүүдээ” (2 Нифай 9:27) дэмий өнгөрөөж байдаг.

Сүүлийн үед хит болж буй бичлэг, шинэ шоу эсвэл хүмүүсийн тавьсан мэдээлэл зэргийг үзэж, цагаа дэмий үрэхийн оронд бид өөрсдийг маань сэргээж, урам өгөх утга учиртай үзвэр үйлчилгээг үзэж сонирхох цагийг өөрсдөдөө зориулан гаргаж болно. Холмэс ах, “Ухаалаг сонголт хий. Та нар цахим зүйл дээр юуг, хэзээ, хэрхэн ашиглахаа өөрсдөө шийд” гэж хэлжээ.<sup>8</sup>



### Урам зориг өгдөг мэдээллийн хэрэгслийг сонго

Үзвэр үйлчилгээгээ анхааралтай хянуур сонгохын бас нэг хэсэг бол илгээж буй захиасуудыг нь мэддэг байх явдал юм.

Бүх төрлийн үзвэр үйлчилгээ нь санаатай эсвэл санамсаргүй байхаас үл хамааран ямар нэг зүйлийг илэрхийлсэн захиас бүхий байдаг. Кино үзэж эсвэл ном уншиж байх үедээ, тухайлбал энэ нь өөрийн бэлэг тэмдэг, дүр, үг, зургуудаар дамжуулан чамд ямар захиас өгч байгааг өөрөөсөө асуугаарай. Үүний эрхэмлэдэг зүйл нь юу юм бол? Энэ ямар зан чанарыг дэмжиж байна вэ? Хамгийн чухал нь, энэ нь та нарт Есүс Христийн тухай бодож мөн Түүнийг хүндэтгэхэд тусалж байна уу? Энэ нь Түүний бурханлаг байдлыг ойлгоход та нарт тусалдаг уу? Мөн энэ нь та нарт золиослолын тухай ямар нэг зүйлийг зааж байна уу? Аль эсвэл хайрын тухай юу? Амин хувиа үл хичээх үзлийн тухай юм бол уу? Энэ нь гэр бүлийн ач холбогдол эсвэл гэрлэлтийн ариун байдлын тухай ямар нэг юм өгүүлдэг үү? Хэрэв та нар үзвэр үйлчилгээнийхээ захиаснаас сайн мэдээтэй холбоотой үнэнүүдийг олж

харахгүй байгаа бол энэ нь үнэ цэнэтэй биш бөгөөд та нарын цагийг дэмий үрж байгаа хэрэг юм.

Зарим хүмүүс “Энэ чинь зүгээр л үзвэр үйлчилгээ болохоос биш сургууль эсвэл сүм биш шүү дээ. Би үүнээс ямар нэг юм сурах хэрэггүй” гэж хэлж магадгүй. Гэхдээ та нар мэдсэн ч, мэдээгүй ч “та нарын уншдаг, сонсдог, хардаг зүйлс та нарт нөлөөлдөг.”<sup>9</sup>

Бид үзэж буй мэдээллийн хэрэгслээ оюун бодол, зүрх сэтгэлдээ үнэлж цэгнэх үед бидэнд эргэцүүлэн бодох мөч олддог. Профессор Жэнсэн эдгээр мөчүүдийг “харилцан яриа” хэмээн нэрлэдэг. “Энэ үеэр бид хийдэг зүйлсээ эргэцүүлж, өөрсөдтэйгөө харилцан ярилцдаг. Бидний хийдэг хамгийн сайн харилцан яриа нь ихэвчлэн хувийн наманчлалын мөч болдог. Учир нь ийм харилцан ярианы үеэр бид бодлоо өөрчлөн, шинэ арга зам олж эсвэл илүү сайн байх шийдвэр гаргадаг. Эдгээр мөчүүдэд бидний бодгаль дотроо хийдэг өөрчлөлтүүд нь ихэвчлэн жижиг, энгийн мөртлөө өсөлттэй, тайвшруулсан мөн бүтээлч үр нөлөө бүхий байдаг.”<sup>10</sup>

Бид чөлөөт цагаараа ч гэсэн “ариун журамтай, сайхан эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай ямар нэгэн зүйлийг” эрэлхийлдэг (Итгэлийн Тунхаг 1:13). Есүс Христийн төлөөлөгчдийн хувьд бид “уншиж эсвэл үздэг бүх зүйлүүд маань . . . ямар нэг сайн зүйлийг зааж, [бидэнд] эсвэл [гэр бүлд] маань ямар нэг сайн зүйлийг бий болгодог байхад анхаарах хэрэгтэй.” Бид үздэг үзвэр үйлчилгээгээ “Тэнгэрлэг Эцэгийн алсын харааг ойлгож мөн хуваалцахад [бидэнд туслах] зорилготой, бүхнээ зориулсан үйлдэл болгох ёстой.”<sup>11</sup>

Ийм ариун журамтай, сайшаалтай үзвэр үйлчилгээ буюу ашиг тустай мэдээллийн хэрэгсэл нь бидэнд урам зориг өгч, биднийг амьдралын бэрхшээлүүдэд бэлтгэж мөн бидний дагалдагч байх чадварыг хүчирхэгжүүлдэг гэдгийг бид мэднэ. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.*

### ЭШЛЭЛҮҮД

1. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” *Лиакхона*, 2010 оны 11-р сар, 129, энд “үр бүтээлтэй үйл ажиллагааг” аз жаргалтай гэр бүлийг байгуулах зарчмуудын нэг нь хэмээн жагсаасан байдаг.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 11.
3. Даллин Х.Өүкс, “Powerful Ideas (Хүчирхэг санаанууд),” *Ensign*, 1995 оны 11-р сар, 27-г үзнэ үү.
4. Брад Вилкоккс, “If We Can Laugh at It, We Can Live with It (Хэрэв бид үүнд инээж байвал үүний дагуу амьдарч чадна),” *Ensign*, 2000 оны 3-р сар, 29.
5. Райн Холмэс, “The Truth of All Things (Бүх зүйлийн үнэн),” (Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт, 2013 оны 5-р сарын 7), [speeches.byu.edu](http://speeches.byu.edu)
6. Эми Питэрсэн Жэнсэн, “Some Hopeful Words on Media and Agency (Хэвэл мэдээллийн хэрэгсэл ба сонгох эрх чөлөөний талаар найдвар төрүүлэх хэдэн үг),” (Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт, 2012 оны 3-р сарын 20), [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).
7. Холмэс, “The Truth of All Things (Бүх зүйлийн үнэн),” [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).
8. Холмэс, “The Truth of All Things (Бүх зүйлийн үнэн),” [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).
9. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 11.
10. Жэнсэн, “Media and Agency (Хэвэл мэдээллийн хэрэгсэл ба сонгох эрх чөлөө),” [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).
11. Жэнсэн, “Media and Agency (Хэвэл мэдээллийн хэрэгсэл ба сонгох эрх чөлөө),” [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).



# Эцэг эх байх нь мөн бүх зүйлээ салгах нь

Жан Пинбороу

Сүмийн сэтгүүлүүд

Аврагч: “Бяцхан үрсээ болгоогтун” гэсэн гурван энгийн үг хэлсэн байдаг. Нифайчууд хүүхдүүд рүүгээ харцаа чиглүүлэв. Үүний дараа болсон явдал нь бүх сударт гардаг хамгийн ариун нандин үйл явдлуудын нэг юм. (3 Нифай 17:23–24-ийг үзнэ үү.)

Би ууган охиноо төрүүлсний дараа “болгоох” гэдэг зүйлийг анх удаа биеэрээ үзсэн юм. Түүний туниа муутай, тасралтгүй уйлах дуу намайг шөнө дундын үед сэрээсэн бөгөөд түүнийг хооллохоор намайг зэхэж байх үед энэ явдал болсон юм. Охин минь нүдээ том гэгч нь нээгээд хэсэг хугацаанд миний нүд рүү эгцээн ширтэв. Охин бид хоёр анх удаа нэг нэгнээ үнэхээр “болгоох” тэр мөчид би бидний хооронд мөнхөд үргэлжлэх харилцааны талаар ямар нэг зүйлийг мэдэрсэн юм.

Нейробиологийн судалгаагаар эцэг эх ба хүүхдийн хоорондоо бие биенээ ширтэлцэж, “болгоохын” чухал ач холбогдлыг баталсан юм. Доктор Аллан Н.Шорын хэлснээр, үггүй харилцааны хэлбэр болох “харилцан ширтэлцэх” нь нялх хүүхдийн уураг тархины зөв хөгжилд зайлшгүй чухал байдаг байна.<sup>1</sup> Хойшид ч энэ харилцаа өсөж буй хүүхдийн оюун ухаан, зүрх сэтгэлд болон сүнсний хөгжилд амин чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ.

“Болгоох” гэдэг нь хайнга, хальтхан, зэрвэс харах явдал биш

юм. Энэ нь хэн нэгэн хүнтэй зүрх сэтгэл болон оюун санаагаараа хамт байх явдал мөн. Энэ нь “Би чамайгаа харж байна. Чи бол миний хувьд хамгаас чухал” гэх төвлөрсөн анхаарал юм.

Өнөөгийн эцэг эхчүүдийн хувьд энэ төрлийн болгоох үйлдэл нь тэднийг зурагтныхаа дэлгэцээс холдож мөн бусад электрон хэрэгслүүдээ зориудаар салгахыг олонтоо шаарддаг. Үүний тулд бид утасныхаа мессэжийг эсвэл фэйсбүкийнхээ постуудыг харах гэсэн уруу таталтыг эсэргүүцэх хэрэгтэй болж магадгүй. Энэ нь мэдээллийн хэрэгсэл ашиглах сайтар бодож боловсруулсан хувийн болон гэр бүлийн дүрмийг бий болгох, өдөр бүр гэр бүлдээ мөн бие биедээ зориулдаг ариун нандин цагийг хамгаалах хил хязгааруудыг тогтоох зэрэг үйлдлүүдийг шаардаж болно.

Бид бяцхан үрсээ илүү бүрэн дүүрнээр мөн илүү ойр ойрхон болгоохыг хичээснээрээ хүүхдүүдийнхээ өөрийгөө үнэлэх үнэлэмжийг сайжруулж, бие биетэйгээ харьцах харилцаа холбоогоо баяжуулан, хүүхдүүдийнхээ зүрх сэтгэл рүү өнгийж харах тэдгээр ариун нандин мөчүүдтэй илүү ихээр учрах болно. ■

## ЭШЛЭЛҮҮД

1. “Relational trauma and the developing right brain: The neurobiology of broken attachment bonds (Баруун тархийг хөгжүүлэх нь ба хамаарал бүхий гэмтэл: Салангид хэлхээ холбооны нейробиолог),” in Tessa Baradon, ed., *Relational Trauma in Infancy* (2010), 19–47-г үзнэ үү.



## БҮХ ЗҮЙЛСЭЭ УНТРАА, ТЭГЭЭД ХАЙРААР СОНС

“Хүүхдүүдийнхээ хэрэгцээг олж мэдэх бидний залбирлын хариулт нь электрон хэрэгсэл ашиглахаа багасгах явдал байж болох юм. Бидний хүүхдүүдтэйгээ харилцаа холбоо тогтоож, харилцан ярилцах боломжийг олгодог үнэт цаг хугацаа маань бид анхаарал сарниулагч зүйлүүдэд анхаарлаа хандуулах үед алдагддаг. Бид яагаад өдөр бүр тодорхой хугацаанд электрон хэрэгслүүдээ унтрааж, нэг нэгэнтэйгээ харилцах цаг гаргаж болохгүй гэж? Зүгээр л бүх электрон хэрэгслээ унтраачих. Таныг ингэх үед эхэндээ гэр тань нам гүм болсон мэт санагдаж магадгүй. Та юу хийж, юу хэлэх хэрэгтэйгээ мэдэхгүй байгаа мэт санагдаж болно. Дараа нь та хүүхдүүддээ анхаарлаа бүрэн хандуулсны дараа харилцан яриа эхлэх бөгөөд бие биенээ сонсож байгаа чинь та нарт таалагдах болно.”

Рөүзмэри М.Виксом, Хүүхдийн хэсгийн ерөнхий ерөнхийлөгч, “Бидний хэлдэг үгс,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 82.



**Линда К.Бертон**  
Халамжийн  
Нийгэмлэгийн  
ерөнхий ерөнхийлөгч

# САНВААРЫН ХҮЧ ЧАДАЛ



## БҮГДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ

*Санваарын эрх мэдэл нь томилгоогоор өгөгддөг  
ч санваарын хүч чадал нь бүх хүнд хүртээмжтэй.  
Бидний хүн нэг бүр санваарын хүч чадлыг амьдралдаа  
урих түлхүүр нь зөв шударга байдал юм.*

**С**анваарын талаар илүү олон хүн асууж, тодруулж байгаа сүмийн түүхийн энэ онцгой үед амьдарч байгаа нь бидний хувьд онцгой боломж юм. Бурханы санваартай холбоотой эрх мэдэл, хүч чадал, адислалуудын талаар илүү сайн ойлгох сонирхол ба хүсэл хүмүүст маш их байна. Санваарын номлол “тэнгэрээс буух

шүүдэр лугаа адил [бидний сүнсэн] дээр *намуухан* буух болно” хэмээн би найдаж байгаа (С ба Г 121:45; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн). Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулж байгаа гэдгийг би гэрчилж байна. Их Эзэн Өөрийн ажлыг хэрхэн гүйцэлдүүлдгийг ойлгох нь бидний хувьд туйлын чухал бөгөөд ингэснээр бид Түүний төлөвлөгөө болон

зорилгуудын төлөө ажиллахаас ирдэг хүч чадлыг хүлээн авч чадна. Их Эзэн “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Моисе 1:39) Өөрийн ажлыг үргэлж Өөрийн санваарын хүчээр гүйцэлдүүлсээр ирсэн. Үүгээр тэнгэр болон газар бүтээгдсэн юм. Есүс Христийн Цагаатгал байгаа учраас бид уналтын үр дагавруудыг





санваарын ёслолуудаар дамжуулан даван туулж чадна. Санваарын эрх мэдэл нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг адислахын тулд хүмүүнд өгөгдсөн учраас Тэрээр биднийг хувийн амьдрал болон гэр бүлдүүдээ хүчирхэгжүүлэхийн тулд санваарын хүч чадлыг өөрсдийнхөө гэр оронд авчраасай хэмээн хүсдэг.

2013 оны дэлхий даяарх удирдагчдын сургалт дээр Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс “Эрэгтэй хүмүүс бол санваар биш!” хэмээн онцлон мэдэгдсэн.<sup>1</sup> Энэ үг миний хувьд ухаарал өгсөн үг байсан бөгөөд бид бүгдийн хувьд санваарын талаар илүү сайн судалж, тунгаан бодож мөн ойлгох урилга байсан юм. Өөр итгэл бишрэлтэй та нарын хүүхэд эсвэл найз тань дараах асуултуудыг асуувал та нар хариулт өгч чадах байсан уу?

- Санваар гэж юу вэ?
- Санваар яагаад тийм чухал байдаг вэ?
- Санваарын түлхүүрүүд гэж юу вэ?
- Санваарын түлхүүрүүдийг хэн атгадаг вэ?

### Санваар гэж юу вэ?

Санваар бол Бурханы мөнхийн хүч ба эрх мэдэл бөгөөд Тэр үүгээр дамжуулан Өөрийн хүүхдүүдийг адисалж, гэтэлгэж мөн өргөмжилдөг. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар санваарын талаар: “Санваар бол Их Эзэн бодгалиудыг аврахын тулд эрэгтэйчүүдээр дамжуулан ажилаадаг зүйл юм. . . . Санваарыг атгагч нь энэ ариун нандин эрх мэдлийг Бурханы ариун оюун, хүсэл болон зорилгуудтай нийцүүлэн ашиглах үүрэгтэй. *Санваартай холбоотой нэг ч зүйл өөр дээрээ төвлөрсөн байдаггүй. Санваар нь үргэлж бусад хүмүүст*

“Санваартай холбоотой нэг ч зүйл өөр дээрээ төвлөрсөн байдаггүй. Санваар нь үргэлж бусад хүмүүст үйлчилж, адисалж мөн тэднийг хүчирхэгжүүлэхэд ашиглагддаг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар



*үйлчилж, адисалж мөн тэднийг хүчирхэгжүүлэхэд ашиглагддаг”* хэмээн тайлбарласан юм.<sup>2</sup>

Намайг санваарын талаар ойлгохын тулд судалж, тунгаан бодож мөн эрэлхийлэх үед дэлхий дээр санваар *байхгүй* бол ямар байх байсан бол гэдэг бодол минь их тус дөхөм болж байсан. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс энэ санааг “Хэрэв ямар ч санваар байхгүй байсан бол мөнх бус амьдрал нь ямар харанхуй мөн ямар их хоосон байх байсныг та нар төсөөлж чадах уу? Хэрэв санваарын хүч дэлхий дээр байхгүй байсан бол чөтгөр ямар ч саадгүйгээр хэрэн хэсэж мөн захирах байсан. Тэр үед биднийг удирдаж мөн гэгээрүүлэх Ариун Сүнсний бэлэг ч,

Их Эзэний нэрээр ярих бошиглогчид ч, ариун нандин мөнхийн гэрээнүүдийг хийх ариун сүмүүд ч мөн адислах эсвэл баптисм хүртээх, эдгээх эсвэл тайтгаруулах эрх мэдэл ч байхгүй байх болно. . . . Ямар ч гэрэл, найдвар байхгүй зөвхөн

харанхуй байх болно” хэмээн илэрхийлсэн юм.<sup>3</sup>

Санваар байхгүй байсан бол гэдэг бодол нэгийг бодогдуулдаг. Энэ ариун нандин хүч энэ цаг хугацааны бүрэн байдлын эцсийн ба алдар суут эрин үед Бурханы бошиглогчоор дамжуулан дэлхий дээр сэрэгэгдсэнд би бүх чадлаараа баясдаг!

Биднийг санваарын тухай ярихад ахлагч Өүкс: “Заримдаа бид санваар атгагчдыг ‘санваар’ хэмээн хэлдэг боловч санваар атгагчид нь санваарыг эзэмшдэггүй мөн тэд санваар биш гэдгийг бид хэзээ ч мартаж өгсгүй. Энэ нь *эрэгтэй, эмэгтэй хүмүүс ба хүүхдүүдэд адил тэгш ашиг тус хүргэх ариун нандин итгэл дээр* үндэслэгдэн олгогддог” гэж анхааруулдаг.<sup>4</sup>



## Санваар яагаад тийм чухал байдаг вэ?

“Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоог мөнхжүүлдэг. Ариун сүмийн ёслолууд болон гэрээнүүд нь хувь хүн Бурханы оршихуйд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжийг олгодог” гэдгийг бид мэднэ.<sup>5</sup> Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэл М.Нэлсоны заасанчлан “Гэр бүлүүд мөнхөд лацдан холбогдож болохын тулд санваарын эрх мэдэл сэргээгдсэн юм.”<sup>6</sup>

“Сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэхэд санваарын эрх мэдэл шаардлагатай. . . . Ёслол бүр нь арвин баялаг адислалын үүд хаалгыг нээдэг.”<sup>7</sup> Есүс хаант улсын ариун нандин түлхүүрүүдийг “Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно” гэсэн үүрэг хариуцлагатайгаар Петрт олгосон юм (Матай 16:19).

## Санваарын түлхүүрүүд гэж юу вэ?

Санваарын түлхүүрүүдийн талаарх энгийн тайлбар 2012 оны 5-р сарын *New Era* сэтгүүлд нийтлэгдсэн байдаг:

“Түлхүүрүүдийг байшинд орох, автомашин жолоодох, чемодан онгойлгох гэх мэт түлхүүргүйгээр хийх боломжгүй олон зүйлд ашиглаж болдог. Нэг үгээр хэлбэл түлхүүрүүд нь эрх мэдэл ба нэвтрэх эрх юм.

“Санваарын түлхүүрүүд нь үүнтэй мөн адил юм. Тэдгээр нь санваарын адислал болон ёслолуудад нэвтрэх явдлыг хянаж байдаг. . . . Санваарын түлхүүрүүд нь сүмийг тэргүүлж мөн удирдах эрх юм. . . . Түлхүүрүүд нь ихэвчлэн газарзүйн бүсийн хувьд буюу тойрог, гадаст эсвэл номлолд хамаатай байдаг. Тэдгээр нь бас ямар нэг тодорхой ёслол ба үйл

ажиллагааг захирах эрх мэдлийг агуулдаг (жишээ нь: баптисм, ариун ёслол, номлогчийн болон ариун сүмийн ажил гэх мэт).”<sup>8</sup>

## Санваарын түлхүүрүүдийг хэн атгадаг вэ?

“Есүс Христ Өөрийн сүмд хамаатай санваарын бүх түлхүүрийг эзэмшдэг. Тэрээр дэлхий дээр Бурханы хаант улсад хамаатай бүх түлхүүрийг төлөөлөгч бүрдээ олгосон юм. Хамгийн ахмад, амьд сэрүүн төлөөлөгч бол сүмийн ерөнхийлөгч бөгөөд тэрээр санваарын бүх түлхүүрийг ашиглах эрх мэдэл бүхий дэлхий дээрх цорын ганц хүн юм (С ба Г 107:91–92-ыг үзнэ үү). . . . [Тэрээр] санваарын түлхүүрүүдийг санваартны бусад удирдагчдад хариуцсан бүсүүдийг нь тэргүүлүүлэхээр олгодог. . . . Туслах бүлгүүдийн ерөнхийлөгч болон тэдний зөвлөхүүд түлхүүрүүдийг хүлээн авдаггүй. Тэд дуудлагадаа тохирсон эрх мэдлийг хүлээн авдаг.”<sup>9</sup>

Гэхдээ санваарын эрх мэдэл, санваарын хүч чадал хоёрын хооронд ялгаа бий. Санваарын эрх мэдэл нь гагцхүү томилгоогоор дамжин өгөгддөг бол харин санваарын хүч чадал нь бүх хүмүүст боломжтой юм. Бид бүгд санваарын хүч чадлыг өөрсдийн гэр бүлд болон орон гэртээ байлгахыг хүсдэг учраас *бид* энэ хүчийг амьдралдаа урьж оруулахын тулд юу хийх хэрэгтэй вэ? Санваарын хүч чадлыг олж авахад хувийн зөв шударга байдал нь туйлын чухал юм.

## Санваарын сургаалыг ойлгох нь

Нэгдүгээрт, Ариун Сүнсний бэлэг хүлээн авахуйц зохистой байхыг эрэлхийл. Санваарын сургаал нь илчлэлтээр хамгийн сайн ойлгогддог учраас энэ сургаалыг бидэнд илчилж мөн бидний бодгаль дээр намуухан буух Ариун Сүнсний тусламжийг авах нь амин чухал юм.

Хоёрдугаарт, ариун сүмд ордог бай. Ариун сүмүүд нь “шүтээний бүх газраас хамгийн ариун нь”<sup>10</sup> бөгөөд илчлэлтийн сүнсээр дамжуулан санваарын талаар суралцах хамгийн шилдэг газар гэдгийг бид мэддэг.

Гуравдугаарт, судруудыг судал.



Судруудыг эрж хайн, тунгаан бодож, судлах нь бидэнд санваарын тухай чухал үнэнүүдийг илчлэх Ариун Сүнсийг урьдаг. Би та нарт дараах судруудыг залбирч мөн анхааралтай судалж үзэхийг санал болгож байна: Сургаал ба Гэрээ 13, 20, 84, 107, 121-р хэсгүүд мөн Алма 13. Дараа нь би та нарыг Сургаал ба Гэрээ 84:33–40 дээр гардаг санваарын андгай ба тангаргийг цээжлэхэд урьж байна. Үүнийг хийвэл Ариун Сүнс санваарын талаарх ойлголтыг тань тэлж мөн гайхамшигтай арга замуудаар та нарт илчлэлт өгч, та нарыг өргөх болно гэдгийг амлаж байна.

Мөн би та нарыг Сургаал ба Гэрээ 121:34–44-г тунгаан бодож мөн өөрсдөдөө доорхтой төстэй асуулуудыг тавихад урьж байна:

- Миний зүрх сэтгэл энэ дэлхийн зүйлүүд дээр тавигдсан байна уу?
- Би хүмүүсээс хүндэтгэл хүлээхийг эрмэлздэг үү?
- Би нүглээ далдлахыг оролддог уу?



- Би бардамнадаг уу?
- Би өөрийнхөө хүүхдүүдийг, эхнэрээ эсвэл бусдыг хянаж, эзэгнэж эсвэл албаддаг уу?
- Би сэнхрүүлэл, номхон дөлгөөн байдал, тэсвэр тэвчээр, нинжин сэтгэл, эелдэг зөөлөн байдал, чин сэтгэлийн хайр (жинхэнэ эсвэл зүрх сэтгэлийн хайр гэсэн утгатай) зэрэг зөв шударга зарчмуудыг хөгжүүлэхийн тулд шаргуу хичээдэг үү?
- Бодол санааг минь ариун журам зогсолтгүй чимэн гоёдог уу?
- Би Ариун Сүнснийг өөрийнхөө байнгын хамтрагч байлгахыг хүсдэг үү?

Би олон жилийн өмнө ааваасаа адислал авахыг хүссэн бөгөөд үүнийгээ эргэн санах үед

*сэнхрүүлэл, номхон дөлгөөн, тэсвэр тэвчээр, нинжин сэтгэл, эелдэг зөөлөн болон чин сэтгэлийн хайр* зэрэг үгс нь миний хувьд шинэ бөгөөд маш дотно утга учиртай болсон юм.

Би залуу насанд хүрэгч байхдаа нэгэн хэцүү шийдвэр гаргах тал дээр нэлээн эргэлзэж байлаа. Би өмнөх шигээ аавдаа хандаж, түүнээс эцгийн адислал авахыг хүслээ. Түүнийг миний хүсэлтэд хариулж тэр дороо адислал өгнө гэж бодсон боловч “чамд адислал өгөхийн тулд өөрийгөө бэлтгэх хугацаа надад хэрэгтэй байна. Чи хоёр өдөр хүлээвэл зүгээр үү?” гэж хэлэхэд нь би гайхаж билээ.

Сонирхолтой нь, 40 жилийн хойно би аав минь надад эцгийн адислал өгөхдөө юу гэж хэлснийг мартсан байсан ч аавыгаа өөрт буй санваарыг ихэд хүндэтгэж мөн надад эцгийн адислал өгөхийн тулд өөрийгөө сүнслэгээр бэлтгэж байсныг би хэзээ ч мартажгүй. Аав минь Сургаал ба Гэрээ 121-р хэсэгт гардаг зарчмуудыг ойлгодог байсан бөгөөд өөрийн гэр бүлийг адислах санваарын хүчийг авахуйц зохистой байхын тулд тэдгээр зарчмуудаар амьдрах шийдвэр төгс байсан юм.

### **Амьд бошиглогчдын үгс**

Өдөр бүр илчлэлт авдаг бошиглогч, үзмэрч, илчлэгчидтэй хамт үйлчлэх нь миний хувьд онцгой боломж мөн. Хэрэв бид санваарын сургаалыг үнэхээр ойлгохыг хүсэх юм бол бидэнд итгэлтэй бөгөөд Бурханаас өгөгдсөн амьд эх сурвалжууд болох бошиглогч, илчлэгч, үзмэрчид байдаг. Тэд бол хувийн зөв шударга байдлаараа дамжуулан санваарыг атгаж буй Бурханы эрс гэдгийг би гэрчилж байна.

Саяхан болсон Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн

чуулгын ахлагч М. Рассэлл Баллард: “Тэнгэрлэг Эцэгийн маань санваараар адислагдсан агуу төлөвлөгөөнд санваарыг ашиглах онцгой үүрэг хариуцлага эрчүүдэд өгөгдсөн ч тэд өөрсдөө санваар биш юм аа. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөр өөр үүрэгтэй боловч эдгээр нь адил үнэ цэнэтэй байдаг. Эмэгтэй хүн эр хүнгүйгээр үр хүүхэдтэй болж чадахгүйтэй адил эрэгтэйчүүд эмэгтэй хүнгүйгээр мөнхийн гэр бүлтэй болоход санваарын хүчээ бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй. Өөрөөр хэлбэл, мөнхийн талаас нь авч үзэхэд хүүхэд төрүүлэх хүч болон санваарын хүчийг эхнэр нөхөр хоёр хуваалцдаг” хэмээн заасан.<sup>11</sup>

Эмэгтэйчүүдийн ёс суртахууны нөлөө нь санваарын хүч чадлыг дэмжигч бэлэг гэдгийг би ойлгож эхэлж байна. Ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–1995) сүмийн эмэгтэйчүүдийг “Бид та нарыг өөрсдийн хүчирхэг сайн *нөлөөгөөр* бидний гэр бүлүүдийг болон сүм ба нийгмийг хүчирхэгжүүлэхийн төлөө тохинуулахад уриалж байна” хэмээн уриалсан.<sup>12</sup> Саяхан болсон Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Д. Тодд Кристоффэрсон эмэгтэйчүүдэд хандан, “Та нар ганц бие эсвэл гэрлэсэн, хүүхэд төрүүлсэн эсвэл төрүүлээгүй ч бай мөн та нар хөгшин, залуу эсвэл энэ хоёрын дунд байсан ч хамаагүй, та нарын ёс суртахууны хүч бол амин чухал юм” хэмээн хэлсэн билээ.<sup>13</sup>

Ахлагч Баллард мөн үүнтэй төстэй зүйлийг: “Энэ дэлхий дээр зөв шударга эмэгтэй хүний *нөлөөнөөс* илүү хувийн, илүү хайраар тэтгэгч эсвэл амьдралыг илүү өөрчлөгч зүйл гэж байхгүй” хэмээн хэлсэн байдаг.<sup>14</sup>

Бид Бурханы ариун санваартай холбоотой хэдэн асуултын талаар



ярилцлаа. Гэхдээ өөр олон асуулт байгаа нь тодорхой.

### Эхлээд дуулгавартай дага, дараа нь ойлгож ав

Хариулт байхгүй асуултуудтай зохицож амьдрахад надад тусалсан нэгэн туршлагаар би үгээ өндөрлөө. Хэдэн жилийн өмнө нөхөр, бид хоёр сүмийн туршлагатай олон удирдагч цугласан цугларалтад уригдсан юм. Шинэ тэргүүлэх эрх мэдэлтэн нь дуудагдаад удаагүй байсан бөгөөд хурлын төгсгөлд маш хүнд бөгөөд маргаан дэгдээхүйц асуултыг нэг хүн асуулаа. Уг асуулт маш хэцүү асуулт байсан учраас нөхөр, бид хоёр энэ шинэ удирдагчийн төлөө Тэнгэрлэг Эцэгтэй хандан чин сэтгэлээсээ залбирч билээ. Тэрээр асуултад хариулахаар индэр дээр гарч ирээд сүр жавхлантай, мөр цэх байж мөн Их Эзэний хүч чадлаар ярих үед түүний дүр төрх өөрчлөгдсөн байхыг би харсан юм.

Тэрээр: “Ах минь, би таны асуултын хариулт юу болохыг мэдэхгүй. Гэхдээ би танд юу мэддэгээ хэлье. Бурхан бол бидний Мөнхийн Эцэг гэдгийг би мэднэ. Есүс Христ бол дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч гэдгийг би мэднэ. Иосеф Смит Бурхан Эцэг болон Түүний Хайртай Хүү Есүс Христийг харсан ба дэлхий дээр санваарын хүч чадлыг сэргээх зэмсэг байсан гэдгийг би мэднэ. Мормоны Ном үнэн бөгөөд Есүс Христийн сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг гэдгийг би мэднэ. Өнөөдөр бидний амьдралыг адислахын тулд Их Эзэний өмнөөс ярьдаг амьд бошиглогч байгаа гэдгийг би мэднэ. Би таны асуултын хариултыг мэдэхгүй ч би эдгээр зүйлүүдийг мэднэ. Бусад зүйлүүдэд би итгэлээрээ ханддаг. Би ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн эхнэр Маржори Хинклигийн

Бурханы санваар нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг болон хүүхдүүдийг адисалж, биднийг гэр бүлээрээ Бурханы оршихуйд мөнхөд хамт амьдруулахын тулд өгөгдсөн ариун нандин зүйл юм.



хэлсэн ‘эхлээд дуулгавартай дага, дараа нь ойлгож ав’ гэсэн энгийн үгсийн дагуу амьдрахыг хичээдэг” гэж хариулж билээ.

Санваар нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг болон хүүхдүүдийг адисалж, биднийг гэр бүлээрээ Бурханы оршихуйд мөнхөд хамтдаа амьдруулахын тулд өгөгдсөн ариун нандин зүйл юм. Бидний хүн нэг бүр санваарын хүчийг амьдралдаа урих түлхүүр нь зөв шударга байдал юм. Энэ сургаал бидний бодгаль дээр намуухан бууж, энэ сүмийг мөн санваарын хүч чадал болон эрх мэдлийг эзэмшдэг Түүнтэй биднийг илүү ойртуулах болтугай. ■

2013 оны 5-р сарын 2-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон эмэгтэйчүүдийн чуулган дээр хэлсэн үгсээс авав.

### ЭШЛЭЛҮҮД

1. Даллин Х.Өүкс, “Гэр бүл дэх санваарын хүч” (дэлхий даяарх удирдагчдын сургалт); [wwlt.lds.org](http://wwlt.lds.org).
2. Дэвид А.Бэднар, “Тэнгэрийн хүчнүүд,” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 48; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
3. Роберт Д.Хэйлс, “Санваарын адислалууд,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 32.
4. Даллин Х.Өүкс “Халамжийн Нийгэмлэг ба сүм,” *Ensign*, 1992 оны 5-р сар, 36.
5. “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг” *Лиакхона* 2010 оны 11-р сар, 129.
6. Рассэлл М.Нэлсон, “Nurturing Marriage (Гэрлэлтийг тордох нь),” *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 37.
7. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 2.1.2.
8. “Санваарын түлхүүрүүд,” *New Era*, 2012 оны 5-р сар, 38.
9. *Гарын авлага 2*, 2.1.1.
10. Судруудын удирдамж, “Ариун сүм, Их Эзэний өргөө”; [scriptures.lds.org](http://scriptures.lds.org).
11. М. Рассэлл Баллард, “Энэ нь Миний ажил болон алдар суу бөлгөө,” *Лиакхона*, 2013 оны 5-р сар, 19.
12. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society (Миний хаант улсын охид: Халамжийн Нийгэмлэгийн түүх ба ажил)* (2011), 157; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
13. Д. Тодд Кристоффэрсон, “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч,” *Лиакхона*, 2013 оны 11-р сар, 30.
14. *Daughters in My Kingdom (Миний хаант улсын охид)*, 156; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.





# Итали

## ДАХЬ ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮД ИТГЭЛИЙН ӨВ

**Лиa Маккланахан**

Итали дахь сүмийн түүх Шинэ Гэрээний үеэс, Ромын эзэнт гүрний нийслэл нь итгэлтэй хэсэг бүлэг Христийн шашинтнуудын гэр байх тэр үеэс эхэлсэн. Библи дээр Ромд сургаалыг анх хэн авчирсан талаар бичигдээгүй байдаг боловч М.Э 57 онд төлөөлөгч Паул ромчууд руу захидал илгээх үед (Ром 15:23) сүмийн салбар тэнд олон жилийн турш байжээ.

Ром дахь Христэд итгэгчдийг “аливаа сайн сайхнаар дүүрэн” (15:14) гэж Паул дүрсэлжээ. Тэрээр тэдний заримтай нь танил байсан ба түүний захидал нь мэнд хүргэсэн хайрт гэгээнтнүүдийн урт жагсаалтыг агуулдаг (16:1–15-ыг үзнэ үү).

Паул тэдгээр Христэд итгэгчдийн итгэлийг магтаж, тэдний төлөө үргэлж залбирдаг тухайгаа тэдэнд хэлсэн. Тэрээр тэдэнтэй уулзахыг хүсэж, Бурханы хүслээр удахгүй тэдэн дээр очно гэж найддаг байсан юм (1:8–15-ыг үзнэ үү).

Ромд хамгийн сүүлд ирэхдээ Паул шоронд байсан. Гэвч сүмийн гишүүд түүний ирэхийг хүлээж байсан ба түүнтэй Аппиу Форум гэдэг газар уулзахаар ах дүүсийн зарим нь 43 бээр (69 км) газар аялсан байв. Паул тэднийг хараад “Бурханд талархаж зориг оров” (Үйлс 28:15).

Хожим нь Ниро болон бусад хаад Христэд итгэгчдийг ихэд хавчиж байсан Ромд Паул алуулсан билээ. Аажимдаа сүм урвалтад орсон боловч эртний Ромын гэгээнтнүүд итгэлийнхээ өвийг эзэнт гүрнийхээ төвд нь үлдээсэн юм. Тэд Христийн шашныг дэлхий даяар түгээх алхмыг тавьсан.





Италийн Ром зүүн гадасны өсвөр үеийнхэн орон гэргүй хүмүүст зориулсан асрамжийн байр засаж мөн будахад туслав

*\*МЭӨ 63: Ромын цэргийн удирдагч Помпеиус Иерусалимыг эзэлж, энэ нь Ромын эзэнт гүрний хэсэг болов.*

*МЭ 45: Ромын иргэн, Төлөөлөгч Паул Ромын эзэнт гүрэн даяарх анхны номлогчийн аялалыг эхлүүлэв.*

*64: Христийн шашинтнууд Ромд гарсан гал түймэрт буруутгагдаж мөн Ромын засгийн газарт хавчигдан дарлагдав.*



*◀ 313: Константин Христийн шашинтай Ромын анхны эзэн хаан болж, Христийн шашныг шүтэх явдлыг хуульчлав.*

*380: Эзэн хаан Теодосиус I Христийн шашныг Ромын эзэнт гүрний албан ёсны төрийн шашин болгож, Христийн шашныг дэлхий даяар дэлгэрүүлэх замын эхлэлийг тавив.*

## Их Эзэний нуусан хүмүүс

1849 онд Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Лорэнзо Снөү (1814–1901) Италид номлол байгуулахаар дуудагдсан юм. Тэрээр уг ажлаа хаанаас эхлүүлэхийг эргэцүүлэн байх үедээ Италийн баруун хойд зүгийн нутагт орших Пиедмонт уулсаар нутагладаг валденчууд гэдэг шашны бүлэг хүмүүсийн талаар мэдэж авчээ.

Валденчууд нь өөрсдийн итгэл бишрэлээс болж үүссэн хэрцгий хавчлага шахалтыг долоон зууны турш тэсвэрлэж иржээ. Протестант шинэчлэлээс хэдэн зууны өмнө тэд Христийн эртний сүм урвалтад орсон хэмээн номлодог байв. Тэд өөрсдийгөө Ромын католик сүмээс тусгаарлан, тэрс үзэлтнүүд хэмээн дуудуулж, хотуудаас хөөгдөн, тамлагдаж мөн устгагдаж байв. Өөрсдийн итгэлийг үгүйсгэхийн оронд тэд уулс руу зугтжээ.<sup>1</sup>

“Намайг валденчуудын талаар бодох үед асар их гэрэл миний оюунд цацрах шиг болсон” хэмээн ахлагч Снөү тэмдэглэсэн байдаг. Тэрээр гэртээ бичсэн захидалдаа “Их Эзэн Алшийн уулс дунд хэсэг хүмүүсийг нуусан гэдэгт би итгэдэг” хэмээн өгүүлжээ.<sup>2</sup>

Италийн өөр бүс нутгууд дахь хууль тогтоомж номлогчийн ажилд төдийлөн дэмжлэг болдоггүй байлаа. Гэхдээ л ахлагч Снөүт ирэхээс хоёр жилийн өмнө Пиедмонт бүс дэх валденчууд хэдэн зууны турш үргэлжилсэн хавчлагын эцэст шашны эрх чөлөөтэй болсон байлаа.<sup>3</sup> Үүгээр ч зогсохгүй, тэдний дундаас хэд хэдэн хүн гайхалтай зүүд болон үзэгдэл харсан бөгөөд номлогчдын захиасыг хүлээж авахад бэлтгэгдсэн байжээ.<sup>4</sup>

1850 оны 9-р сарын 19-нд ахлагч Снөү хоёр номлогч хамтрагчтайгаа сайн мэдээг номлохын төлөө Италийг онцгойлон адисалжээ. Ахлагч Снөү “Тэр өдрөөс хойш бидэнд захиасаа хуваалцах боломжууд гарч эхэлсэн” хэмээн тэмдэглэсэн байна.<sup>5</sup>

Дараагийн дөрвөн жилд номлогчдын хүчин чармайлт амжилт болон эсэргүүцэлтэй тулгарсан юм. Тэд номлогчийн хоёр гарын авлагыг болон Мормоны Номын итали орчуулгыг хэвлэн гаргасан байв. Тэд тодорхой тооны хөрвөгчдөд баптисм хүртээжээ. Гэвч 1854 онд ажил үйлс доройтож, номлогчид өөр газрууд руу дуудагдан, үнэнч тууштай хөрвөгчид нь Юта руу цагаачилж, хавчлага улам бүр өсөн нэмэгдсээр байв. 1862 онд гадуур номлох

*\*Эртний огноонууд нь ойролцоогоор бичигдэв.*



номлолын бүхий л ажил зогссон бөгөөд 1867 онд номлол хаагдсан юм.

Италийн номлол зөвхөн 12 жилийн турш идэвхтэй байсан бөгөөд энэ хугацаанд 12 гэр бүл, 7 хүн хөрвөгдөж, Юта руу цагаачилсан байна. Сайн мэдээг хүлээн авсан валденчууд Юта дахь сүмийг хүч чадлаар сэлбэсэн бөгөөд өнөөдөр мянга мянган гишүүдийн үр удам Роки Маунтинс (Rocky Mountains) хэмээх газрын хожмын үеийн гэгээнтнүүдтэй нэгдэхийн төлөө өвөг дээдсийнхээ нутгийг орхисон итгэлтэй 72 валдентай холбогдог.<sup>6</sup>

### Ажлыг яаравчлуулах нь

Италийн номлол хаагдсаны дараа Италид зуу орчим жилийн турш албан ёсны номлогчийн ажил хийгдээгүй юм. Дэлхийн II дайны дундуур сайн мэдээний гэрэл Италид дахин гэрэлтэж эхэлсэн бөгөөд Нэгдсэн Улсаас

(1899–1994) сайн мэдээг номлоход зориулан Италийг онцгойлон адислах залбирлыг хэлжээ.

Номлол нээгдсэнээс арван жилийн дараа Итали дахь гишүүдийн тоо 300-аас 5 000 болон өссөн байна. 1982 он гэхэд энэ тоо хоёр дахин нэмэгджээ. Ойрын жилүүдэд маш хурдацтай өсөж байна. 2005–2010 оны хооронд дөрвөн шинэ гадас байгуулагдаж, нийтдээ долоон гадастай болжээ. Өнөөдөр Италид 25 000 орчим хожмын үеийн гэгээнтэн байна.

### Сүмийг зохион байгуулах нь

Далын ахлагч Крэйг А. Кардон бол 1854 онд Юта руу цагаачилсан валден хөрвөгч Филипэ Кардоны үр удам болох мянга мянган итали хожмын үеийн гэгээнтний нэг юм. Ахлагч Кардон 1960-аад онд шинэхэн нээгдсэн Итали номлолд залуу номлогч байж

► 1173: Францын Лионы Валдо нь Христ болон Түүний төлөөлөгчдийн заасан анхны сайн мэдээнд буцаж очих хөдөлгөөнийг эхлүүлэв.



1215: Валдо болон түүнийг дагагчид мөн өнөөдөр—Италид зарим нь амьдардаг—валденчууд тэрс үзэлтнүүд хэмээн нэрлэгдээс мөн хавчигдан гадуурхагдав.

1843: Жизетте (Жозеф) Торонто—АНУ-ын Массачусеттс баптисм хүртэж, сүмд нэгдсэн анхны итали хүн болов.

1848: Пиемонт Сардины хаан Карло Алберто валденчуудад шашны эрх чөлөө олгов.



◀ 1850: Ахлагч Лорензо Сноу ахлагч Жозеф Торонто болон В. Х. Стэнхаустай хамт Италид номлогчийн ажлыг эхлүүлэв.

1852: Мормоны Номын итали орчуулга хэвлэгдэв.

ирсэн хожмын үеийн гэгээнтэн цэргийн албан хаагчид Италийн хотуудад байрлах үеэс энэ нь эхэлжээ. Эдгээр гишүүд ням гаргийн цуглаанд оролцох бүлгүүдийг үүсгэсэн ба эдгээр бүлгүүд нь дайны дараа тухайн гишүүд Итали дахь цэргийн баазуудад хуваарилагдах үед идэвхтэй хэвээр байсан байна.

Дараагийн 20 жилд Их Эзэн Өөрийн ажлыг яаравчлуулсан юм. Уугуул италичууд зэргэлдээх орнуудад номлогчидтой уулзсаныхаа дараа сүмд нэгдэж эхлэв. Нэйпэлс ба Верона дахь цэргийн албан хаагч гишүүдийн бүлгүүд нь Швейцари номлолын удирдлага дор салбарууд болон зохион байгуулагдсан байна. Уг номлол Мормоны Номыг итали хэлнээ дахин орчуулж мөн хэвлэн гаргажээ. Итали руу номлогчдыг илгээх хугацаа ойртсоор байлаа.

1964 онд Итали улс Швейцари номлолын нэгэн дүүрэг болон зохион байгуулагдсан бөгөөд удалгүй итали хэлтэй номлогчид хэд хэдэн хот руу илгээгдсэн байна. 1966 онд, анхны номлол хаагдсанаас хойш 99 жилийн дараа Италийн номлол зохион байгуулагджээ. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Эзра Тафт Бэнсон

Ахлагч Эзра Тафт Бэнсон (голд нь) шинэхэн байгуулагдсан Италийн номлолын номлогчидтой уулзав





мөн дараа нь 1980-аад оны үед Италийн Ром номлолын ерөнхийлөгч байхдаа Их Эзэний ажил өвөг дээдсийнх нь нутагт урагшлахыг нүдээрээ үзжээ.

1983 онд ахлагч Кардоныг номлолын ерөнхийлөгчөөр дуудагдах үед Ром дахь сүмийн байруудын нэгээс бусад нь түрээсийн байр байжээ. Тэр үед сүмийн байр барих зардлын зарим хэсэг нь тухайн газар нутгийн гишүүдийн хандиваас бүрддэг байсан байна. Хэд хэдэн байр барих хөрөнгө хэрэгтэй байсан учраас гишүүдийн хувьд тийм ихийг хандивлах нь цаасан дээр боломжгүй мэт харагдаж байв. Энэ асуудлыг залбирч авч үзсэний дараа Итали дахь гишүүдийг тухайн жилийнхээ зул сарын

оролцохоор Италид буцаж очсон байна. Энэ нь гайхалтай үйл явдал байлаа. Тэрээр “Энд санваарын хүч, санваарын түлхүүрүүд, судрын хэллэгээр толгой хоргодох газар болох гадас Ромд зохион байгуулагдав” гэж хэлжээ.

### Ром дахь ариун сүм

2008 оны 10-р сарын Ерөнхий чуулганы үеэр ерөнхийлөгч Томас С.Монсонг Ромд ариун сүм баригдах тухай зарлахад Чуулганы төвд дуу алдах болон сэтгэл хөдлөлөөр дүүрэх нь сонсогдсон билээ. Хиймэл дагуулаар чуулган үзэхээр Италид цугласан гэгээнтнүүд баярласандаа чанга хашгирчээ. Нэгэн эгч энэ үйл явдлын талаар “Бид зүрх

*1854: Хавчлага өсөхийн хэрээр номлогчийн ажил буурч, номлогчид Швейцарит анхаарал хандуулах болов; валден хөрвөгчид Ютагийн Солт Лэйк хот руу цагаачилж эхлэв.*

*1862: Итали дахь бүх номлох ажил зогсов.*

*1944: ХҮТ цэргийн албан хаагчдын бүлэг Италид байгуулагдав.*



◀ 1964: Сүм Мормоны Номын шинэ итали орчуулгыг хэвлэв; Швейцарь номлол Италийн дүүргийг зохион байгуулав.

▶ 1966: Италийн номлол зохион байгуулагдав; ахлагч Эфра Тафт Бэнсон сайн мэдээг номлолын төлөө Италийг дахин онцгойлон адислав.



баярт зарцуулах мөнгийг сүмийн барилгын санд хандивлахад урьсан байна. Гэр бүлүүд өөрсдийн золиослолыг төлөөлүүлэхийн тулд зул сарын гацуур модны дор бэлэг тавихын оронд тоосго тавьж байв.

“Тэр үед тохиолдсон зүйл тун гайхамшигтай” хэмээн ахлагч Кардон хэлжээ. “Хандив нь хэрэгцээтэй байгаагаас нь ч илүү давж гарсан юм. Ийм учраас гэгээнтнүүд үргэлжлүүлэн аравны нэгийг итгэлтэйгээр төлж, сүмийг байгуулахын төлөө чадах бүхнээ хийх үед Их Эзэн номлол болон гэгээнтнүүд дээр элбэг дэлбэг сүнслэг адислалыг цутгаж байлаа. Тэдний итгэлтэй байдал нь сүмийг үргэлжлүүлэн өсгөж, гадас зохион байгуулагдаж мөн өнөөдөр Ромд ариун сүм баригдах хүртэлх боломжоор хангасан гэдэгт би бүрэн итгэдэг.”<sup>7</sup>

Ахлагч Кардон ерөнхий эрх мэдэлтнээр дуудагдахаасаа өмнө 2005 онд Италийн Ром гадас байгуулагдах үйл явдалд




Сицилийн эрэг дээр байрлах Катаниа тойргийн цуглааны байр. Катаниа салбар нь Италийн номлол байгуулагдсанаас хойш нэг жилийн дараа 1967 онд байгуулагджээ



сэтгэлдээ тун баяртайгаар мөн далавчтай юм шиг л гэртээ харьж билээ” хэмээн дурссан байдаг.

Ромд ариун сүм баригдана гэсэн нь яагаад тийм утга учиртай зүйл байна вэ? Гишүүд ариун сүмийн гүнзгий сүнслэг ач холбогдлыг ойлгохын сацуу ахлагч Кардоны хэлснээр энэ нь “ут хотын засаглал болон хүч чадал; үүнээс төрөн гарч, дэлхийн түүхэнд хувь нэмэр оруулсан аялагч, уран бүтээлч, эрдэмтэд ба зохион бүтээгчид; дэлхий дахинд Христийн шашныг таниулахад Ромын шашны үзүүлсэн нөлөөний адислал зэрэг түүхэн ач холбогдлын талаарх гүн мэдрэмжтэй холбоотой тэдгээр нь Ромын түүхийн нэг хэсэг бөгөөд одоо тэд Их Эзэний ариун сүмээр адислагдаж байна” гэсэн юм. 2010 онд болсон шав тавих ёслолын үеэр ерөнхийлөгч Монсон “Энэ газар дээр баригдах ариун сүм нь хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд утга учиртай бүх зүйл нь юм” хэмээн хэлжээ.<sup>8</sup>

## ИТАЛИ ДАХЬ СҮМИЙН ГИШҮҮД



1972: Ерөнхийлөгч Харолд Б.Лий хожмын үед Итали дахь гишүүд дээр айлчилж очсон сүмийн анхны ерөнхийлөгч болов.

1981: Италийн анхны гадас болох Милан гадас байгуулагдав.

1993: Сүм албан ёсоор өмч эзэмшиж мөн засгийн газраар хүлээн зөвшөөрөгдсөн гэрлэлт гүйцэтгэх хууль ёсны эрх авав.



◀ 2008: Ерөнхийлөгч Томас С.Монсон Италийн Ромын ариун сүмийг зарлав.

2012: Италид шашны байгууллагад олгодог хамгийн дээд хуулийн зөвшөөрлийг сүмд олгов.

40 гаруй жилийн турш Италийн гишүүд Швейцарийн Бернийн ариун сүм рүү аялж байсан ба зарим нь тэнд очихын тулд хоёр өдөр аялдаг байжээ. Ром гадасны ерөнхийлөгч асан, өдгөө бүсийн Далын гишүүн Массимо Дэ Фео Ром дахь ариун сүм бол Их Эзэн хожмын үеийн гэгээнтнүүдийн олон жилийн үйлчлэл болон золиослолыг харсны мөн ариун сүм бол тэдний чин хүсэл байсныг ойлгож байгаагийн илрэл гэдэгт итгэдэг.

Ариун сүм баригдах тухай зарлагдахад гишүүдийн мэдэрсэн сэтгэл хөдлөл нь сүүдчийн хоромд дэмжиж буй баг нь ялаат байгуулахад цэнгэлдэх хүрээлэнд мэдрэгддэгтэй адил байсан ба энэ баяр баясгалан нь мөнх бус байдлын өмнөх амьдрал авралын төлөвлөгөө зарлагдах үед бидний мэдэрсэн хэмээн түүний төсөөлсөн баяр баясалтай мөн адил юм гэж ахлагч Дэ Фео хэлжээ. Гэгээнтнүүд бие биенээ тэвэрч, инээж мөн уйлж байв. Энэ бол жинхэнэ аз жаргал байлаа.

“Эдгээр өдрүүдэд Их Эзэнд үйлчлэх нь гайхалтай бөгөөд энэ нь Итали болон Ромын хувьд онцгой юм” хэмээн ахлагч Дэ Фео хэлжээ. Тэрээр “Их

Эзэн Өөрийн хаант улсын энэ хэсгийг агуу ихээр адисалж байгааг би мэднэ” хэмээн гэрчилсэн юм.<sup>9</sup> ■ Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.

### ЭШЛЭЛҮҮД

1. Роналд А.Малан, “Waldensian History: A Brief Sketch (Валденчуудын түүх: Товч тэмдэглэл),” Валденчуудын гэр бүлүүдийн судалгаа, [www.waldensian.info/History.htm](http://www.waldensian.info/History.htm).
2. Лорэнзо Снөү, *The Italian Mission (Италийн номлол)* (1851), 10–11.
3. Лорэнзо Снөү, *The Italian Mission (Италийн номлол)*, 10–11.
4. Дианэ Стокөү, “Мормон валденчууд” (магистрын зэрэг горилсон бүтээл, Бригам Янгийн Их Сургууль, 1985), 26–27. Ийм зүүдний тухай жишээг Элизабет Маки “Suddenly the Thought Came to Me: Child’s Vision Prepares Her Family for the Gospel (Надад гэнэт бодоо төрөв: Хүүхдийн үзэгдэл гэр бүлийг нь сайн мэдээнд бэлтгэв),” 2013 он, 6-р сарын 3, [history.lds.org/article/marie-cardon-italy-conversion-ээс үзнэ үү](http://history.lds.org/article/marie-cardon-italy-conversion-ээс үзнэ үү).
5. Лорэнзо Снөү, *The Italian Mission (Италийн номлол)*, 15, 17.
6. Стокөү, “The Mormon Waldensians (Мормон валденчууд),” 1–5, 71–84.
7. Крэйг А.Кардон, 2013 оны 6-р сард зохиогчтой хийсэн ярицлагаас.
8. Томас С.Монсон, Жэсон Свэнсон, “Rome Italy Temple Groundbreaking (Италийн Ром дахь ариун сүмийн шав тавих ёслол),” *Сүмийн мэдээ*, 2010 оны 10-р сарын 23, [ldschurchnews.com](http://ldschurchnews.com).
9. “Ерөнхийлөгч Массимо Дэ Фэотой хийсэн ярицлага—Итали—1-р хэсэг,” *Бүх дэлхийд* (архивлагдсан радио хөтөлбөр); [mormonchannel.org](http://mormonchannel.org).



Ахлагч  
**Жэффри Р.Холланд**  
Арванхоёр Төлөөлөгчийн  
чуулга

# Христтэй адил байх ДУУДЛАГА

Үеийн үед энэ нь Израилын түүх байсаар ирсэн юм. Гэм нүгэл ихсэн, нийгэм нь шашингүй болох үед эсвэл Бурханы өгсөн зарлигийг болон ёс суртахууны жишгийг харийнхан устгах үед Бурхан гэрээний хүүхдүүдийг аглаг буйд руу явуулж байсан бөгөөд Сионыг дахин байгуулж мөн дахин шинээр эхлэхийг зарлигладаг байсан.

Хуучин Гэрээний үед энэ гэрээний эцэг болох Абрахам нь Халдеигаас—чухамдаа Вавилоноос—зугтан гарах хэрэгтэй болдог бөгөөд бидний одоо Ариун нутаг гэж нэрлэдэг (Абрахам 2:3–4-ийг үзнэ үү) Канааны нутагт ирж, бүхий л амьдралаа Бурханд зориулдаг. Абрахамын үр удмын үеэс хэдхэн үеийн дараа, израилчууд хэмээн нэрлэгдэж байсан тэд Сионоо алдаж мөн харь холын Египетэд боолчлогдож байсан юм (Египетээс гарсан нь 1:7–14-ийг үзнэ үү). Тиймээс амлалтын хүүхдүүдийг аглаг буйд руу дахин удирдан дагуулах Мосег өсгөсөн билээ.

Хэдхэн зууны дараа, тэдгээр израил гэр бүлүүдээс нэгэн гэр бүл Лихайгаар удирдуулан, Вавилоны эзэгнэлээс зугтан, хайрт Иерусалимаа орхин явахаар зарлигдуулдаг. Энэ нь дахиад л тохиолоо! (1 Нифай 2:2-ыг үзнэ үү.) Тэд огт өөр тив рүү шинэ Сионыг байгуулахаар явж байгаага мэдээгүй (1 Нифай 18:22–24-ийг үзнэ үү). Мөн тэдний жаредчууд гэж нэрлэгдэх өвөг эцгийн нэг бүлэгт мөн яг тэдний адил зүйл тохиолдсоныг ч тэд мэдээгүй (Ефер 6:5–13-ыг үзнэ үү).

Өөрсдийн хүссэнээр шүтэн бишрэхийн тулд төрсөн нутгаасаа зугтан гарсан хэсэг бүлгээс Америкийн колони бий болсон гэдэг нь сайн мэдээний сэргээлтийг тэмдэглэх бүтэд сонирхолтой байх болов уу. Америкийн Пюританы бүлгийн нэгэн нэрт эрдэмтэн үүнийг Христийн шашны “аглаг буйд дахь үйлс” болон орчин үеийн израилчуудын өөрсдийгөө Эртний ертөнцөөс (Old World) чөлөөлөх гэсэн мөн шинэ газар нутагт тэнгэрийн замыг дахин хайх гэсэн хичээл зүтгэл хэмээн тайлбарласан юм<sup>1</sup>

*Энэ хожмын өдрүүдэд Бурхан Израилыг Христтэй илүү адил байж, сайн мэдээний дагуу амьдрах шийдвэр төгс байхад болон Сионыг байгуулахдаа бидний одоо байгаагаас ч илүү ариун байхад дуудаж байна.*





Тэр нэгэн сүүлчийн зугталтын талаар би та нарт сануулахад энэ бол өөрсдийн бошиглогчдоор удирдуулсан, шашны өвөг дээдсийг маань удирдан залсан манай сүм байсан билээ. Иосеф Смитийг Нью Йорк, Пенсилвани, Огайо, Миссури мужуудад мөрдөн мөшгөж, эцэст нь Иллинойс мужид хөнөөснөөс хойш Израилын хүүхдүүд амар амгалангийн газрыг эрж хайх явдал хожмын өдрүүдэд дахин тохиохыг бид хардаг. Бригам Янг (1801–1877) буюу америк Мосе гэж хүндэтгэгдэн нэрлэгдэж байсан тэрбээр гэгээнтнүүдийг уулсын хөндий тийш удирдсан ба хөл нь цуцаж байсан ч тэд:

*Бурханы бидэнд бэлтгэсэн газрыг бид олно,  
Өрнөдийн алс холд,  
Хэн ч ирж гэмтээж, айлгахгүй тийм газарт;  
Тэнд л гэгээнтнүүд адислагдах болно хэмээн  
дуулж байжээ.<sup>2</sup>*

Сион. Амагдсан газар. Шинэ Иерусалим. Гэрээт түүхийн 4000 гаруй жилийн туршид; Зугт, эрэлхийл; явж, өөр газар оршин тогтно; Вавилоноос зугт; Сионы хамгаалалтын ханыг барь гэсэн хэв маягтай байсаар ирсэн юм.

Одоо мөн бидний өдрийг хүртэл.

### **Байгаа газартаа Сионыг байгуул**

Манай эрин үеийн олон онцгой шинж чанарын нэг нь бидний дэлхий дээрх Бурханы хаант улсыг байгуулж байгаа байдал хэрхэн өөрчлөгдөж байгаа нь юм. Энэ үе нь агуу бөгөөд түргэн өөрчлөлтийн үе юм. Өөрчлөгдсөн нэг зүйл бол Бурханы сүм дахин хэзээ ч зугтахгүй. Энэ сүм Наувугаас болон Көртландаас мөн Англи, Иерусалим, Канаан болон Хараанаас явахын тулд тэгээд бас хаашаа явахаа мэдэхгүйгээр ахин хэзээ ч Ураас явахгүй юм.

Үгүй ээ, Бригам Янгийн бид бүгдэд хэлсэнчлэн “Биднийг хайруулын тавгаас гаргаад галд шидсэн ч галаас гаргаад өрөөний голд шалан дээр шидсэн ч бид энд байна, бид эндээ үлдэнэ.”<sup>3</sup>

Мэдээж, энэ нь дэлхий даяарх сүмийн гишүүдийн хувьд үзэл баримтлал нь болсон юм. Манай үед, энэ эцсийн өдрүүдэд бид төлөвшиж мөн зугтахаа больсон. Бид улс, үндэстэн, хэлтэн, ард түмэн болгонд өөрсдийн хөл, гэр бүл, үндэс суурийг *хөдөлшгүй бат* тавихаар хөгжиж төлөвшсөн. Сүм хаана байна—тэнд Сион байх болно. Энэхүү өөрчлөлтийн улмаас бид Сионыг өөрсдийн *хаана* амьдарч байгаагаар бус

харин *хэрхэн* амьдарч байгаагаар боддог болсон.

Энэхүү шинэ үйл хэргийг тайлбарлахын тулд би гурван тохиолдлын талаар дурдмаар байна.

### **Гурван зүйлийг зааж сургасан гурван үйл явдал**

1. Хэдхэн жилийн өмнө номлолоос буцаж ирсэн миний нэгэн найз Юта мужийн коллежийн сагсан бөмбөгийн багт тоглодог байсан. Тэр маш сайн залуу мөн сайн тоглодог байсан хэдий ч өөрийнхөө хүссэн хэмжээнд тоглож чаддаггүй байлаа. Түүний хамгийн сайн чадварлаг тал нь түүний багт тэр үед тийм ч хэрэгтэй байгаагүй бололтой. Тийм болохоор багийнхаа гишүүд, дасгалжуулагчийн дэмжлэгтэйгээр мөн сайныг хүссэн ерөөлтэйгөөр залуу найз маань өөр сургууль руу шилжсэн бөгөөд тэр сургуулийн багт илүү их тус дэм болох байх гэж бодож байсан аж.

Аз болоход шинэ сургуульдаа тэр удалгүй эхлэн тоглогч болсон юм. Тэгтэл юу болсон гээч? Энэ явдал болохоос хэдэн жилийн өмнө гарсан байсан хуваарийн дагуу тэрээр Солт Лэйк хотод тэр үед Дэлта төв гэж нэрлэгддэг байсан төвд өөрийн хуучин багийнхаа эсрэг тоглох болжээ.

Тэр л орой уг залууд—аравны нэгээ төлөгч, саяхан гэрлэсэн, ахлагчдын чуулгад үйлчилж, хотынхоо өсвөр үеийнхэнд энэрлийн үйлчилгээ үзүүлж мөн эхнэртэйгээ хамт шинэ үрээ хүлээж байсан түүнд хандан хэлсэн хорон гашуун үгсийг ямар ч хүмүүний хувьд хэзээ ч, хаана ч, ямар ч спорт тоглодог бай эсвэл аль ч их сургуулийнх бай, ямар ч хувийн шийдвэр гаргасан байх нь хамаагүй, хэн ч амсахгүй байх ёстой юм.

Мэргэжлийн хувьд амьд домог болсон нэгэн сонирхол татсан тоглолтын дараа энэ багийн дасгалжуулагч нь хүртэл түүнд “Юу болоод байна аа? Чи чинь энэ нутгийн, сайн явж байгаа хүү нь шүү дээ. Эд нар чинь танай хүмүүс. Тэд чиний найзууд биз дээ” гэж хэлжээ. Гэхдээ хамгийн муухай нь гэвэл тэр бүр зориуд гайхшаа баран “Энэ хүмүүсийн ихэнх нь танай сүмийн гишүүд биш гэж үү?” хэмээн асуусан байна.

2. Би нэг гадасны 18-аас дээш насны ганц бие залуучуудын цуглаанд үг хэлэхээр уригдсан байв. Би гадасны төвийн арын хаалгаар орох үед 30 гаруй насны нэг эмэгтэй надтай зэрэг шахуу орж ирсэн юм. Цуглааны





өрөө рүү шахцалдан орж байгаа хүмүүсийн дундаас түүнийг анзаарахгүй байхын аргагүй байсан. Миний санаж байгаагаар, тэр ганц хоёр шивээстэй, чих ба хамартаа цагираг зүүсэн, мөсөн чихэрт л байж болох олон өнгийн үстэй, богинохон банзал, ил задгай энгэртэй цамц өмссөн байсан.

Толгойд минь энэ эмэгтэй манай сүмийнх биш, зовж буй нэгэн байх, уригдан ирсэн юм болов уу эсвэл хэн нэгэнтэй хамт энэ цуглаанд Их Эзэний удирдамжаар ирж, түүний амьдралд сайн мэдээний өгөх амар амгаланг болон зөв удирдамжийг олох гэж хичээн ирсэн юм болов уу? Эсвэл сүмийн гишүүдийнхээ дагаасай хэмээн урамшуулдаг жишиг ба найдвараас төөрөн холдсон гишүүн ч байж магадгүй, тэгээд өнөө орой сүмийн энэ үйл ажиллагаанд ирэхээр шийдсэн юм болов уу? гэсэн бодлууд орж ирэв.

3. Хэдэн сарын өмнө Канзас хотын ариун сүмийн онцгой адислаад оролцож байх үед Либэрти Миссури гадасны дээд санваартан, цагдаагийн мэргэжилтэй Фристөүн хэмээх гайхалтай нэгэн ах Холланд эгч бид хоёрыг урьсан юм. Бидэнтэй ярьж байх хоорондоо тэрээр нэг орой уг хотын нэгэн хэцүүхэн хэсэгт гомдол гарсныг барагдуулахаар очсон тухайгаа ярьсан юм. Ор, гудас, дэр ч үгүй хоосон нэг өрөөнд 2-8 насны бололтой таван жаахан хүүхэд бөөгнөрөн, хиртэй шалан дээр унтахыг хичээж байгааг нь тоох хүн ч байхгүй, чанга дуу чимээ бүхий хөгжим хангинаж, хар тамхи үнэртсэн газар нэгэн эмэгтэй хэдэн эрэгтэйтэй хамт архидан, хараалын үгс хэлж байжээ.

Фристөүн ах гал тогооны шүүгээнүүдэд мөн хөргөгчинд ямар нэг лаазтай, савтай хоол байгаа эсэхийг үзэхэд юу ч байгаагүйгээр үл барам байрны ард хуцаж байсан нохой тэдгээр хүүхдүүдээс илүү хоолтой байсан тухай ярьсан юм.

Ээжийнх нь унтлагын өрөөнд тэр нэг зөөлөн гудас олжээ. Тэр нь уг гэрт байгаа ганц л гудас байсан аж. Тэр уг гэрээс эрж хайсаар орны даавуурхуу юм олоод гудсан дээр тавин, мөнөөх таван хүүхдийг хэвтүүлжээ. Нүдэндээ нулимстайгаар тэр өвдөг сөхрөн суугаад Тэнгэрлэг Эцэгт хандан, тэдний аюулгүй байдлын төлөө залбирч, тэдэнд сайхан нойрсоорой гэж хэлсэн байна.

Түүнийг босон, хаалга руу алхах зуур хүүхдүүдийн нэг нь болох зургаа орчим настай хүүхэд орноосоо суга үсрэн босоод түүн рүү гүйж ирэн, “Та намайг өргөөд авчих тэгэх үү?” гэж гуйжээ. Нүд дүүрэн нулимстай тэрээр уг хүүхдийг оронд нь хэвтүүлж, хар тамхи хэрэглэчихсэн байсан ээжийг нь олоод (эрэгтэйчүүд нь аль хэдийн зугтчихсан байсан) түүнд хандан, “Би маргааш буцаад ирнэ. Намайг тэр хаалгаар орж ирэх үед энэ гэрт илт өөрчлөлт хийсэн байгаарай. Тэгвэл цаашид улам их өөрчлөлт гарах болно. Би чамд амлая” гэж хэлжээ.<sup>4</sup>

Энэ гурван тохиолдол юугаараа адил вэ? Тэд Вавилоны гурван өөр жижигхэн амьдралын бодит жишээ—нэг нь сагсан бөмбөгийн тэмцээн дээрх жигшим хувийн зан чанар, нөгөө нь биднээс өөрөөр амьдардаг хүмүүстэй нүүр тулахад хувь хүнд тулгардаг



соёлын бэрхшээл, гуравдахь нь маш том, илүү ноцтой асуудал байлаа.

**Сургамж 1: Чи хэзээ ч шашнаа хаалганы гадна бүү орхи**

Эхлээд сагсны тэмцээн дээр болсон явдлын талаарх түүхээ төгсгөе. Тэр тэмцээний маргааш нь хүмүүс дургүйцэж, уг болсон явдлаас болж уучлалт гуйхыг хүсэхэд нэг залуу үүний хариуд нь “Сонсож бай даа, бид сагсан бөмбөгийн тоглолтын талаар ярьж байна шүү. Ням гаргийн хичээлийн талаар биш. Хэрвээ чи хүмүүсийн хашгичихыг хүлээж авч чадахгүй бол битгий тогло. Бид уг тэмцээнүүдийг үзэх гэж их мөнгө төлдөг. Тэгэхээр бид хүссэнээрээ л байж болно. Бид шашнаа хаалганы гадна орхичихоод ороод ирдэг шүү дээ” гэж хариулсан байна.

“Бид шашнаа хаалганы гадна орхичихоод ороод ирдэг шүү дээ” гэнэ үү? 21-р зуунд Сионыг байгуулах нэгдүгээр сургамж нь: Чи хэзээ ч шашнаа хаалганы гадна орхих ёсгүй.

Залуу найз нар минь, иймэрхүү шавьт ёс байж болохгүй—энэ нь шавьт ёс огтхон ч биш. Бошиглогч Алмагийн зааснаар бид “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж” (Мозая 18:9) зогсох ёстой. Заримдаа юм уу, цөөн хэдэн газарт эсвэл зөвхөн манай баг олон оноогоор

хожиж байх үед гэж хэлээгүй юм шүү.

Нөхцөл байдал юм уу өдөөн хатгалга эсвэл асуудал ямар ч байсан бай Христийн жинхэнэ дагалдагч шашнаа хаалганы гадна хэзээ ч орхидоггүй юм.

**Сургамж 2: Нинжин сэтгэл гарга, гэхдээ зарлигуудад үнэнч бай**

Харин одоо би яриагаа цугларалт дээр харсан эмэгтэй рүү хандуулж байна. Тэр эмэгтэйд хүмүүсийн хандах хандлага ямар ч байсан гэсэн, мөнхийн хууль нь юу вэ гэвэл энэ нь бидний шашны итгэлийг болон сайн мэдээний маань амлалтыг харуулах ёстой. Тийм болохоор ямар ч нөхцөлд бидний хариулт уг нөхцөлийг дордуулах биш, дээрдүүлэх учиртай юм. Бид тэр хүнийг илүү буруутгах байдлаар үйлдэх юм уу хариу үзүүлэх ёсгүй.

Энэ нь бид өөрсдийн гэсэн бодол санаагүй мөн өөрсдийн жишиггүй байна гэсэн үг ч биш, бас амьдралын “тэгэх ёстой” эсвэл “тэгэх ёсгүй” гэдгийг бүр тоохгүй орхиж байна гэсэн үг ч биш юм. Гэхдээ энэ нь бид чадахынхаа хэрээр Аврагчийн амьдарч мөн хамгаалсны адилаар тэдгээр зарлигуудыг шударга арга замаар хамгаалан, жишгүүдийн дагуу амьдрах ёстой гэсэн үг юм. Аврагч маань нөхцөл байдлыг сайжруулахад хэрэгтэй зүйлийг хийж, үнэнийг заан, нүгэлтнүүдийг өршөөж, бүр ариун сүмийг ч ариусгаж байсан.



За тэгэхээр, ер бусаар хувцаслаж, өөрийгөө өөрөөр авч яваа тэр эмэгтэйн талаар хэлэхэд, тэр бол Бурханы охин мөн тэрээр мөнхийн үнэ цэнэтэй гэдгийг бид юун түрүүнд санах хэрэгтэй. Тэр энэ дэлхий дээр хэн нэгний охин гэдгийг бид бас эхлээд санах хэрэгтэй. Тэр сүмийн үйл ажиллагаанаас зайлсхийлгүй ирчихсэн байгаад нь бид талархаж болно. Товчоор хэлбэл, бид түүнийг байж чадах хамгийн сайн хүн болоход нь туслах чадвартай байх үүднээс өөрсдийн чадах хамгийн сайнаараа байх хэрэгтэй.

Бид: Миний хэлж мөн хийж болох хамгийн зөв зүйл юу вэ? Энэ нөхцөлийг мөн тэр эмэгтэйтэй *эцсийн дүндээ* юу дээшлүүлж болох бол? хэмээн чимээгүйхэн дотроо залбирч болно. Миний бодлоор эдгээр асуултыг асууж, Аврагчийн хийх байсан зүйлийг хийхээр хичээх юм бол Түүний “Гаднах төрхөөр нь бүү шүү. Харин үнэн зөв шүүлтээр шүү” (Иохан 7:24) гэж хэлсний жинхэнэ учир утга нь гарч ирнэ.

Энэ сүм нийгмийн сайн сайхан, улс төрийн зорилго эсвэл өөр бусад шалтгаанаар хэзээ ч сургаалаа амархан болгож, бууруулахгүй. Илчлэгдсэн үнэний дээд өндөрлөг л бидэнд зовсон ядарсан нэгнийг өргөх боломж олгодог. Манай Христийн шашны үндсэн чанар, шаардлага болох бидний нинжин сэтгэл ба хайраас болж бид хэзээ ч зарлигуудыг зөрчиж болохгүй.

Бид ардчилсан нийгэмд нийгмийн нарийн ширийн асуудалтай тулгарахад энэ нь маш бэрхшээлтэй, зарим хүмүүст бүр ойлгохын аргагүй мэт санагдаж болно. Залуучууд “Бид ийм байдлаар амьдарч мөн ингэж биеэ авч явах ёстой гэдэгт итгэдэггүй, гэхдээ бид яагаад бусдыг өөрсөдтэйгөө адил байлгах ёстой юм бэ? Тэд өөрсдийн гэсэн сонгох эрх чөлөөтэй биз дээ? Бид бусдад өөрсдийн сүсэг бишрэлийг тулгаж, *тэднийг* тодорхой байдлаар, яг ингэж биеэ авч явах хэрэгтэй гэж шаардаж байна гэдэг чинь өөрсдийнхөө зөв гэдэгт л итгэж, шүүж байгаа хэрэг биш үү?” гэж асууж болох юм.

Иймэрхүү нөхцөл байдалд та нар зарим зарчмуудыг яагаад хамгаалдаг мөн *зарим* нүглийг *хаана ч байсан гэсэн* яагаад эсэргүүцдэг талаар эелдгээр тайлбарлах хэрэгтэй. Учир нь холбогдох хууль, нөхцөлүүд нь зөвхөн улс төр, нийгмийн асуудал *биш* харин мөнхийн үр дагавартай байдаг. Биднээс өөр сүсэг бишрэлтэй хүмүүсийг гомдоохыг хүсэхгүй байгаа ч Бурханыг гомдоохгүй байхыг л бид илүү ихээр хүсч байна.

Энэ нь нэг өсвөр насны хүүхэд “Би одоо автомашин жолоодож чадаж байгаа, улаан гэрэл дээр зогсох ёстой гэдгээ ч мэднэ, гэхдээ бид үнэхээр бусдыг шүүн, бусад

бүх хүнийг улаан гэрэл дээр зогсоохыг хичээх ёстой юу? *Хүн болгон* бидний хийдэг зүйлийг хийх ёстой юу? Бусад хүмүүст ч гэсэн сонголт байдаг юм биш үү? Тэд бидэнтэй адил биеэ авч явах ёстой юу?” гэж хэлж байгаатай ойролцоо юм. Тэгээд түүнийхээ учрыг тайлбарлах хэрэгтэй бөгөөд *бүх* хүнийг улаан гэрэл дээр зогсоосой гэж бид найддаг. Тийм ээ, тэд өөрсдийн гэсэн ёс суртахууны сонгох эрх чөлөөтэй болохоор гэмтэй тэдгээр хүмүүсийг эсвэл биднээс өөр итгэл бодолтой тэднийг бид *буруушаалгүйгээр* үүнийг хийх хэрэгтэй.

Энэ дэлхий дээр янз бүрийн сүсэг бишрэл байгаа мөн хүн бүр ёс суртахууны хувьд сонгох эрх чөлөөтэй,

**Бидний үйлдэл, биеэ авч явах**

**байдал нь шашны итгэл бо-**

**лон сайн мэдээний амлалтыг**

**маань харуулах ёстой. Тийм**

**болохоор ямар ч нөхцөлд**

**бидний хариулт уг нөхцөлийг**

**дордуулах биш харин дээр-**

**дүүлэх учиртай юм.**

гэхдээ бидний хэн нь ч Бурхан энэ тухайд үл дуугардаг мэтээр эсвэл нийтээрээ санал нийлж байгаа үед л зарлигуудыг дагах ёстой мэтээр хандаж болохгүй. Энэ 21-р зуунд бид энэ дэлхийгээс зугтаж чадахгүйгээс хойш, шашнаа чөлөөтэй шүтэх эрх чөлөөг олгодог хууль, нөхцөл байдал, орчин тойрны төлөө бид тэмцэх ёстой. Энэ

нь Вавилонд байгаа ч гэсэн, тэндхийнх биш мэт байх нэг арга юм.

Зугтах ч аргагүй энэ дэлхий дээр бид дэлхийд харуулахын тулд Бурханы зарлигласнаар, түүний өгсөн хуулийн дагуу ёс суртахууны жишгээ хадгалж, тэрхүү болгоомжтой замаар алхахдаа нинжин сэтгэл, хайр энэрэл, харилцан ойлголцоор хийхээс илүү чухал, илүү шударга зарчимч байдлыг би мэдэхгүй.

### **Сургамж 3: Нийгэм, улс эх орныхоо сайн сайхны төлөө сайн мэдээний үнэ цэнийг ашигла**

Бидний олон нь цагдаа юм уу нийгмийн ажилтан эсвэл шүүхийн ширээнд суух шүүгч болохгүй ч бид бүгдээрээ бусдын сайн сайхны төлөө мөн нийгмийнхээ ёс суртахууны аюулгүй байдлын талаар санаа тавьж байх хэрэгтэй. Хоёр жилийн өмнө Ерөнхий чуулган дээр Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Квинтин Л.Кук энэ талаар:

“Бид гэр бүлээ хамгаалахаас гадна өөрсдийн нийгмийг хамгаалах гэрлийн эх үүсвэр нь байх хэрэгтэй. Аврагч “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх



Эцэгийг алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” хэмээн хэлсэн гэж хэлжээ. . . .

“Шударга бус байдал өсөн нэмэгдэж байгаа энэ дэлхийд шашны итгэл дээр үндэслэсэн үнэ цэнэ бүхий зүйлс ард түмний талбай дээр [ил тод] байх нь их чухал юм. . . .

“Шашны итгэл бол гэрэл, мэдлэг, мэргэн ухааны эх үүсвэр бөгөөд нийгэмд маш чухал ашиг тус үзүүлдэг.”<sup>5</sup>

Хэрвээ бид сайн мэдээний адислалуудыг нийгэмдээ мөн орон нутагтаа авчрахгүй юм бол, үнэндээ бидэнд ёс суртахуунт зан байдлыг албадаж чадах хангалттай олон цагдаа—хангалттай олон Исаак Фристөүнтэй байхгүй байхсан. Энэ нь ч тийм биш. Тэр гэрт байсан хоол хүнс, хувцас хунаргүй хүүхдүүд бол Бурханы охид, хөвгүүд юм. Тэр ээж тэднээс ахмад болохоор илүү буруутай, илүү хариуцлагатай байх ёстой боловч тэр ээж ч гэсэн Бурханы охин юм. Тиймэрхүү нөхцөл байдал нь хуулийн дагуу хатуу байхыг зүй ёсоор шаардаж болох

хэдий ч бид чадах үедээ, чадах газраа тэдэнд туслахыг хичээж байх хэрэгтэй. Учир нь зарим хаалга хэчнээн найдваргүй, онцгүй байсан ч бид өөрсдийн шашныг хаалганы гадна орхидоггүй юм.

Үгүй ээ, бид бүгдийг хийж чадахгүй, гэхдээ л бидэнд хийж чадах зүйл бий. Бурханы дуудлагад хариулан, Израилын хүүхдүүд энэ удаад Вавилоноос зугтахгүй, харин дайрч гаран, үүнийг хийх хүмүүс нь юм. Бид хэт гэнэн байлгүйгээр, бусдыг болон өсөж буй үеийнхнээ хамгаалж, хөршүүдээ адислан мөн гэр бүлүүдэд туслах янз бүрийн боломжийг эрж олон, шашнаа өргөн хүрээнд тууштайгаар даган амьдарч чадна.

### **Есүс Христэд хайраа харуул**

Хожмын үеийн гэгээнтнүүд нь талхны хөрөнгө, амтаа алдаагүй давс байж, торхны доор нуух бус харин толгод дээр тавих ёстой гэрэл байхаар дуудагдсан. Тийм болохоор, танилцуулаад байгаарай!





**Хожмын үеийн гэгээнтнүүд нь  
талхны хөрөнгө, амтаа алдаагүй  
давс байж, торхны доор нуух бус  
харин толгод дээр тавих ёстой  
гэрэл байхаар дуудагдсан**

хэмжээнд хамгийн хүнлэг байдлаар бусдад миний үгснийг тунхаглаж мөн миний сайн мэдээг хамгаалсан” гэж хэлээсэй гэж би хүсч байна.

Тэрээр “Чамайг өөрийнхөө хийсэн гэм нүглийн хувьд эсвэл бусдын нөхцөл байдлын тухайд дандаа амжилттай байгаагүй гэдгийг чинь мэднэ. Гэхдээ чамайг чин сэтгэлээсээ хичээсэн гэдэгт би итгэж байна. Чи зүрх сэтгэлдээ намайг үнэхээр хайрладаг байсанд чинь би итгэж байна” хэмээн хэлэх болно.

Би энэ мөнх бус амьдралд юунаас ч илүү тийм л нэг явдал тохиогоосой. Надад ч, та нарт ч бид бүгдэд тийм зүйл тохиолдоосой гэж хүсч байна. Жижиг, том аль ч зүйл дээр хувь хүнийхээ хувьд Есүс Христийн сайн мэдээг дагаж амьдар хэмээн; тэгээд бас та нартай яг адил харагдаж, хувцаслаж, биеэ авч явдаггүй тэдэнд гар сунган, болж өгвөл өөрийн чадах нөхцөл байдлаар үйлчлээрэй хэмээн—“Ай Израил, Бурхан дуудаж байна.”<sup>6</sup>

Би Их Эзэн, Есүс Христэд хайртай бөгөөд Түүний үйлчлэгч болохоор хичээж байгаа. Хүүтээ бидэнд өгөх хэмжээнд биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгт би хайртай. Энэхүү бэлгийн хувьд, Бурхан энэхүү хожмын өдрүүдэд Израилыг дуудаж байгаа бөгөөд Тэрээр биднийг Сионыг байгуулж, сайн мэдээний дагуу амьдрах шийдэмгий байдалдаа Христтэй илүү адил болж, одоо байгаагаасаа илүү ариун байгаасай хэмээн хүсэн хүлээдэг. Биднийг гуйвал Тэрээр бидэнд үнэн шавь нар нь байх хүч чадал болон ариун байдлыг өгнө гэдгийг би бас мэднэ. ■

*2012 оны 9-р сарын 9-нд Ютагийн Сэйнт Жорж дахь Дикси Стэйт Их Сургууль дээр болсон СБС-ийн онцгой цугларалт дээрх “Ай, Израил, Бурхан дуудаж байна” хэмээх хэлсэн үгээс авав. Хэлсэн үгийг бүрэн эхээр нь уншихыг хүсвэл [lds.org/broadcasts/ruu/opno.yu](http://lds.org/broadcasts/ruu/opno.yu).*

#### ЭШЛЭЛҮҮД

1. Пэрри Миллэр, *Errand into the Wilderness (Аглаг буйдад)* (1984), 2–3-ыг үзнэ үү.
2. “Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 2.
3. Бригам Янг, Жэймс С.Браун эш татав, *Life of a Pioneer: Being the Autobiography of James (Анхдагч хүний амьдрал: Жэймс С.Брауны намтар)* S.Brown (1900), 121.
4. Исаак Фристон, 2012 оны 5-р сарын 5-нд зохиогчтой хуваалцсан туршлага.
5. Квинтин А.Күк, “Тэрэлтэй!” *Лиакхона* 2010 оны 11-р сар, 28, 29.
6. “Israel, Israel, God Is Calling (Ай Израил, Бурхан дуудаж байна),” *Hymns*, no. 7.

Бид зөв зүйлийг ярьж, зөв зүйл хийж, үйлс үгээрээ өгөөмөр хандах юм бол Аврагч Өөрийн ажлыг зөв шуударгаар яаравчлах үед мөн төгсгөл ирлээ гээд Өөрийн алдар суунд ирэх үед Тэрээр биднийг – таныг, намайг, бид бүгдийг чадах бүхнээ хийн, сайн мэдээний дагуу амьдрах гэж мөн өөрсдийн амьдрал, сүм, нийгмээ чадахын хэрээр дээшлүүлэх гэж хичээж байгааг маань олж харах болно.

Түүнийг ирэх үед би *аль болох* сайн мэдээний дагуу амьдарч байхыг хүсч байна. Итгэлээ түгээж, ямар нэгэн сайн зүйлийг хийж байхад маань гайхшируулан ирээсэй гэж би хүсч байна. Аврагч маань надад хандан, “Жэффри, би чамайг албан тушаалаар чинь биш, харин амьдралаар чинь, хэрхэн амьдрахыг хичээж байгаагаар чинь, хадгалан хамгаалахыг хичээж байгаа жишгээр чинь таньж байна. Би зүрх сэтгэлийн чинь үнэнч байдлыг харж байна. Чи хамгийн эхлээд, юуны түрүүнд өөрийгөө сайжруулахыг хичээсэн, тэгээд өөрийнхөө

## БУЛШНЫ ЧУЛУУН ДЭЭР ҮЛДЭЭСЭН МИНИЙ ЗУРВАС

**2003** оны зун би АНУ-ын Мичиганд элэнц нагац Робэрт Холлын талаар судалгаа хийж байсан юм. Аялалынхаа төгсгөлд би 20 жилийн өмнө очиж байсан оршуулгын газартаа дахин очлоо.

Өмнө нь энд ирэхдээ би Холл гэсэн нэртэй нэгэн булшны чулуун дээр цэцэг байхыг анзаарч билээ. Энэ удаад би зурвас бичиж, түүн дээрээ он, сар, өдрөө бичээд зурвасаа ус борооноос хамгаалахын тулд гялгар хавтсанд хийв. Тэгээд би Робэрт Холлын талаар илүү ихийг мэдэж авахад минь тусалж чадах хэн нэгэн хүн зурвасыг олох байх гэж найдан залбирч, зурвасаа булшны чулуун дээр орхиж билээ. Калифорни дахь гэртээ буцаж ирэх үед надад найдлага байсан

ч зурвасны талаар ямар нэг сураг ирнэ гэдэгт эргэлзэж байв.

Долоо хоногийн дараа би холын үеэл Дэкэ Бэнтлигээс нэг захидал хүлээн авсан юм.

Тэрээр “өчигдөр надад нэг хачин зүйл тохиолдлоо” гээд “15:00 цагт би гүзээлзгэнэ худалдаж авахаар явж байснаа гэнэт Плэйнс Рөүд оршуулгын газарт очиж, өвөг дээдсийнхээ булшийг үзэхээр шийдсэн. Би хэдэн жилийн турш тэнд очоогүй. Булшнуудын хажууд чиний ил захидал байсан” гэж бичжээ.

Намайг зурвас үлдээсэн тэр өдөр Дэкэ оршуулгын газарт очсон юм. Би тэр даруй түүн рүү утасдсан. Ярилцаж байх үедээ би түүнийг оршуулгын газраас 50 бээр (80 км) зайд орших Хиллсдэйл гэдэг газар амьдардаг болохыг нь олж мэдэв.

Хэдэн сарын дараа би Дэкэтэй уулзахаар Мичиган руу яаран явсан. Түүний байшингийн эсрэг талд хамаатнуудынх нь оршуулга байдаг гэж тэр хэлсэн ба намайг тийшээ явах хүсэлтэй байгаа эсэхийг асуув. Тэр оршуулгын газарт Холл гэсэн нэртэй дөрвөн булшны чулуу байгаа бөгөөд тэдний хоёрынх нь талаар юу ч мэдэхгүй гэдгээ тэрээр хэллээ.

Оршуулгын газарт Дэкэ надад булшны чулуунуудыг үзүүлэхэд түүний мэдэхгүй хоёр нэр байсан нь Мартин ба Анна Холл гэсэн хүмүүс байлаа. Би удмын бичгээ авчраагүй байсан ч Мартин Холл гэдэг хүний талаар мэдээлэл хайж байснаа тод санаж байв.

Бид Мартины нас барсан тухай баримтаас эцэг эхийнх нь нэрийг олох байх гэж найдан, тэр газрын шүүх байгууллагын ажил тарахаас өмнө яаран очлоо. Энэ нь олдсон юм! Робэрт Холл бол Мартины аав байсан байна! Удаан үргэлжилсэн эрэл хайгуул маань дууссан гэдгийг Ариун Сүнс надад баталж өглөө.

Робэрт Холлын мэдээллийг олсон нь “бараг сүнслэг” зүйл боллоо гэж сүмийн гишүүн бус Дэкэ хэлсэн. Сүнс намайг удирдсан гэдгийг би мэдэж байсан учраас инээмсэглэв.

“Чи зурвасаа 20 жилийн өмнө энд үлдээгээгүйдээ сэтгэл дундуур байсан байж болох юм, гэхдээ би гуравхан жилийн өмнө л Хиллсдэйл рүү нүүж очсон шүү дээ” гэж Дэкэ хэлэв.

Энэ туршлага нь миний хувьд сургамжтай үйл явдал байсан ба гэр бүлийн түүх бол үнэхээр Бурханы ажлын нэг хэсэг, Тэрээр биднийг зөв шударга хичээл чармайлтаар маань дамжуулан удирддаг гэдгийг ойлгуулсан. ■

АНУ, Калифорни, Мариан Чаплин Стовалл



**Н**адад тусалж чадах хэн нэгэн хүн зурвасыг олох байх гэж найдан залбирч, зурвасаа булшны чулуун дээр үлдээж билээ.



# ИХ ЭЗЭН ХҮҮГ МААНЬ ЭДГЭЭХ БОЛОВ УУ?

Хүү маань дөрвөн настай байхдаа надаас байнга “Master, the Tempest Is Raging (Эзэн, уруу таталт ширүүсч байна)” (*Hymns*, х. 105) дууг дуулж өгөөч гэж гуйдаг байсан. Тэр дууллын Их Эзэн салхи болон давалгаанд тушааж, номхруулж байгаа дахилтын хэсэгт түүний бяцхан нүд гэрэлтдэг байлаа. Тэр надаас Есүсийн хүч чадлын талаар асуудаг байсан. Есүс Христ бүх хүч чадлыг эзэмшдэг учраас тэр зөв шударга байдалд ямар ч зүйлийг хийж чадна хэмээн би түүнд хариулдаг байж билээ. Аврагч хүүгийн маань баатар байв.

Гэвч хүү маань 13 настай байхдаа сэтгэцийн гүн хямралд орсон юм. Түүнд ярих эсвэл хоол идэх хүсэл ч байхгүй болсон байлаа. Тэр өмнө нь хийдэг байсан үйл ажиллагаануудаа сонирхохоо больж, тэр ч байтугай гэр бүлээрээ залбирахыг ч эсвэл гэр бүлийн үдэшт оролцохыг ч хүсдэггүй байлаа. Тэр сүмд эсвэл сайн мэдээнд ямар ч сонирхолгүй болсон юм шиг байсан.

Гэр бүлийнхэн маань ойр ойрхон түүний төлөө залбирч мөн мацаг барьдаг байсан бөгөөд тойрог болон гадасны ах эгч, найз нөхөд, хамаатнууд маань ч бидэнтэй адил үйлддэг байлаа. Бидний хүчин чармайлт хүүгийнхээ төлөө залбирч байгаа ахмад Алмагийнхтай төстэй санагдаж байв (Мозая 27:14, 22–23-ыг үзнэ үү).

Бид сайн мэдээг хүүдээ тулгахыг хүсээгүй бөгөөд тэрээр гэр бүлийн залбиралд юм уу гэр бүлийн үдэшт оролцох албагүй, гэхдээ түүнийг бидэнтэй хамт оролцоосой гэж хүсдэг болохоо бид түүнд хэлсэн юм. Бид “. . . хүүхдүүд чинь адислагдаж болохын тулд, гэр бүлдээ Эцэгт хандан миний нэрээр үргэлж залбир” (3 Нифай 18:21) гэсэн Аврагчийн үгсийг дагах үед гэр бүлийн залбирал болон гэр бүлийн үдэш


маань илүү хүчирхэг болдог байсан юм. Бид гэртээ Сүнс мэдэрдэг байв. Хэдийгээр хүү маань чимээгүй суудаг боловч бидэнтэй хамт байдаг байлаа.

Үүнээс хойш хоёр жилийн хугацаанд бидний залбирлууд болон гэр бүлийн үдшүүд хүүд маань бага багаар нөлөөлж байгааг бид мэдсэн. Нэг гэр бүлийн үдшийн үеэр хүү маань Аврагчийн тухай гэрчлэлээ хуваалцаж мөн дараагийн гэр бүлийн үдшийг бэлтгэж болох уу гэж асуув. Тэрээр гэр бүлээрээ залбирахад оролцож мөн сүмд дуртайяа явдаг болов. Тэр Аврагчийн гэтэлгэгч хайрыг мэдрэхийн хэрээр зүрх сэтгэлийн хүчиг өөрчлөлтийг амссан юм (Алма 5:26-г үзнэ үү). Их Эзэн Өөрийнхөө эдгээх хүчээр хүүг маань үнэхээр аварсан билээ.

Хүү маань дахин баяр хөөртэй, эрч хүчтэй болж, бусдад тусалж мөн хайраа үзүүлэх хүсэлтэй болж эхлэв. Аврагч өөрийг нь эдгээсэн гэдгийг мэддэг гэдгээ тэр надад хэлсэн юм. Хүүгийн маань бэрхшээл түүнд Аврагчийн талаарх гэрчлэлээ хүчирхэгжүүлэн, Түүнийг хайрлах хайраа мөн Түүнд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд нь тусалсан юм. Тэр номлогч болж, Аргентиний Буэнос Айрес өмнөд номлолд Их Эзэнд үйлчилсэн билээ. Номлолоос эргэж ирснийхээ дараа тэрээр эхнэртэйгээ ариун сүмд гэрлэсэн бөгөөд тэд нэг гайхалтай охинтой болсон.

Аврагчид эдгээх, гайхамшиг бүтээх мөн биднийг энэ амьдралд болон ирэх амьдралд аз жаргалтай болгох хүч байдгийг би мэднэ. ■ Чили, Сантиаго, Ана Кремаши Занарту

Хүү маань 13 настай байхдаа сэтгэцийн гүн хямралд орсон бөгөөд гэр бүлээрээ залбирахыг ч эсвэл гэр бүлийн үдэшт оролцохыг ч хүсдэггүй байлаа.



## ТА МОРМОН УУ?

**Б**и гэрээсээ хол ажлын шугамаар олон улсын нэгэн чуулганд оролцож байв. Хэдэн зуун хүн оролцсон боловч би муж, бүс нутгаасаа ганцаараа оролцсон юм.

Нэг орой бүх оролцогчид зориулсан оройн хоол боллоо. Бид зоогийн танхимд ороод согтууруулах ундаа үнэгүй захиалах дөрвөн тасалбар хүлээн авав. Гэрээсээ хол байгаа хүний хувьд энэ боломжинд уруу татагдах нь маш амархан бөгөөд нэг ч хүн энэ талаар мэдэхгүй шүү дээ гэсэн бодол надад төрж билээ. Гэвч энэ нь хоромхон зуурын бодол байсан бөгөөд би тасалбаруудыг хаалган дээр зогсож байсан хүнд буцааж өгсөн юм.

Энэ оройн хоолны үеэр би үл таних долоон хүнтэй хамт нэг ширээнд суусан. Бид хоол идэн, инээлдэж мөн ажилд маань тус болох мэдээлэл солилцох үедээ би ус л ууж байлаа.

Маргааш өглөө нь би нэг ширээнд сууж байсан залуутай

тааралдаж, мэндэллээ. Түүний нэрийн тэмдгийг хараад түүнийг миний төрсөн хотоос ирсэн болохыг мэдээд миний сэтгэл их хөдлөв. Би төрсөн хотоосоо гараад 35 жил болж байна. Би ахлах сургуулиа төгссөний дараа их сургууль, гэрлэлт гэх мэт зүйлүүдээс болж гэрээсээ өөр тийшээ нүүсэн юм.

Бид хоёр мэддэг газар, болсон үйл явдлуудын талаар ярилцах зуур тэрээр гэр бүлийг маань тэр хотдоо одоо болтол байдаг эсэхийг асуув. Тэнд гэр бүлээс маань хүн байхгүй боловч миний олон сайн найз байдаг ба тэдэнтэйгээ одоо болтол холбоотой байдгаа би түүнд хэлэв. Тэр найзуудын маань нэрийг асууж, би тэдний заримыг нь нэрлэж эхлэв.

Эхний хэдэн хүний нэрийг хэлсний дараа тэр намайг түр зогсоогоод “Байзаарай, та Мормон уу? Таны нэрлэсэн хүмүүс бүгд мормончууд” гэж хэллээ.

Намайг хожмын үеийн гэгээнтэн гэдгээ хэлэхэд тэр миний найзуудыг

ямар сайн иргэд болохыг мөн тэд амьдарч буй газартаа үйлчилж, бүх хүнд сайн жишээ үзүүлдэг тухай надад хэлсэн юм. Хэсэг хормын туршид тэрээр сүмийг болон миний найзуудыг үнэлж явдгаа, тэдгээр нь нийгэм дэх сайн сайхан зүйлүүдийн төлөө хэрхэн бат зогсож байсан тухай надад хэлсэн юм.

Бид салцгаах үед хэрэв би согтууруулах ундаа уух тасалбаруудыг хэрэглэхээр шийдсэн байсан бол юу болох байсан бол гэдэг бодол надад төрж байлаа. Миний нэр дурдсан хүмүүс надад зөвийг сонгохыг заасан. Хэрэв би тасалбаруудыг ашигласан байсан бол би өөрийгөө сүмийн гишүүн гэж хэлэхээсээ эвгүйцэж мөн ичих байсан.

Хүүхэд ахуй үеийн минь гэрээс 2 000 бээр (3 220 км) зайд, 35 жилийн дараа зохистой, идэвхтэй, бусдад үйлчилдэг тэдгээр найзуудынхаа жишээнд би хэчнээн их талархалтай байна вэ. ■

АНУ, Хойд Каролина, Кэрл А.Боус



**Б**ид зоогийн танхимд ороод согтууруулах ундаа үнэгүй захиалах дөрвөн тасалбар хүлээн авав.



# БОШИГЛОГЧ МИНИЙ ЗАЛБИРАЛД ХАРИУЛСАН

Хоёрдугаар курс төгсөх жилээ би их сургуулийнхаа график дизайны хөтөлбөрт бүртгүүлсэн юм. Би тэнцээгүй боловч дараа жил дахин бүртгүүлэх боломжтой байлаа. Би сургууль төгсөхийн тулд дахин нэг жил хүлээнэ гэхэд тийм ч баяртай байсангүй.

Миний сонгосон мэргэжилтэй хамгийн ойр зүйл нь гэрэл зураг байлаа. Би мэргэжлээ солих талаар залбирсан ба надад сайхан мэдрэмж төрсөн юм. Би зүгээр л эрдмийн зэргээ авахыг л хүсэж байлаа!

Хичээлийн жилийн намрын улирлын эхэнд би кино ба гэрэл зургийн нийгмийн түүхийн хичээлүүдийг сонгосон. Би эдгээр хичээлд суух болсондоо баяртай байлаа. Би киноны ангийн хичээлийн хөтөлбөрийг хараад энэ хичээл дээр оюутнууд олон зохисгүй кино үзэх шаардлагатай байдгийг анзаарав. Гэрэл зургийн хичээлийн багш маань бид гэмт хэргийн болон харгис хэрцгий мөн эротик зургуудыг судлах болно, өнөө үеийн гэрэл зураг гэж эдгээрийг л хэлнэ гэлээ.

Юу хийх талаараа бодох үед зүрх маань хөндүүрлэж байв. Сайн мэдээ ийм зүйлүүдийн эсрэг зүйл заадгийг би мэдэж байсан ч эдгээр хичээлд зайлшгүй суух шаардлагатай байлаа. Би дэлхийд байвч дэлхийнх бус байх тухай заадаг судрын талаар бодлоо (Иохан 15:19-ийг үзнэ үү). Би эдгээр хичээлд суусан ч тэдгээрт автахгүй байж чадах болов уу?

Би юу хийхээ болон зөв зүйлийг хийх итгэлийг олж авахын төлөө залбирав. Би бас эхнэртэйгээ болон эцэг эх, ахтайгаа зөвлөсөн. Ахтайгаа ярих үед тэрээр надад “Учир нь хүн бүх дэлхийг олж авсан ч амиа алдвал ямар ашиг байх билээ? Эсвэл амийнхаа оронд юугаа өгөх билээ?” (Матай 16:26) гэсэн шүлгийг сануулсан юм.

Боловсрол чухал гэдгийг би мэдэж байсан ч би буруу мэргэжил сонгосон юм болов уу? Төгсөлт ойртоод хонгилын үзүүрт гэрэл ойрхон харагдаж байхад би яаж сургуулиа-саа завсардаж чадах билээ?

Нэгэн орой өвчтэй нялх хүүхдээ асарч байхад минь надад интернэтээр ерөнхийлөгч Томас С.Монсоны тухай уншъя гэсэн бодол төрлөө. Удалгүй би ерөнхийлөгч Томас С.Монсоны 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг сонсов. Нийгмийн ёс суртахууны луужин доройтож, зохистой бус болон ёс бус зан авирыг олон хүн хүлээн зөвшөөрч байна хэмээн түүнийг хэлэх үед би анхааралтай сонсож байлаа.

Тэгээд тэрээр: “Бид сүнсэлг зүйлээс дэндүү холдсон дэлхийд сонор сэрэмжтэй байх ёстой. Бидний жишигт нийцэхгүй аливаа зүйлсээс

татгалзах нь маш чухал. Учир нь тэдгээр нь бидний хамгийн их хүсдэг Бурханы хаант улс дахь мөнх амьдралыг хүлээн авахад саад болдог” гэсэн миний сонсох хэрэгтэй байсан зүйлийг хэлсэн юм.<sup>1</sup>

Эдгээр үгс миний дотор агуу хүчээр нэвтрэн орлоо. Нулимс хацрыг минь даган урсах үед би амьд бошиглогч миний залбиралд хариулсныг мэдсэн юм.

Хэдийгээр би төгсөлтөө хойшлуулсан ч гэсэн бид бошиглогчийг дагаж, дэлхийн үзэл бодлыг эсэргүүцэн, зарлигуудыг дуулгавартай сахиж мөн сайн мэдээний жишгүүдийг дэмжих үед Их Эзэн гэр бүлийг маань болон намайг адисална гэдгийг би мэднэ. ■

АНУ, Миссури, Дэррик Фийлдс

## ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон “Ариун газруудад зогсогтон” *Лиакхона*, 2011 оны 11-р сар, 83.

Нэгэн орой өвчтэй нялх хүүхдээ асарч байхад минь надад интернэтээр ерөнхийлөгч Томас С.Монсоны тухай уншъя гэсэн бодол төрлөө.





**Бишоп  
Жэралд Коссэй**  
Тэргүүлэх Бишопын  
нэгдүгээр зөвлөх

# АЗ ЖАРГАЛД

## ХҮРГЭХ ЗАМЫГ ДАГА

**Е**рөнхийдөө өсвөр нас бол хувийн төлөвлөгөө гаргахад хамгийн тохиромжтой үе юм. Бид бүгдээрээ хүүхэд ахуй үедээ янз бүрийн зүйл мөрөөддөг. Залуучууд та нар ирээдүйнхээ төлөө мөрөөдөлтэй бай! Энэхүү мөрөөдөл нь спортод амжилт гаргах, урлагийн шилдэг бүтээл туурвих; ажилч хичээнгүй, шаргуу хөдөлмөрөөрөө нарийн мэргэжил, өндөр боловсрол эзэмших найдвар бүхий байж болно. Ирээдүйд сайн нөхөр, сайн эхнэр болох, гадаад төрх байдалдаа болон биеэ зөв авч явахад анхаарах, зан төлөвийн шилдэг чанаруудыг эзэмших, гэр бүлийг тань адислах сайхан хүүхдүүдтэй болох гээд олон сайхан зүйлийг та нар оюун ухаандаа төсөөлөн бодож болно.

Та нарын мөрөөдлөөс хэд нь биелэгдэх бол? Амьдрал тодорхой бус зүйлээр дүүрэн байдаг. Амьдралын замд санаандгүй явдал өчнөөнөөрөө гарч ирэх болно. Амьдралын чинь зүг чигийг агшин зуурт өөрчлөх чухал мөчүүд ч гарч ирнэ. Ийм мөчүүд нь гадна үзэмж, харилцан яриа эсвэл төлөвлөөгүй үйл явдал гэх мэт зүйлүүдээс бүрдэж болно. Номлолд үйлчлэх насны талаар ерөнхийлөгч Томас С.Монсоны хийсэн саяхны мэдэгдэл шиг шинэ боломжууд ч та нарын амьдралд гарч ирэх болно.<sup>1</sup> Заримдаа амьдралын зүг чиг өөрчлөгдөх явдал нь гэнэтийн бэрхшээлүүдээс эсвэл урам хугарахаас ирдэг.

Ихэнх хүмүүс тодорхой бус зүйлд дургүй байдаг. Итгэл дутагдах, янз бүрийн байдлаар ирээдүйгээс айх нь тодорхой бус байдлыг бий болгодог. Зарим хүмүүс нэг удаа бүтэлгүйтсэнээсээ болоод айж, шинэ сайхан боломж олдсон үед ч гэсэн эргэлздэг. Жишээ нь, ийм хүмүүс гэрлэж, гал голомтоо бадраан, өрх гэрээ төвхнүүлэхийг болон боловсролтой болохыг хойшлуулдаг эсвэл тогтвортой ажил мэргэжилтэй болж, бие даан амьдрахын оронд “зүгээр сууж, цаг нөгчөөн,” эцэг эхийнхээ гэр орны ая тухтай байдалд сэтгэл нь хоргоддог.

Биднийг хазаарладаг өөр нэг үзэл баримтлал бол: “Ид, уу, мөн баяс, учир нь маргааш бид үхнэ” (2 Нифай 28:7) гэсэн “дэлхийн мэргэн” ухаан юм. Энэ үзэл баримтлал нь ирээдүйн үр дагаврыг огтхон ч бодохгүйгээр тэр даруй наргиж, цэнгэхийг өөгшүүлэн дэвэргэдэг.

### Аз жаргалд хүргэх замыг дага

Айдас, эргэлзээ, амин хувиа бодсон зугаа цэнгэлийн зам нь амьдрал дахь амар амгалан байдал, итгэл найдвар авчирдаг замаас өөр юм. Та нар амьдралынхаа бүх нөхцөл байдлыг хянаж чадахгүй ч аз жаргалдаа хяналт тавьж чадна. Та нар бол аз жаргалынхаа уран барилгачид.

Та нарын аз жаргал бол ихэнхдээ таны сүнслэг байдлын алсын хараа, амьдралаа дээр нь суурилуулдаг

**Та нарын аз жаргал амьдралын тань гадаад нөхцөл байдлаас биш харин та нарын дагахаар сонгосон зарчмуудаас ихээхэн хамаарах болно.**

зарчмуудын үр дүн мөн. Хүсэн хүлээгээгүй сорилт бэрхшээлүүд дэлхий дээрх аялалуудын тань үед гарцаагүй тохиолдох хэдий ч эдгээр зарчмууд та нарт аз жаргал авчрах болно. Би эдгээр нэн чухал зарчмуудаас заримынх нь талаар та бүхэнтэй ярилцахыг хүсч байна.

### 1. Өөрийнхөө үнэ цэнийг ухаарч ойлго

Саяхан би гэр бүлийнхээ хамт өмнөд Францад хэд хоног амарлаа. Нэг орой нар жаргаж, хөдөө нутгийг харанхуй нөмөрсөн үед би байшингийнхаа гаднах сандал дээр хэсэг тайван хэвтэж амрахаар шийдэв. Орчныг харанхуй нэлд нь нөмөрсөн учраас эргэн тойрондоо





Ямар хүн  
болох ёстой,  
тийм л хүн  
бол.

Бурханы  
амлалтуудад  
ИТГЭ.

Өөрийнхөө  
үнэ цэнийг  
ухаарч ойлго.

байгаа юмсыг ялган таних аргагүй байв. Тэнгэр өөд хараа бэлчээн ширтлээ. Эхлээд харахад тэнгэр түнэр харанхуй байлаа. Тэнгэрт гэнэт гэрэл гялсхийв, дараа нь хоёр тэгээд гурван удаа гэрэл гарлаа. Аажимдаа миний нүд харанхуйд дасч, жирвэлзэн анивчих үй түмэн одыг ширтэн байлаа. Би харанхуй тэнгэр Сүүн зам болон хувирлаа хэмээн бодож байв.

Хязгааргүй орчлон хорвоогийн тухай бас энэхүү агуу ертөнцтэй харьцуулахад миний бие хэчнээн өчүүхэн болохыг тунгаан бодоод би өөрөөсөө “Энэхүү агуу ертөнцийн өмнө би гэгч ер нь юу юм бэ?” гэж асуулаа. Тэгтэл нэг судар санаанд орж ирэв.

“Таны мутрын бүтээл болох Таны тэнгэрүүдийг, Таны цогцлоон байгуулсан сар, оддыг би тунгаан бодохдоо

“Хүн гэгч юу болоод Та түүнд санаа тавьж, Хүний хүү гэгч юу болоод Та түүнийг халамжилна вэ? (Дуулал 8:3–4).

Энэхүү тайтгаруулагч өгүүлбэрийн араас залган:

“Та түүнийг Бурханаас арай дор болгож, алдар ба хүндэтгэлийн титмийг түүнд өмсгөжээ” (Дуулал 8:5) гэсэн судрын эшлэл санаанд минь орлоо.

Энэ бол ер бусын зүйл бөгөөд Бүтээлтийн гайхамшиг. Орчлон ертөнц хэмжээ хязгааргүй ч, бид бүгд Бүтээгчийн мэлмийд өөр өөрийн онцлог, өөр өөрийн алдар хийгээд



үнэ цэнэтэй юм. Миний бие үл мэдэгдэм өчүүхэн ч миний хувь хүний үнэ цэнэ Тэнгэрлэг Эцэгт минь хэмжээлшгүй чухал юм.

Бурхан биднийг мэддэг, бүр нэг бүрчлэн хайрладаг гэдгийг мэдэх нь бидний амьдралыг гийгүүлж, утга учиртай болгодог гэрэлтэй адил юм. Намайг хэн байлаа ч гэсэн, надад найз нөхөд байна уу, үгүй юү эсвээс би нэрд гарсан уу үгүй юү, бусад хүмүүс намайг хавчдаг уу эсвэл эсэргүүцдэг үү гэдэг нь хамаагүй, Тэнгэрлэг Эцэг минь надад хайртай гэдэгт би төгс итгэлтэй байдаг. Тэр надад юу хэрэгтэй байгааг мэдэж, надад тулгарч байгаа асуудлуудыг ойлгон, намайг адислахын төлөө санаа тавьдаг.


Бурхан та нарыг хэрхэн хардаг шиг өөрсдийгөө нэг төсөөлж хараад үз дээ. Хэрэв та нарыг Бурхан хайрлаж, энэрэн, та нарт итгэдэг шиг та нар өөрсдийгөө хайр, энэрэл, итгэлээр харж, юу болохыг төсөөлбөл энэ нь ямар утга учиртай зүйл байх бол? Мөнхийн чадавхыг тань Бурхан хэрхэн ойлгодог шиг тийм байдлаар ойлгохын тулд та нарын амьдралд нөлөөлөх нөлөөллийг төсөөлөн бодоод үз дээ.

Бурхан байдгийг би гэрчилж байна. Түүнийг хайгтун! Эрж хайж, судлагтун. Залбирч, асуу. Бурхан Өөрийн оршихуйн тухай, Тэр та нарыг үнэхээр хайрладаг тухай үнэн бодитой тэмдгүүдийг илгээх болно гэдгийг би та нарт амлаж байна.

## **2. Ямар хүн болох ёстой, тийм л хүн бол<sup>2</sup>**

Энэ өгүүлбэр хачирхалтай сонсогдож болох юм. Би ямар хүн болдгоо аль хэдийн болчихоод байхад одоо яаж өөрчлөгдөх юм бэ? Би энэ зарчмыг нэг түүхээр дамжуулан тайлбарлахыг хичээе.

Би саяхан *Ухаан суусан нас* нэртэй нэг кино үзлээ. Энэ кино амсхийх завгүй амьдралтай,



**Тэр захидалд “Өөртөө хандсан миний үгс: Миний хамгийн агуу хүсэл бол Аврагч, Есүс Христийн шавь байх явдал гэдгийг та санах болно гэдэгт би итгэлтэй байна гэсэн үгс байх болов уу.**

дэлхийг тойрон аялж, олон хурал зөвлөгөөнд оролцдог, нэрд гарсан банкны эзэн Маргэритын тухай өгүүлдэг. Түүнийг хайрладаг нэгэн байсан ч тэр гэрлэх, үрийн зулай үнэрлэх зав алга гэдэг байв.

Тэр 40 хүрсэн үедээ нэгэн учир битүүлэг захидал хүлээн авчээ. Уг захидалд: “Өөртөө хандсан миний үг. Өнөөдөр би долоон нас хүрлээ. Тэгээд би энэ захидлыг долоон настайдаа хийсэн амлалтуудаа санахад туслахын тулд бас би ямар хүн болохыг хүсдэг байснаа сануулахын тулд энэ захидлыг танд бичиж байна” хэмээн өгүүлжээ. Маргэрит энэ захидлыг өөрөө, долоон настай байхдаа бичсэнээ гэнэт санажээ. Бяцхан охин нэлээд олон хуудсанд багтаан, амьдралын зорилгоо нарийн тодорхой дүрсэлсэн байв.

Тэрээр бяцхан охин байхдаа ямар хүн болохыг хүсдэг байсан нь одоо ямар хүн болсонтой нь огт төсгүй байгааг Маргэрит ойлгов. Тэрээр бяцхан охин байхдаа ирээдүйд ямар хүн болохыг зөгнөсөн шиг тийм хүн болж өөрчлөгдөхийн тулд амьдралаа маш няхуур төлөвлөн, үндсээр нь өөрчлөхөөр шийдсэн байна. Тэрээр гэр бүлтэйгээ эвлэрч,

үлдсэн амьдралаа тусламж хэрэгтэй хүмүүст үйлчлэхэд зориулахаар шийджээ.<sup>3</sup>

Хэрэв та нар өнгөрсөн үеэсээ захидал хүлээж авбал түүнд юун тухай өгүүлэх байсан бол? Мартагдсан боловч үнэн бодит өнгөрсөн үеэсээ чи өнөөдөр захидал хүлээн авбал энэ нь амьдралд чинь хэрхэн нөлөөлөх бол?

Тэр захидалд “Өөртөө хандсан миний үгс: Би ямар хүн болохыг хүсдэг байснаа танд сануулахын тулд захидал бичиж байна. Миний хамгийн агуу хүсэл бол Аврагч, Есүс Христийн шавь байх явдал гэдгийг та санах болно гэдэгт би итгэлтэй байна. Би Түүний төлөвлөгөөг дэмждэг, тиймээс дэлхий дээр байхдаа Түүнд, Түүний авралын ажилд туслахыг хичээх болно. Би бас үүрд мөнх хамт амьдрах гэр бүлийн гишүүн болохыг хүсдэгийг санаарай” гэсэн үгс байх болов уу.

Амьдралд тохиолддог агуу адал явдлуудын нэг бол өөрсдийгөө үнэхээр ямар хүн болох, хаанаас ирснээ олж мэдэх мөн өөрсдийгөө Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгийг мэдэх үнэний мэдлэгтэйгээ



болон өөрсдийнхөө энд байгаагийн зорилготой нийцүүлэн амьдрах явдал юм.

### 3. Бурханы амалтуудад итгэх

Бошиглогч Малахийн сургаал бол сайн мэдээний сэргээлтийн гол төвд байдаг: “Мөн тэрээр эцгүүдэд нь хийсэн амалтуудыг хүүхдүүдийнх нь зүрх сэтгэлд суулгах болно, мөн хүүхдүүдийнх нь зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэх болно” (Иосеф Смит—Түүх 1:39) гэсэн билээ. Та нар сэргээлтийн ачаар амалтын хүүхдүүд болсон билээ. Та бүхэн эцгүүдэд тань хийсэн амалтуудыг хүлээн авах болно.

Патриархын адислалаа дахин дахин уншиж бай. Их Эзэн энэ адислалд Израилын арванхоёр овгийн нэгэнтэй нь таныг холбосон байгааг баталдаг. Иймээс та нар итгэл бишрэлээрээ дамжуулан Абрахам, Исаак, Иаков нарт амлагдсан үй олон агуу адислалыг өвлөгчид болсон билээ. “Учир нь энэ Сайн мэдээг

хүлээн авах болгон нь [түүний] нэрээр дуудагддаг байх болно мөн, [түүний] үр удам хэмээн тооцогддог байх болно, мөн босч зогсоод, тэдний эцгийн хувьд, [түүнийг] магтан дуулах болно” (Абрахам 2:10) хэмээн Бурхан Абрахамд амласан юм.

Эдгээр адислал үнэн бодитой юм. Хэрэв бид өөрсдийн үүргийг биелүүлбэл Бурхан бас хүлээсэн үүргээ биелүүлэх болно. Нөгөө талаар та нарын амьдралд тохиолддог юм бүхэн та нарын хүсэн хүлээсний дагуу болдоггүйг эдгээр амалт харуулдаг. Бурхан үүний оронд та нарын амьдралд тохиолдох зүйлс Түүний хүслийн дагуу байх болно гэдгийг амладаг. Амьдралдаа бидний хүсч болох хамгийн агуу зүйл бол өөрийнхөө хүслийг Их Эзэний хүсэлд захируулж, бидний амьдралд зориулсан Түүний төлөвлөгөөг хүлээн авах явдал мөн. Тэрбээр бүх зүйлийг эхлэлээс мэддэг бөгөөд бидэнд байдаггүй

мэргэн ухаан Түүнд байдаг. Тэр биднийг хэмжээлшгүй хайр энэрлээр хайрладаг билээ.

Энэ зарчмыг би өөрийн туршлага дээр үндэслэн тайлбарлая. Би бага байхдаа Францын бизнесийн шилдэг сургуулиудын элсэлтийн шалгалтад бэлтгэхээр шийдсэн. Бүтэн жил үргэлжилсэн энэхүү бэлтгэл надад яггүй хүнд сорилт болсон бөгөөд өдөр бүр шаргуу хичээллэх шаардлагатай байдаг байлаа. Би тэр жилийн эхээр элсэлтийн шалгалтад бэлтгэхэд хэчнээн хүнд байлаа ч гэсэн ням гаргийн цуглаануудыг болон долоо хоногт нэг удаа хичээллэдэг байсан институтийн хичээлийг ганц ч удаа таслахгүй байхаар шийдсэн юм. Тэр ч байтугай би залуучуудын тойрогт бичиг хэргийн ажилтнаар үйлчлэхийг зөвшөөрөв. Энэ ажилд долоо хоног бүр нэлээн хэдэн цаг зориулагд байлаа. Их Эзэн миний итгэлтэй байдлыг мэдэж, зорилгоо биелүүлэхэд надад туслах болно гэдэгт би үргэлж итгэлтэй байв.

Жилийн эцэс болж, шалгалт ойртсон үед би чадах бүхнээ хийсэн юм шиг санагдаж байлаа. Тэгээд улам шаргуу залбирч, мацаг барьж эхэллээ. Тэгээд хамгийн их нэр хүндтэй нэгэн сургуульд шалгалт өгөхөөр ирсэн үедээ Их Эзэн миний хүсэлтэд хариулна гэж итгэл дүүрэн байлаа. Харамсалтай нь, үйл явдал миний найдаж байснаас эсрэгээр эргэх нь тэр. Би хамгийн сайн бэлтгэсэн хичээлээрээ өгсөн аман шалгалтдаа доогуур дүн аваад сэтгэлээр маш их унасан юм. Их Эзэн намайг ийм их итгэлтэй байхад яаж хаяж чадаж байна аа?

Миний жагсаалтын хоёрдугаарт байсан өөр нэг сургуульд аман шалгалт өгч байх үеэр эргэлзээ, тодорхойгүй байдал намайг эзэмдлээ. Энэ сургуулийн хамгийн хүнд гэж

**Тэр өдөр би хамгийн өндөр дүн авч, тэр сургуульд хүндэтгэлтэйгээр элсэн орж билээ.**



тооцогддог шалгалтыг сургуулийн захирал нь удирдан, шалгалтын комисс 45 минут ярилцлага хийж авдаг байсан. Ярилцлага эхэндээ хэвийн байлаа. . . . Тэгтэл ач холбогдол багатай юм шиг санагдсан дараах асуулыг надаас асуув: “Та энэ шалгалтад сайн бэлтгэсэн нь харагдаж байна. Гэвч та хичээлээсээ гадуур ямар үйл ажиллагаануудад оролцдогийг бид сонирхож болох уу?”

Миний зүрх түт түт цохилоод явчихлаа! Бүтэн жилийн турш би шалгалтад бэлтгэх, сүмд явах гэсэн ердөө хоёрхон зүйлийг л хийсэн шүү дээ! Шалгалтын комисс миний сүмийн гишүүнчлэлд сөргөөр хандах вий гэж айсан ч секундын дараа би баримталдаг зарчмууддаа үнэнч байхаар шийдлээ.

Тиймээс “Би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн” гэж хэлээд сүмд өөрийн оролцдог бүх үйл ажиллагаа болох хүндэтгэлийн өдрийн цуглаан, институтын хичээл, тойргийн бичиг хэргийн ажилтны үүрэг хариуцлага зэргийн тухай 15 минут орчим яриу. Намайг яриагаа дуусгахад сургуулийн захирал:

“Би залуудаа Нэгдсэн Улсад сурч байсан. Миний хамгийн сайн найз нарын нэг нь Мормон байлаа. Тэр найз маань хүний мөсөөр тун сайн, гайхалтай сайхан залуу байсан. Би мормончуудыг тун сайн хүмүүс гэж боддог” гэж ярилаа.

Тэр өдөр би хамгийн өндөр дүн авч, тэр сургуульд хүндэтгэлтэйгээр элсэн орж билээ.

Би ач ивээлийнх нь төлөө Их Эзэнд талархал илэрхийлэв. Тэр сургуульд орох миний мөрөөдөл биелэгдээгүй нь гайхамшигтай адислал болж хувирсныг ойлгоход надад хэдэн жил хэрэгтэй болсон юм. Хоёр дахь сургуульдаа би маш чухал хүмүүстэй танилцсан юм. Тэдэнтэй тогтоосон харилцаа миний

ажил мэргэжилд ч миний амьдралд болон гэр бүлийн минь амьдралд ч онцгой чухал байсан, бүр өнөөдрийг хүртэл чухал хэвээр байгаа билээ.

Та нарыг чадах бүхнээ хийсний эцэст юмс та нарын найдсанаар буюу хүсэн хүлээснээр болохгүй бол Тэнгэрлэг Эцэгийнхээ хүслийг хүлээн авахад бэлэн бай. Тэрбээр бидний сайн сайхны төлөө биш ямар ч зүйлийг биднээр хийлгэхгүй. “Бүх маханбодь миний мутарт байна; хөдөлгөөнгүй байж мөн Би бол Бурхан гэдгийг мэдэгтүн” (С ба Г 101:16) хэмээн бидний чихэнд шивнэх тайтгаруулагч дуу хоолойг анхааралтай сонсогтун.

### **Та нарын ирээдүй та нарын итгэл лугаа адил гэрэл гэгээтэй**

Эхнэр Валеритайгаа өнгөрүүлсэн амьдралынхаа замналыг тунгаан бодох тусам бид хоёр залуу наснаасаа мөнх амьдралын үзэл бодлоо хуваалцаж ирсэн нь бидний амьдралд өөрчлөлт гаргасан юм гэдэгт би төдий чинээ бат итгэлтэй байдаг билээ. Бид хоёр мөнхийн гал голломтоо бадраахыг хүсдэг байв. Бид юуны учир дэлхий дээр байгаагаа, бидний үүрд мөнхийн зорилго юу болохыг мэддэг байлаа. Бурхан бидэнд хайртайг, бид Түүний мэлмийд агуу үнэ цэнэтэйг мэддэг байлаа. Тэр бидний залбиралд Өөрийн арга замаар, сайн гэж бодсон цагтаа хариулах болно гэдэгт бид бат итгэдэг байсан юм.

Түүний хүслийг хүлээн авах гэдэг нь бид ямар нэг зүйлд суралцах, цааш нь үргэлжлүүлэн байнга суралцах явдал учраас бид Түүний хүслийг хүлээн авахад бэлэн байсан эсэхээ би мэдэхгүй. Гэхдээ бид Түүнийг дагаж, Түүнд бие сэтгэл бүхнээ зориулахын тулд чадах бүхнээ хийхийг хүсдэг байсан.

Ерөнхийлөгч Монсоноор

удирдуулж байгаа үед та нарын “ирээдүй та нарын итгэл лугаа адил гэрэл гэгээтэй”<sup>4</sup> байх болно гэдгийг би гэрчилж байна. Та нарын аз жаргал амьдралын тань гадаад нөхцөл байдлаас биш харин та нарын дагахаар сонгосон зарчмуудаас ихээхэн хамаарах болно. Эдгээр зарчмуудад итгэлтэй байгтун. Бурхан та нарыг мэднэ, бас Тэр та нарт хайртай. Хэрэв та нар Түүний мөнхийн төлөвлөгөөнд нийцүүлэн амьдрах юм бол, хэрэв та нар Түүний амлалтуудад итгэлтэй байх юм бол ирээдүй тань гэрэл гэгээтэй байх болно!

Та нарт мөрөөдөл, зорилго байдаг уу? Тийм бол сайн байна! Мөрөөдөл, зорилгодоо хүрэхийн төлөө бүх зүрх сэтгэлээ зориулан ажилла. Үлдсэнийг нь Их Эзэн хийх болно. Тэрбээр та нарт хийж чадахгүй зүйлийг тань хүртэл зааж өгөх болно.

Бүх цаг үед Түүний хүслийг хүлээн авч, биелүүлдэг бай. Тэр та нарыг хаашаа явахыг хүснэ, тийшээ явж, та нараас юу хийхийг хүснэ, түүнийг нь хийж бай. Тэрээр та нарыг ямар хүмүүс болоосой гэж хүсдэг шиг тийм л хүмүүс болцгоо.

Энэ амьдрал бол үүрд мөнхийн нэгэн гайхамшигтай үе гэдгийг би гэрчилж байна. Бид Бурхантай уулзахаар бэлтгэх агуу зорилгын тулд энэ дэлхий дээр байгаа билээ. ■

*2012 оны 11-р сард Солт Лэйк хотын табернеклад болсон СВС-ийн онцгой цугларалт дээр хэлсэн үгээс авав. Бүрэн эхээр нь уншихыг хүсвэл [lds.org/broadcasts](http://lds.org/broadcasts) хаягаар орно уу.*

### **ЭШЛЭЛҮҮД**

1. Томас С.Монсон “Ерөнхий чуулганд тавтай морилно уу,” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 4–5-ыг үзнэ үү.
2. Энэ хэллэг нь Грекийн хамгийн алдартай яруу найрагчдын нэг Пиндараас үүсэлтэй гэж үздэг. Пиндар, *Pythian* 2.72, in *Olympian Odes, Pythian Odes*, ed. and trans. Виллиам Х.Рэйс (1997), 239.
3. *L'âge de raison (With Love . . . from the Age of Reason)*, Яан Самуэлийн найруулсан (2010), сүүдэр шийг үзнэ үү.
4. Томас С.Монсон, “Зоригтой бай,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 92.



# Сайн мэдээг интернэтээр

хуваалцах нь

**Мариа Махонри-Иггразил  
Ардуо Андака**

**Б**и сайн мэдээг найзуудтайгаа хуваалцахдаа үргэлж зоригтой байдаг байгаагүй. Тэдний олонх нь манай шашны талаар мэддэг байсан ч би гэрчлэлээ хуваалцахын тулд хэзээ ч илүү зүйлийг хийж байгаагүй. Гэсэн хэдий ч хэн нэгэн нь сүмийн тухай буруу ойлголттой байвал би үүнийг засахын тулд чадах бүхнээ хийдэг байсан.

Би их сургуульд ороод мэтгэлцээний клубт нэгдсэн юм. Мэтгэлцээний дараа “мормончууд”-ын талаар тэдний ярьсан нэг зүйлийг залруулах үед бусад гишүүд намайг хожмын үеийн гэгээнтэн гэдгийг олж мэдсэн юм. Би өмнө нь шашныхаа талаар хэзээ ч ярьж байгаагүй бөгөөд тэр өдөр тэд надаас маш олон асуулт асуусан. Би айсан байсан бөгөөд асуултад хариулахаас бараг л зайлсхийж байлаа. Би итгэдэг зүйлээ мэддэг байсан ч үүнийгээ яаж хуваалцахыг мэдэхгүй байсан юм. Би залбирсан боловч хариулт ирэх шинжгүй байлаа.

Хэдэн өдрийн дараа би фэйсбүк үзэж байгаад сүмийн удирдагч маань LDS.org дээр нэг өгүүлэл тавьсан байхыг харсан юм. Үүнийг хараад би бас сүмийн зүйлүүдийг хуудас дээрээ тавьж болох юм гэдгийг анзаарсан. Би мэтгэлцээний багийн асуусан сэдвүүдийг хайж олоод өөрийнхөө хуудас дээр холбоосуудыг тавин мөн хамт байсан бүх хүнтэй хуваалцав. Тэд хариултад сэтгэл хангалуун байх



**Би итгэдэг зүйлээ  
мэддэг байсан ч  
сүмийн талаар мэтгэлцээний багийн  
асуудаг бүх асуултад хариулахдаа  
сандардаг байлаа.**

болно гэсэн мэдрэмж надад байлаа.

Би өмнө нь итгэл бишрэлийнхээ талаар интернэтээр хуваалцаж байгаагүй бөгөөд энэ явдлаас болж сонирхсон илүү олон хүн миний итгэл бишрэлийн талаар асуусан юм. Тэд асуулт асуух үед би ерөнхий хариулттай нь хамт сүмийн материал унших холбоосыг явуулж байлаа. Ингэснээр хүмүүс зөвхөн миний хариултад найдах биш харин ерөнхий эрх мэдэлтнүүдийн өгсөн хариултад найдаж болох байв. Яриа маань илүү хувийн шинжтэй болох үед би тухайн

хүнд ганцаарчлан мессежээр хариулт өгч байв.

Сүм цахим материалууд гаргаж байдагт би их талархдаг. Хэн нэгэн хүн сүмийн тухай асуулт асуух бүрд одоо ч гэсэн надад эвгүй санагддаг. Гэхдээ би тэднээс асуулт ирэхийг хүлээдэггүй; харин би санаачлагаараа сүмийн материалуудыг интернэтээр хуваалцдаг. Эдгээр материал нь гишүүн болон гишүүн бус найзуудад маань аль алинд нь тусалж чадна гэдгийг би мэднэ. ■

*Энэ өгүүллийг бичигч Филиппиний Метро Манилад амьдардаг.*

# Сонгох эрх ба хариултууд: ИЛЧЛЭЛТИЙГ ТАНИХ НЬ

*Зарим үед харилцаа холбооны шугам хаагдсан мэт санагдах үед асар том итгэлийн алхам хийх хэрэгтэй байдаг.*



**Ахлагч  
Ричард Г. Скотт**  
Арванхоёр  
Төлөөлөгчийн  
чуулга

**Н**эгэн эмэгтэй миний өөдөөс харж суугаад уйлав. Нүдэндээ нулимстай тэрээр надад “Би юунд итгээд байгаага ч мэдэхгүй байна” гэж хэллээ. Тэр хүнд байдалд орж мөн амьдралдаа нэг асар чухал шийдвэрийг хэрхэн гаргах талаар олж мэдэх гэж олон хоног залбирсан тухайгаа хэлсэн. Тэр цөхөрсөн янзтай “Би юу хийхээ мэдэхгүй байна. Хэрэв та надад юу хийхийг хэлбэл би түүнийг хийх болно” гэж хэлэв. Тэр гараа судрууд дээр тавиад “Бурхан бидэнд тусална гэж хэлсэн. Тэр бусад бүх хүний залбиралд хариулдаг. Тэр миний залбиралд яагаад хариулахгүй байна вэ?” гэв.

Сэтгэл хөдлөлийн эргүүлэг дотор орох үед ганцаараа гарах замаа олох нь хэцүү байдаг. Миний залбирал бол үүнтэй төстэй мэдрэмжтэй хүмүүст туслах явдал юм.

Яаралтай чухал залбирлын хариу ирэхгүй байх нь бид залбирлын тухай зарим үнэнүүдийг ойлгохгүй эсвэл бид хариултуудыг ирэх үед нь таниагүй байхын аль нэг нь байж болно.

## **Залбирлын зарчмууд**

Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцах нь жирийн зүйл биш. Энэ бол ариун нандин боломж. Энэ нь өөрчлөгдөшгүй зарчмууд дээр үндэслэгдсэн байдаг. Бид Тэнгэрлэг Эцэгээсээ тусламж хүлээн авахад энэ нь

итгэл, дуулгавартай байдал болон сонгох эрхээ зөв ашигласнаас үүдэн ирдэг.

Бидний хэлсэн залбирал бүрийн хариулт тэр дороо ирнэ гэж бодох нь эндүүрэл юм. Зарим залбирал нь бидний зүгээс нэлээд хүчин чармайлтыг шаарддаг. Зарим үед биднийг эрэлхийлээгүй байхад урам илчлэлт ирдэг нь үнэн. Тэдгээр нь бидний мэдэх хэрэгтэй буюу өөр арга замаар мэдэх боломжгүй зүйлүүдтэй холбоотой байдаг.

***Тэр “Бурхан бидэнд тусална гэж хэлсэн. Тэр бусад бүх хүний залбиралд хариулдаг. Тэр миний залбиралд яагаад хариулахгүй байна вэ?” гэв.***

Бид өөр арга замаар олж авч чадахгүй туршлагыг хуримтлуулахаар энэ дэлхий дээр байгаа билээ. Бидэнд өсөх, хөгжих мөн сүнслэг төлөвшил олж авах боломж өгөгдсөн юм. Үүнийг хийхийн тулд бид үнэнийг ашиглаж сурах ёстой. Бид бэрхшээлүүдтэй хэрхэн нүүр тулж мөн хүнд асуудлуудыг шийдвэрлэж байгаа нь бидний аз жаргалд асар чухал нөлөө үзүүлдэг.

Би залбирлыг илүү сайн ойлгохын тулд бусдын зөвлөгөөг сонсон, судруудыг тунгаан бодож мөн бошиглогчдын болон



бусдын амьдралыг судалсан. Гэсэн хэдий ч хамгийн их тус болсон зүйл бол хайраар дүүрэн, нинжин сэтгэлтэй, биднийг ойлгодог мөн амжилтад хүрээсэй гэж хүсдэг. Эцэгт хандан итгэлтэй залбирч буй хүүхдийг оюун санаандаа төсөөлөн харах явдал байсан юм.

Мэдэрч байгаа зүйлээ эв хавгүй, болхидуу илэрхийлсэн бол бүү санаа зов. Зүгээр л Эцэгтэйгээ ярилц. Тэр залбирал бүрийг сонсдог бөгөөд үүнийг Өөрийн арга замаар хариулдаг.

Бид ямар нэг асуудал болон санал болгох шийдлийг тайлбарлах үед Тэрээр зарим тохиолдолд тийм, зарим тохиолдолд үгүй гэж хариулдаг. Тэрээр олонтоо хариулт өгөхөөс азнадаг бөгөөд энэ нь бидэнд санаа тавьдаггүй учраас бус харин Тэр биднийг төгс хайрладаг учраас юм. Тэр биднийг Түүний бидэнд өгсөн үнэнүүдийг ашиглаасай хэмээн хүсдэг. Бид өсөж хөгжихийн тулд зөв шийдвэр гаргах өөрсдийн чадварт

итгэн найдах ёстой. Бид зөв гэж *мэдэрч* буй зүйлээ хийх хэрэгтэй. Цаг нь ирэхээр Тэр хариулах болно. Тэр биднийг орхихгүй.

Би Тэнгэрлэг Эцэг болон бидний хоорондын харилцааны туйлын үнэнийг дүрсэллээ. Түүнд бидний тухай мэдэхгүй зүйл гэж огт байхгүй. Тэр бидэнд хэрэгтэй байгаа зүйл бүрийг мэддэг бөгөөд бүх хариултаар хангаж чадна. Гэсэн хэдий ч Түүний зорилго нь бидний мөнхийн аз жаргал учраас Тэр биднийг зөв сонголт хийхэд урамшуулан дэмждэг.

### Хариулт олох гурван арга

#### **1. Тэр та нарт аль хэдийн хариулт өгсөн гэсэн нотолгоог эрж хай**

Бидний олонхтой адилаар Оливер Каудери Их Эзэний аль хэдийн өгсөн залбирлын хариултын нотолгоог анзаараагүй юм. Түүний болон бидний нүдийг



нээхийн тулд энэ илчлэлт нь Иосеф Смитээр дамжуулан өгөгджээ:

“Чи хийсэн тэр зүйлийнхээ төлөө адислагдсан болой; учир нь чи надаас асуусан билээ, мөн болгоогтун, *чи асуух тоолондоо, чи миний Сүнснээс заавар хүлээж авсан* бөлгөө. Хэрэв энэ нь ийм байгаагүй аваас, чи энэ цагт өөрийнхөө байгаа тэр газарт хүрч ирэхгүй байх байсан.

Болгоогтун, чи надаас асууснаа мэдэж байгаа мөн бибээр *чиний оюуныг гэгээрүүлсэн билээ*; мөн үнэний Сүнсээр гэгээрсэн гэдгээ чамайг мэдээсэй гэсэндээ би эдгээр зүйлүүдийг чамд хэлж байна” (С ба Г 6:14–15; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Хэрэв Бурхан залбирлуудад *чинь* хариулаагүй гэсэн мэдрэмж та нарт байвал эдгээр судруудыг тунгаан бодож тэгээд өөрийн тань амьдралд Түүний аль хэдийн өгсөн хариултын нотолгоог анхааралтай эрж хай.

## 2. Мэдрэмжүүдэд анхаарал тавь

Өгөгдсөн хариултуудыг танихад бидний хүн нэг бүрд туслахын тулд Их Эзэн ийн хэлжээ:

“Хэрэв чи дахин нэмэлт гэрчийг хүсэх аваас, чи зүрх сэтгэлдээ эдгээр зүйлүүдийн үнэний талаар чи мэдэхийн тулд надад хандан залбирсан тэр шөнийг оюундаа санагтун.

“Энэ асуудлын талаар чиний оюунд амар амгаланг би яриагүй билүү?” (С ба Г 6:22–23; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Их Эзэн бидэнд аливаа асуудлыг оюундаа тунгаан бодоод энэ нь зөв аваас асуух, зөвлөгөө өгөх замаар бидэнд илүү ойлголтыг өгдөг:

“Мөн энэ нь зөв аваас цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно.

“Гэвч энэ нь зөв биш аваас чамд ийм мэдрэмж байхгүй байх болно, харин дүйнгэ бодол санаа чамд байх болно” (С ба Г 9:8–9; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

## 3. Түүнийг хариулахгүй байгаа үед өөрөө үйлд

Биднийг залбирах үед Их Эзэн *хариуг нь шууд өгөлгүйгээр* гуравдагч замаар хариулдгийг мэдэх нь маш чухал юм. Тэр яагаад ингэдэг вэ?

Тэр бол бидний төгс Эцэг юм. Тэр бидний ойлгож чадахаас ч илүү биднийг хайрладаг. Тэрээр бидэнд юу хамгийн сайн болохыг мэднэ. Тэр эхлэлээс төгсгөлийг хүртэл харж чаддаг. Тэр биднийг хөдөлмөрлөж, хэрэгцээтэй туршлагаа олж аваасай гэж хүсдэг:


Түүний *тийм* гэдэг хариулт бидэнд итгэл найдвар өгдөг.

Тэрээр *үгүй* гэж хариулбал энэ нь алдаанаас сэрэмжлүүлж байна гэсэн үг.

“Хэрэв тэр *хариулахгүй байвал* бид Түүнд итгэх итгэлээрээ дамжуулан өсч хөгжин, Түүний зарлигуудад дуулгавартай байх, үнэн дээр үйлдэх хүсэлтэй байхыг сануулж байна гэсэн үг. Ямарваа урьдчилсан баталгаагүйгээр Түүний сургаалуудтай нийцсэн шийдвэрийн дагуу үйлдсэнээр хариуцлагыг өөртөө авахыг Тэр биднээс хүсэн хүлээдэг. Бид Их Эзэнийг хариулахгүй байна хэмээн гомдоллон дургүйцэлгүй мөн идэвхгүй хүлээж сууж болохгүй. Бид үйлдэх хэрэгтэй.

Бидний хийдэг сонголтууд ихэнхдээ зөв байдаг. Харин үүнийг Их Эзэн Өөрийн арга замаар баталгаажуулдаг юм. Тэрхүү баталгаа нь ерөнхийдөө тусламж болж, бидэнд ирдэг. Бид сүнсэлг мэдрэмжтэй байснаар үүнийг олж авна. Энэ нь хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг бидний сонголтуудыг баталсны тэмдэг болж бидэнд ирдэг. Хэрэв бид итгэлдээ тулгуурлан зөв бус зүйлийг хийж эхэлбэл Тэрээр хэт оройтохоос өмнө бидэнд үүнийг мэдүүлэх болно. Бид түгшүүртэй эсвэл тайван бус мэдрэмжүүдийг таньснаар энэ тусламжийг анзаардаг.

Туулин ялтсуудыг олж авах гэсэн Нифайн хичээл зүтгэл энэ зарчим хэрхэн ажилладгийг харуулдаг (1 Нифай 3:6–7-г үзнэ үү). Нифай хоёр удаа амжилтгүй оролдлого





хийсний дараа итгэлтэй хэвээр үлдсэн юм. Тэрээр бүх хариултыг авалгүйгээр Лебений гэрийг чиглэн хот руу орсон юм. Тэрээр “Би хийвэл зохих зүйлүүдийг урьдаас мэдэхгүй байсны учир Сүнсэнд хөтлөгдөн байлаа” хэмээн хэлсэн ба “*гэсэн хэдий ч би урагшлан явлаа*” хэмээн өгүүлжээ. (1 Нифай 4:6–7; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

“Нифай чадах бүхнээ хийж, олон удаа шаргуу оролдсон юм. Тэрээр өөртөө туслуулах шаргуу итгэлийг харуулсаар байв. Тэр санаагаар унахыг хүсээгүй. Харин тэр үйлдэж, Их Эзэнд итгэх итгэлтэй, дуулгавартай байж, сонгох эрхээ зөвөөр ашиглан, удирдамж хүлээн авсан юм. Тэрээр алхам алхмаар амжилт олоход Сүнсээр нөлөөлөгдсөн бөгөөд “зарлигласан зүйлийг гүйцэлдүүлж чадах *хүчийг* тэдэнд өгснийг би баттай мэдэв” хэмээн эх нь хэлсэн юм. (1 Нифай 5:8; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Нифай алхам алхмаар тусламж хүлээн авахын тулд Бурханд итгэн, итгэлээ ашиглаж мөн үйлдэл хийх нь түүнээс шаардагдаж байсныг мэдсэн юм. Тэр бувтнаж эсвэл бүтэн тайлбар хүсээгүй. Гэвч анхааралтай ажиглаарай, тэр тусламж ирэхийг идэвхгүй хүлээгээгүй. Тэр үйлдсэн! Сүнсэлг хуулийг дагаснаар түүнд илчлэлт болон үйлдэх хүч өгөгдсөн юм.

### **Бурханы хүсэл болон арга замд найдах нь**

Заримдаа бидний залбирлын хариултууд анзаарагдахгүй өнгөрдөг, учир нь бид өөрсдийн хүсэлтэй нийцэх баталгааг хэт их хүсдэг. Их Эзэн биднээр өөр зүйл хийлгэхийг хүсэж байгааг бид харж чаддаггүй. Анхааралтай байж, Түүний хүслийг эрэлхийл.

Зөв шударга байдал болон Тэнгэрлэг Эцэгт итгэх итгэл байхгүй тохиолдолд хэрхэн зөв шийдвэр гаргахаа мэдэхгүй гэдгээ би хүлээн зөвшөөрч байна. Сонгох эрх нь санаатайгаар Бурханы хүслээс өөрөөр ашиглагдвал энэ зарчим ердөө ч ажиллахгүй. Хэрэв наманчлаагүй нүгэл байвал бид өөрсдийн эгэл байдалдаа үлдэж, өөрсдөө зовох болно. Бид хувийн наманчлалаар дамжуулан аврагдаж *чадна*.

Биднийг шийдвэр гаргахад туслах илчлэлт эрэлхийлэх үед Их Эзэн намуухан өдөөлтүүдийг өгдөг. Эдгээр нь биднээс бодох, итгэлээ ашиглах, ажиллах, зарим үед зовох мөн үйлдэхийг шаарддаг. Шийдвэрлэх чухал зүйл эсвэл ярвигтай асуудлын хариултууд нэг дор бүрэн ирэх нь ховор байдаг. Харин энэ нь олонтоо нэг нэг хэсгээр, төгсгөл нь харагдахааргүйгээр ирдэг.

Иби эцсээ хүртэл залбирлынхаа хамгийн чухал хэсгийг авч үлдсэн юм. Энэ бол талархал. Хайрт Тэнгэрлэг Эцэгтээ талархалтай байх бидний чин сэтгэлийн хичээл

зүтгэл нь амар амгалан, өөрийгөө үнэлэх үнэлэмж болон хайрын гайхалтай мэдрэмжийг төрүүлдэг.

Яагаад хамгийн ядуу зүдүү хүмүүс нь Их Эзэнд хэрхэн талархахаа хамгийн сайн мэддэг юм шиг санагддаг вэ? Гватемалын уулархаг газруудад гишүүд арай гэж амь зуудаг. Ариун сүм рүү явахад маш их золиослол шаарддаг. Энэ аялалд нэг жилийн турш бэлдэх хэрэгтэй. Үүний тулд шаргуу хөдөлмөрлөж, мөнгө болон хоол хүнсээ нөөцлөн, золиослол гаргаж, утас ээрч, будан, шинэ хувцас нэхдэг. Тэд уулнаас хөл нүцгэн бууж, хол газар алхан, Изабел нуурыг гатлах хэрэгтэй болох ба автобусанд багахан хүнстэй явах болно. Тэгээд ядарч сульдсан байдалтай ариун сүмд ирдэг. Тэд өөрсдийгөө гялалзтал зүлгэн угаагаад Их Эзэний өргөөнд ордог.

---

**Заримдаа бидний залбирлын хариултууд  
анзаарагдахгүй өнгөрдөг, учир нь бид өөрсдийн  
хүсэлтэй нийцэх баталгааг хэт их хүсдэг.**

---

Цагаан хувцас өмссөн тэд Сүнсээр заалган ёслолуудыг хүлээн авч, үйлддэг. Нэгэн уулархаг нутгийн эмэгтэй сүнснийг болон хувийн хишгийн утга учрыг хүчтэй мэдэрчээ. Селестиел өрөөнд орохдоо тэрээр толгойгоо хүндэтгэл бишрэлтэй бөхийлгөн сууж буй хүмүүсийг харав. Тэр сөгдөж суугаад тонгойн, бусдыг ч анзааралгүй мэгшин уйлж, хориод минутын турш Тэнгэр дэх Эцэгтээ зүрх сэтгэлээ уудлан ярив. Эцэст нь нулимсаараа хувцсаа норгосон тэрээр толгойгоо өндийлгэв. Ариун сүмийн сайхан сэтгэлтэй ажилтныг “Би танд тусалж болох уу?” хэмээн асуухад тэрээр хариуд нь “Тэгж болох юм уу? Би тэнгэр дэх Эцэгтээ бүхий л адислалуудынхаа төлөө талархлаа илэрхийлэхийг хичээлээ. Гэвч хангалттай илэрхийлсэн гэж би бодохгүй байна. Түүнд ямар их талархаж байгаагаа хэлэхэд минь та надад тусалж чадах уу?” гэжээ.

Залбирлын тухай энэ зөвлөгөө нь үнэн юм. Би үүнийг хувийн амьдралынхаа лабораторит бүхэлд нь туршиж үзсэн. Зарим үед харилцаа холбооны шугам хаагдсан мэт санагдах үед асар том итгэлийн алхам хийх хэрэгтэй гэдгийг би олж мэдсэн юм.

Хэрэв та нар Түүний тусламжийг эрэлхийлбэл амьдралаа цэвэр, хүслүүдээ зохистой байлгаж мөн Түүний хүссэн зүйлийг хийхэд бэлэн бай, учир нь Тэр та нарын залбиралд *хариулна*. Тэр бол та нарын хайрт Эцэг; та нар бол Түүний хайртай хүүхдүүд. Тэр та нарыг төгс хайрладаг бөгөөд та нарт туслахыг хүсдэг. ■



Хэрэв би  
**ЦЭЭЖИН**  
 дотроо  
**ШАТАХ МЭТ**  
 мэдрэмжийг  
 мэдрэхгүй  
 бол яах вэ?

Та нар юуг анзаарах ёстойгоо мэдэж байвал Ариун Сүнсийг илүү амархан таньж чадна.

**Рачел Нийлсэн**

**З**арлалыг сонссон даруйд “Ноён Вүдийг\* семинарт урь” гэсэн бодол толгойд маань орж ирсэн бөгөөд би үүнийг тэр даруй галзуу зүйл гэж бодлоо. Би яах гэж хөгжмийн багшаа өглөө 5:30-аас семинарт ирэхийг урих юм бэ?

Семинарын багш ангийнханд маань бид багшдаа талархах өдөр зохион байгуулна гэдгийг хэллээ. Бидэнд сургуулийнхаа зарим багшийг өглөөний семинарт урьж мөн тэдний үйлчлэлд талархах даалгавар өглөө. Энэ зарыг сонсоноос хойш бүтэн долоо хоногийн турш би ноён Вүдийг урих талаар бодож байлаа. Намайг семинарт байхад *\*Нэрийг өөрчлөв.*

эсвэл түүний хөгжмийн ангид суух болгонд “Ноён Вүдийг семинарт урь” гэсэн бодол бодогдсоор байлаа. Энэ байдал хэдэн өдөр үргэлжилсний дараа би уг бодлыг тоохгүй байж чадсангүй.

Нэгэн өглөө хөгжмийн ангид байсан бүх сурагч хөгжмийн зэмсгээ гаргаж байхад би тромбон хөгжмөө орхиод ноён Вүд рүү очлоо. Миний зүрх хүчтэй цохилж, гар минь салгалж байсан боловч ам нээж, түүнийг урих үедээ би тайвшралыг мэдрэсэн.

Ноён Вүдийг очно гэж хэлэхэд нь би их гайхсан! Тэр намайг яагаад өглөө бүр сургуулийн өмнө семинарт

явдгийг сонирхож мөн илүү ихийг мэдэхийг хүссэн юм. Түүнд бүтдийг хэлсний дараа би дүүрэн баяртай алхаж явлаа.

Энэ явдлын үеэр би цээжин дотроо шатах мэт мэдрэмжийг мэдрээгүй (С ба Г 9:8-ыг үзнэ үү). Гэхдээ би Ариун Сүнсийг мэдэрсэн. Ноён Вүдийг урь гэсэн дахин давтагдсан бодлууд (С ба Г 128:1-ийг үзнэ үү), түүнийг урих үед мэдрэсэн тайвшрал (Иохан 14:26-г үзнэ үү), мөн түүнийг урьсны дараа мэдрэсэн баяр баясал (Галат 5:22-ыг үзнэ үү) бүгдээрээ Сүнснээс ирсэн. Хэрэв би цээжин дотор шатах мэт мэдрэмжийг л зөвхөн хайж байсан



бол Ариун Сүнс намайг өдөөх үед үүнийг анзааралгүй өнгөрөөж болох байсан.

Ариун Сүнс олон арга замаар ярьдаг бөгөөд Тэр хэрхэн харилцдагийг судалснаар Тэр та нартай хамт байж мөн та нарт зааж эсвэл та нарыг удирдах үед Түүний нөлөөг таних гэж хичээх үедээ юуг анзаарах ёстойгоо та нар мэдэх болно.

### Жижиг болоод энгийн зүйлүүдийг эрж хай

Ариун Сүнсний бидэнд хандан ярьдаг олон арга замаас суралцахаас өмнө илчлэлт нь ихэнхдээ намуун, зөөлөн байдгийг бид санах хэрэгтэй. Хэрэв бид залуу Алмад тохиолдсонтой адил тэнгэр элчийг болон газар хөдлөлт болсон тохиолдлыг хайж байвал Ариун Сүнсний илүү ойр давтамжтай мөн илүү нам гүм өдөөлтүүдийг анзаарахгүй байж магадгүй. Хэрэв бид “гайхалтай ба гэнэтийн сүнслэг илэрхийллийг онцлох юм бол” илүү нийтлэг байдаг “жижиг болон өсөн нэмэгдэх сүнслэг өдөөлтүүдийг” анзаарахгүй өнгөрч болдгийг Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А. Бэднар сануулсан юм.<sup>1</sup> Ариун Сүнсний таньж сурахыг хичээх үедээ жижиг болоод энгийн өдөөлтүүдийг эрж хайгаарай.

### Ариун Сүнсний харилцдаг арга замуудыг эрж хай

Хэрэв та нар цээжин дотор шатах мэт мэдрэмжийг хэзээ ч мэдрч байгаагүй бол санаа зовох хэрэггүй. Ариун Сүнсний нөлөөг энэ арга замаар таньдаг хүмүүс олон байдаг

боловч Тэр өөр олон арга замаар ярьдаг бөгөөд та нар Түүний оршихуйг мэдрэхийн тулд цээжин дотор шатах мэт мэдрэмжийг мэдрэх шаардлагагүй. Түүгээр ч барахгүй, та нар Ариун Сүнс өөрт чинь нөлөөлдөг арга замуудыг ойлгож мөн тэднийг амьдралдаа хайх үедээ Тэр бодсоноос чинь ч илүү ихээр та нартай харилцаж байгааг мэдэж болох юм.

Энэ жагсаалт нь Ариун Сүнсний харилцдаг цөөн хэдэн арга замыг багтаасан байгаа. Ариун Сүнс та нарт хандан ярьдаг өөр олон арга замыг олж мэдэхийн тулд судрууд ба орчин цагийн бошиглогчдын үгс болон *Миний сайн мэдээг номло: Номлогчийн үйлчлэлийн удирдамж* (2004) номын 96–97-р хуудсыг судал.

“Илчлэлтийн сүнс нь гол төлөв Ариун Сүнсний хүчээр бидний оюун болон зүрхэнд бодол ба мэдрэмж хэлбэрээр ирж, ажилладаг.

(С ба Г 8:1–2; 100:5–8-ыг үзнэ үү.)”<sup>2</sup> Ариун Сүнс дараах арга замуудаар чамд хандан ярьж чадна:

- Хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, сайхан сэтгэл, итгэлтэй байдал болон дөлгөөн зангийн мэдрэмжүүд (Галат 5:22–23-ыг үзнэ үү).
- Бидний оюуныг эзэмдэх эсвэл мэдрэмжүүдэд нөлөөлөх бодлууд (С ба Г 128:1-ийг үзнэ үү).
- Сайныг үйлдэж мөн зарлигуудыг дуулгавартай дагах хүсэл (Мозая 5:2-ыг үзнэ үү).
- Ямар нэг зүйлийг зөв гэсэн мэдрэмж (С ба Г 9:8-ыг үзнэ үү).
- Тайтгарлын мэдрэмж (Иохан 14:26-г үзнэ үү).
- “[Та нарын] бодгалийг тэлдэг” мэдрэмжүүд (Алма 32:28).
- “Ойлголтыг [чинь] гэгээрүүлэх” бодлууд (Алма 32:28).
- Илүү үнэнийг мэдэхийг хүсэх (Алма 32:28-ыг үзнэ үү).



### ЦЭЭЖИН ДОТОР ШАТАХ ГЭДЭГ НЬ ЯГ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

“Цээжин дотор шатах гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь шаталтаас үүссэн шатах мэт халуун илчийн мэдрэмж байх ёстой юу? Хэрэв ийм утгатай юм бол би хэзээ ч цээжин дотор шатах мэт мэдрэмжийг мэдрч байгаагүй. Сударт гардаг ‘шатах’ гэдэг үг нь тайтгарал болон амар амгалангийн мэдрэмжийг хэлж байгаа нь тодорхой юм. Энэ бол олон хүний хүлээн авдаг гэрчлэл юм. Энэ бол илчлэлт ирэх арга зам юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х. Өүкс, “Teaching and Learning by the Spirit (Сүнсээр заах ба суралцах нь),” *Лиакона*, 1999 оны 5-р сар, 22.



## АЛИВАА БОДОЛ НЬ НАДААС УУ ЭСВЭЛ АРИУН СҮНСНЭЭС ИРЖ БАЙНА УУ ГЭДГИЙГ БИ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

“Бид үйлдэх ёстой. Тэгээд бид энэ нь надаас уу эсвэл Бурханы хүч үү гэдгийг мэдэх болно. . . . Биднийг сайныг хийж мөн сайн байхад урьж, өдөөдөг бүх зүйл Бурханаас ирдэг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар, “Patterns of Light: Discerning Light (Гэрлийн загвар: Ялган таних гэрэл)” (видео бичлэг), LDS.org. lds.org/go/patternL6 хаягаар орж бичлэгийг бүрэн эхээр нь үзнэ үү.

- Үйлдэл хийхээр албадуулах (дэмжих) эсвэл ямар нэг зүйл хийхийг зогсоох (хойш нь чангаах) (1 Нифай 7:15; 2 Нифай 32:7-г үзнэ үү).

### Эдгээр бодол ба мэдрэмж хэрхэн ирэх вэ?

Ариун Сүнснээс ирэх бодол ба мэдрэмжүүд нь:

- “Тэр дороо болон хүчтэйгээр.”
- “Аажмаар болон алгуураар.”
- “Чамд анзаарагдахааргүй тийм сулавтар байдлаар” гэх зэргээр ирж болно.<sup>3</sup>

lds.org/go/revelationL6 дээрх видео бичлэгийг үзэж, энэ талаар илүү ихийг мэдэж ав.

Ариун Сүнснээс ирэх бодол ба мэдрэмжүүд нь дараах шалтгаануудаар ирж болно:

- Бүх зүйлийг бидэнд сануулахаар (Иохан 14:26-г үзнэ үү).
- Биднийг мэхлэлтээс хамгаалахаар (С ба Г 45:57-г үзнэ үү).
- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн талаар гэрчлэхээр (2 Нифай 31:18-ыг үзнэ үү).
- Заахад маань туслахаар (С ба Г 84:85-ыг үзнэ үү).
- Сүнсний бэлгүүдийг өгөхөөр (С ба Г 46:11-ийг үзнэ үү).
- Нүглүүдийн ангижралыг авчрахаар (2 Нифай 31:17-г үзнэ үү).

### Сайныг эрэлхийл

Ариун Сүнсийг таних гэж хичээх үедээ ирж буй мэдрэмжүүдийн үр дүнг бодож үз: Энэ бодол эсвэл мэдрэмж нь чамайг сайн зүйл хийхэд хөтөлж байна уу? Моронай 7:16 дээр “Иймийн тул, би та нарт дүгнэх аргыг үзүүлэе; учир нь Христэд итгүүлэхээр ятгахыг, мөн

сайныг хийхийг урьдаг юм болгон нь, Христийн хүч болон бэлгээр илгээгдсэн байдаг; иймийн тул та нар энэ нь Бурханаас гэдгийг төгс мэдлэгээр мэдэж болно” хэмээн заадаг.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) “Бид Сүнсний өдөөлтийг яаж таньдаг вэ? Энэ нь тийм ч хэцүү гэж би бодохгүй байна. . . . Энэ нь хүнийг сайныг хийж, дээшээ тэмүүлэн, өндөрт зогсоход; зөв зүйлийг хийж, нинжин сэтгэлтэй, өглөгч байхад ятгаж байна уу? Тэгвэл энэ нь Бурханы Сүнс мөн. Хэрэв энэ нь харанхуй, муухай, бохир, сайн биш байвал энэ нь чөтгөрөөс ирсэн гэдгийг та нар мэдэж болно.”<sup>4</sup>

Хэрэв та нар Сүнсийг мэдэрч байгаа эсэх дээр гайхаж байгаа бол бодол эсвэл мэдрэмж чинь сайныг хийхэд урьж байгаа эсэхийг





### АРИУН СҮНСИЙГ ТАНИХАД ЯАГААД ХЭЦҮҮ БАЙДАГ ВЭ?

“Эцэг маань та нарыг Түүнд болон Түүний Ариун Хүү Есүс Христэд итгэх итгэлээ ашиглан энэ бурханлаг бэлгийг хэрхэн олж авахыг сураасай гэж хүсдэг. Бид зөвхөн гуйгаад л илчлэлтээр удирдамж авдаг бол та нар илүү сул дорой болж мөн үргэлж тэднээс хамааралтай байх болно. Энэ амин чухал хувийн өсөлт нь та нар Ариун Сүнсээр удирдуулж сурахыг чадан ядан хичээх үед ирдэг гэдгийг Тэд мэддэг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт, “To Acquire Spiritual Guidance (Сүнслэг удирдамжийг олж авахын тулд),” *Лиахона*, 2009 оны 11-р сар, 7.

өөрөөсөө асуугаад үз. Хэрэв тийм байвал та нар энэ нь Бурханаас ирсэн гэдэгт итгэлтэй байж болно.

### Сонгох эрхээ ашиглах боломжуудыг хай

Хэрэв та нар зөв зохистой боловч Ариун Сүнсийг танихад хэцүү байгаа бол үйлдэл хий. Тэнгэрлэг Эцэг та нарыг сонгох эрхээр адисалсан бөгөөд заримдаа Түүний удирдамжгүйгээр үйлдэл хийхийг та нараас шаарддаг. Тэр та нараас харанхуй руу ганц нэг алхах замаар итгэлээ ашиглахыг хүсэх болно. Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Бойд К.Пакэр “Сүнслэг мэдлэгийг олж авах эрдийн чинь хаа нэгтээ тэр ‘итгэлийн алхам’ байдаг. . . . Энэ бол та гэрлийн

ирмэгт хүрч очоод ганц хоёрхон алхмын цаадах зам тань гэрэлтэй байхад харанхуй руу алхан орох агшин юм” хэмээн хэлсэн.<sup>5</sup> Хэрэв та нар Ариун Сүнсний өдөөлтүүдийг танилгүйгээр өөрсдийн мэдлэгт тулгуурлан, итгэлтэйгээр үйлдвэл Тэнгэрлэг Эцэг та нарыг буруу зам руу оруулахгүй байх болно. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.*

#### ЭШЛЭЛҮҮД

1. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” *Лиахона*, 2011 оны 5-р сар, 88.
2. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” 88.
3. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” 90.
4. *Гордон Б.Хинклигийн сургаалууд* (1997), 260–261.
5. Бойд К.Пакэр, “The Quest for Spiritual Knowledge (Сүнслэг мэдлэгийн төлөө хүсэмжлэх нь),” *Лиахона*, 2007 оны 1-р сар, 18.

## СҮНС ЯАЖ МЭДРЭГДДЭГ ВЭ?

“Бидэнд Сүнсийг төгс дүрслэх . . . үгс байхгүй” (Бойд К.Пакэр, “The Candle of the Lord (Их Эзэний дэнлүү),” *Тамбули*, 1988 оны 12-р сар, 34). Сүнс яаж мэдрэгддэгийг дүрслэхэд хэцүү учраас хүн бүр үүнийг бага зэрэг өөрөөр дүрсэлдэг. Гэвч эдгээр өөрчлөлтөөс үл хамааран, бусад хүмүүс Ариун Сүнс тэдэнтэй хэрхэн ярилцдагийг тайлбарлах үед бид их зүйлийг сурч авч болно. Хэд хэдэн хүн Ариун Сүнсийг хэрхэн дүрсэлж хэлэхийг [lds.org/go/powerL6](https://www.lds.org/go/powerL6) хаягаар орж үзнэ үү.



# Намуухан ӨДӨӨЛТҮҮДИЙГ ДАГА

Ариун Сүнснээс  
ирэх шивнээ бүр нь  
чагнууштай.

**Х**эрэв хар салхи шөнө дунд аварга том ургаа модыг эргэдүүлэн, чиний орон дээр авчрах гэж байвал чи урьдчилан мэдэхийг хүсэх байсан.

Вилфорд Вудрафф (1807–1898), хожим нь сүмийн дөрөв дэх ерөнхийлөгч болсон түүнийг нэг удаа гадаа сүйх тэргэн дотроо эхнэр, хүүхдүүдтэйгээ унтаж байхад нь Сүнс “Босч, морин тэргээ холдуул” гэж шивнэжээ.<sup>1</sup> Тэр үүнийг хачин санаа вэ гээд тоохгүй байж болох байсан ч үүний оронд тэр дуулгавартай дагажээ. Хагас цагийн дараа хуй салхи аварга том модыг тасдаж, агаарт эргэдүүлэв. Тэрхүү мод морин тэргэ байсан газарт унасан байна.

Өдөөлтүүдийг дагасны үр дүнд тохиолдсон ийм гайхамшгуудын жишээ олон байдаг.

Гэтэл найз руугаа утасдаж, мэндийг нь асуу гэсэн өдөөлт хэр чухал вэ? Эсвэл явган аялалаар яваххаасаа өмнө үүргэвчиндээ илүү оймс хий гэсэн өдөөлт нь мөн хэр чухал бол? Ийм өдөөлтүүдийг дагах нь томоохон зүйлийг авчрахгүй боловч тэдгээр нь мөн л чухал юм.

Утсаар ярих найз чинь хүнд өдрийг өнгөрүүлж байж болно. Ганц дуудлага түүний урмыг сэргээж ч болох шүү дээ. Мөн явган аялалын үеэр илүү оймстой байх нь тав тухтай зугаалах эсвэл хөл гэнэт норсноос цэврүүтэж, зовиурлан явах хоёрын ялгааг сануулж болох юм.

Ерөнхийлөгч Томас С.Монсон: “Бид ажигладаг. Бид хүлээдэг. Бид тэр намуун, зөөлөн дуу хоолойг чагнадаг. Энэ дуу хоолойг ярихад мэргэн ухаант эрэгтэй, эмэгтэйчүүд дуулгавартай дагадаг. Бид Сүнсний өдөөлтийг дагахаа хойшлуулдаггүй” хэмээн заасан.<sup>2</sup>

Зарим үед сүнслэг өдөөлтүүд нь анзаарагдахуйц тод байдаг. Гэвч тэдгээр нь ихэнхдээ намуухан байдаг. Тэнгэрлэг Эцэг биднийг “шат шатаар, дүрэм дүрмээр, энд бяцхан мөн тэнд бяцханыг” өгч зааварлах болно хэмээн амласан (2 Нифай 28:30).

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэвид А.Бэднар: “Илчлэлт нь ихэвчлэн, цаг өнгөрөх тусам бага багаар нэмэгдэн ирдэг бөгөөд энэ нь бидний хүсэл, зохистой байдал болон бэлтгэлээс шалтгаалан ирдэг” хэмээн заажээ.<sup>3</sup>

Бидний хэнд нь ч хар салхины шидсэн ургаа модноос булгах хэрэг гарахгүй байх. Гэсэн хэдий ч Ариун Сүнсэнд анхаарал хандуулснаар бид үргэлж жижиг болон энгийн сайн зүйлүүдийг хийх болно гэдэгтэй итгэлтэй байж болно. ■

## ЭШЛЭЛҮҮД

1. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Вилфорд Вудрафф (2011), 47.
2. Томас С.Монсон, “The Spirit Giveth Life (Сүнс амьдрал өгдөг),” *Ensign*, 1985 оны 5-р сар, 68.
3. Дэвид А.Бэднар, “Илчлэлтийн Сүнс,” *Лиакхона*, 2011 оны 5-р сар, 88.



# ДУУД МИНЬ ӨГСӨН АДИСЛАЛ

Жэссэ Жоунз

**Б**и санваарын хүч чадал ба адислалуудын талаар нэгэн золгүй тохиолдлын үед мэдэж авч билээ. Хэдэн жилийн өмнө дүү маань 14 настай байхдаа мотоциклийн осолд орж, хөлөө хугалсан юм. Аав над руу ярьж, дүүг маань эмнэлэг рүү авч явж байгааг хэлэв. Эмнэлэг рүү яаран явах үед миний дотор маш хүнд зүйл мэдрэгдэж байв. Би тэнд очоод авга ах нарынхаа нэгтэй уулзахад тэр надад осол хэр ноцтой болсон талаар хэлсэн юм.

Би юу харах бол гэсэн айдастайгаар дүүгийнхээ байсан өрөөний хаалгыг нээж, өрөөнд оров. Би ганц алхаад нүдээ аньж, тэр дороо амар амгалан болов. Би өөртөө төрсөн хүнд мэдрэмжийг хэзээ ч мартаггүйтэй адил миний дээр ирсэн амар амгалангийн болон тайтгарлын мэдрэмжийг ч мөн хэзээ ч мартаггүй. Энэ мэдрэмж нь Сүнс байсан гэдгийг би таньсан.

Тэгээд би аавынхаа ярихыг сонсон. Тэрээр авга ахтай хамт дүү минь санваарын адислал өгч байв. Тэр өөрийн хүүг зүгээр болж, эдгэрч мөн хөлийг нь хэвийн байдалд оруулахаар Есүс Христийн нэр дээр даруухнаар адислав.

Адислалын дараа хүн бүр хэсэг зуур чимээгүй байв. Тэр үед би ирээдүйн хүүхдүүддээ адислал өгөх боломжтой байхын тулд Мелкизедек санваарыг авахуйц зохистой амьдрах ёстой гэдгийг мэдэж авсан.

Бид дүүгийнхээ өрөөний гадна талын үүдний өрөөнд цуглахад аав, ээж хоёр маань юу хийх ёстойгоо ярилцаж эхлэв. Тэд түүнийг Мексикээс авч явж, Нэгдсэн Улсын эмчид үзүүлэх үү эсвэл мэс заслыг энд хийлгэх үү гэдэг талаар ярилцаж байв. Аль ч сонголт нь дүүгийн маань хувьд хамгийн сайн нь байсан юм, яагаад гэвэл тэр хүлээн авч чадах хамгийн сайн тусламжаа авсан гэдгийг би мэдэж байсан. Тэр санваарыг атгадаг хоёр эрэгтэйгээс адислал авсан учраас аав, ээж хоёр маань юу ч гэж шийдсэн бай, дүү минь сайжрах л байсан.

Тэд Мексикт үлдэж, мэс засал хийлгэхээр шийдсэн. Эмч нар дүүгийн маань хөлийг 10 хадаасаар хадсан юм. Хөл нь сайн эдгэж, хэдэн сарын дараа тэр хөлбөмбөгийн багт орсон билээ. Адислал яг аавын минь хэлснээр биелсэн юм.

Санваар бол хүнд өгөгдсөн Бурханы хүч болон эрх мэдэл гэдгийг би мэднэ. Тэр бидэнд үнэхээр агуу бэлэг өгсөн билээ. ■

*Энэ өгүүллийг бичигч Мексикийн Чиуауад амьдардаг.*



“Бид санваар хүртэхдээ Бурханы нэрээр үйлдэх мөн үнэний болон зөвт байдлын замаар удирдах эрх мэдлийг хүлээн авдаг. Энэхүү эрх мэдэл нь дэлхий дээрх Бурханы хүүхдүүдэд туслах чухал шударга хүч, нөлөөний эх сурвалж бөгөөд энэ нь үхлийн дараа ч гэсэн бидэнд үлддэг.”

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Л.Том Пэрри, “Итгэлийн тунхагдах сургаал, зарчмууд,” Лиакхона, 2013 оны 11-р сар, 47.**





## “Би ариун ёслолын үед юуны тухай бодож байх хэрэгтэй вэ?”

**Х**эдийгээр бид ямар ч цагт мөн бүх зүйлд, мөн өөрийн байж болох хаана ч гэсэн (Мозая 18:9) Есүс Христийн гэрчлэгч болж зогсдог ч гэсэн заримдаа бидний эргэн тойронд байдаг дэлхийн нөлөөнүүд бидний анхаарлыг татдаг. Ариун ёслол нь бидэнд ямар ч саад болох зүйлгүйгээр бодол санаагаа Аврагч дээр төвлөрүүлэх боломжийг олгодог.

Ариун ёслолын турш та ёслолын утга учир болон сайхан зүйлийнх нь тухай бодож болно. Аврагчийн бие болон цусыг төлөөлсөн бэлэгдлийг хүртэх нь түүний хязгааргүй ба цагаатгагч золиослолыг тунгаан бодоход тань тусалж чадна. Та ариун ёслолоос хүртсэнээрээ баптисмын гэрээгээ шинэчилж байдаг. Тэгснээрээ та Түүнийг үргэлж дурсан санаж, Түүний зарлигуудыг дагана гэдгээ өөртөө дахин амладаг.

Та өөрийгөө сүнслэгээр бэлдсэнээр ариун ёслолд оролцох оролцоогоо сайжруулж чадна. Аврагчийн золиослолд болон өөрийнхөө шавийн байдалд анхаарал төвлөрүүлэхэд тань тусалж чадах Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсээс эсвэл судрын хэсгүүдээс долоо хоногийн турш судалж үзэх талаар бодоорой. Ариун ёслолын дуулал болон залбирлуудын туршид дууны үгсэд болон сонсож байгаа үгсдээ анхаарлаа төвлөрүүлж, тэдгээрийн утгын талаар тунгаан бод.

Ариун ёслолын дундуур Есүс Христтэй илүү адил болохын тулд өөрийнхөө хувийн амьдралд хийж байгаа өөрчлөлтүүдийн тухай бодох цаг гарга. Ариун ёслолоос зөв зохистой хүртсэний дараа та баптисм хүртэх үедээ мэдэрсэн шиг тийм цэвэр ариун байдлыг мэдрэх болно.

### Бодол санаагаа Цагаатгал руу чиглүүл

Ариун ёслолын туршид миний бодол санаа Есүс Христ болон түүний Цагаатгал руу чиглэдэг. Есүс Христийн Цагаатгалын тухай бодох үедээ ариун ёслолын турш мэдэрдэг мэдрэмжээ илэрхийлэх нь надад амаргүй байдаг. Есүс Христ бидний Гэтэлгэгч болохоор сонгогдсон гэдгийг би мэднэ. Тэр амьд гэдгийг би мэднэ.

*Бүгд Найрамдах Конго Улс, Браззавилль, Ницфай Б., нас 20*

### Есүс Христийн тухай бод



Ариун ёслолын турш хийсэн алдаануудаа наманчилж болохын тулд Аврагч юуг туулсан тухай би боддог. Мөн түүнчлэн надад

өгсөн Түүний бүх адислалын тухай, Түүний хийсэн ба хийх гайхалтай гайхамшгуудын тухай боддог. Бид ариун ёслолыг хүртэх боломжоор адислагдсан. Тэгснээрээ бид нүглүүдээ наманчилж, илүү сайныг хийхээр болдог.

*АНУ, Юта, Анди Б., нас 13*

### Ариун ёслолын дууллуудын үгсийг тунгаан бод



Ариун ёслолын дууллууд нь бидэнд ариун ёслолын турш юу бодох ёстой талаар заадаг. Жишээлбэл,

Миний дуртай ариун ёслолын дуу болох “Аврагчаа, даруу төлөвөөр” (Сүмийн дуулал, хуудас 26) дуун дээр “Амиа өргөн, цусаа урсган, Калварт загалмай дээр Та эгэл миний өмнөөс зовсныг эгнэгт санаж явъя би” гэсэн байдаг. Ариун ёслолын турш ариун ёслолын дууллуудын үгсийг санах нь надад амар тайвныг мэдрэхэд тусалдаг ба Есүс Христийн Цагаатгалд талархах талархлыг минь нэмэгдүүлдэг.

*Канад, Алберта, Остин Б., нас 15*

### Дурсан сана бас тань

Ариун ёслолын зорилго нь Тэнгэрлэг Эцэгтэйгээ хийсэн гэрээгээ шинэчлэхэд болон бид наманчилснаар нүглүүдээсээ ангижрахад оршдог. Ариун ёслолын турш бид Христийн бидний төлөөх золиослолыг дурсан санадаг ба түүнийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар тунгаан боддог. Өнгөрсөн долоо хоногийн туршид хийсэн зүйлийнхээ талаар



болон Эцэгтэйгээ хийсэн гэрээгээ хэр сайн дагасан талаар би бодохыг хичээдэг. Би хийсэн нүглүүдээ ухаардаг ба тэдгээрийг наманчлахын тулд Цагаатгалыг хэрхэн ашиглах талаар боддог. Ингэснээр ариун ёслол нь миний хувьд урам өгсөн, сүнслэгээр хүчирхэгжүүлсэн туршлага болдог.

*АНУ, Аризона, Абагэйл П., нас 14*

### Бодол санаагаа дэмий зүйлээр бүү сарниул



Ням гараг бүр ариун ёслолын дундуур гаргаж ирдэг жижигхэн карт миний судрын завсар байдаг. Энэ нь Алма баптисмын гэрээг

тайлбарладаг Мозая 18-р бүлгийн номын хавчуурга юм. Энэ карт дээр “Цагаатгалд талархалтай бай” гэх мэт ариун ёслолын зорилгыг болон ариун байдлыг сануулахад тусалдаг жижигхэн зурвас үгс бичигдсэн байдаг. Эдгээр зурвас үгсийг уншнаар бодол санаагаа ариун ёслолын зорилгод болон түүнийг ариун байлгахад төвлөрүүлэхэд минь тусалдаг.

*АНУ, Техас, Алиша М., нас 19*

### Сүүлчийн зоогийг дурсан сана



Бид Есүс Христийн цагаатгагч золиослол, Түүний бие болон цусыг төлөөлсөн бэлгэдлийг зохистойгоор хүртэх нь чухал болох

тухай бодох ёстой. Түүнчлэн бид Түүнийг арванхоёр дагалдагчтайгаа хамт талх ба дарсыг адисалсан үеийн тухай бодож болно.

*Мексик, Морэлос, Ионас А., нас 18*

### Гэрээнүүдээ тунгаан бод

Бага байхдаа ариун ёслолын турш би хэрхэн чимээ гаргахгүй байх

вэ гэдэг ганц л зүйл боддог байсан. Одоо би санваартан бөгөөд ариун ёслол нь утга учиртай, намайг сүнслэгээр өсгөдөг учраас би ариун ёслолын туршид тунгаан бодох хэрэгтэй гэдгийг ойлгодог. Аврагчийн Цагаатгалыг болон бидэнд хэрхэн хайраа үзүүлсэн тухай би боддог. Мөн түүнчлэн би ариун ёслолоос хүртсэнээр итгэл минь хэрхэн хүчирхэгждэг тухай болон баптисмын гэрээгээ биелүүлэх хүслээ хэрхэн нэмэгдүүлэх талаар боддог.

*Нигери улс, Абуржа, Ливай Ф., нас 19*

### Адислалуудынхаа төлөө талархлаа илэрхийл



Ариун ёслолын турш бид бидний төлөө хийсэн Аврагчийн золиослол ямар агуу байсан талаар бодох ёстой ба зүрх сэтгэлдээ

талархлаар дүүрэн байх ёстой. Би ариун ёслолоос хүртэхдээ Тэнгэрлэг Эцэг, Түүний хайрт хүү Есүс Христийн төлөө болон хүдээн авсан адислалуудынхаа төлөө талархдаг.

*Бразил, Парайба, Элэн С., нас 16*



### ДЭЛХИЙГ АРДАА ОРХИ

“Намайг хүүхэд байхад ариун ёслолын дундуур гайхалтай сайхан хөгжим тоглогд-

дог байсан. Удалгүй сүмийн удирдагчид хөгжим тоглохоо зогсоохыг биднээс хүссэн юм. Учир нь бидний оюун бодол Их Эзэн Аврагчийн цагаатгагч золиослол дээр бус харин хөгжмийн аянд төвлөрч байсан юм. Ариун ёслолыг адисалж, түгээх үед бид дэлхийгээс ангид байдаг. Бидний хүн нэг бүрд зориулагдсан энэ ёслолын гүн сүнслэг ач холбогдлыг ойлгосноор энэ нь сүнслэг байдлаа шинэчлэх үе болдог юм. Хэрэв бид ариун ёслолоос хүртэхдээ хайнга хандвал сүнслэгээр өсөж хөгжих боломжоо алдах болно.”

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Л. Том Пэрри, “As Now We Take the Sacrament (Бид ариун ёслолоос хүртэх үед),” Лиэхона, 2006 оны 5-р сар, 41.**

## ДАРААГИЙН АСУУЛТ

“Нэг найз маань ямар нэг муу зүйлийг ердөө ганцхан удаа хийхийг хүсэж байна. Хүмүүсийг энэ тухай ярих үед тэр үүнийг хийж үзсэн байх хүсэлтэй байгаа гэсэн. Энэ нь сайхан санаа биш гэдгийг ойлгоход нь би түүнд хэрхэн тусалж чадах вэ?”

Хариултаа [liahona.lds.org](http://liahona.lds.org) юм уу [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) эсвэл 3-р хуудсан дээрх хаягаар, хэрвээ хүсвэл өндөр нятралтай зургийн хамт 2014 оны 7-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Э-мэйл буюу захидалдаа дараах мэдээлэл болон зөвшөөрлийг оруулна уу: (1) овог нэр, (2) төрсөн огноо, (3) тойрог буюу салбар, (4) гадас буюу дүүрэг, (5) таны хариулт болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн бичгээр хийсэн өөрийн тань зөвшөөрөл, 18 нас хүрээгүй бол эцэг эхийн бичгээр гаргасан зөвшөөрөл (э-мэйл байж болно).

Хариултын хэмжээг тохируулах болон тодорхой болгохын тулд хянан засварлаж болно.



**Ахлагч  
Антони Д.Пэркинс**  
Дал

# АРАВНЫ НЭГ ДОТООД ХҮЧ ЧАДЛЫГ АВЧИРДАГ

*Аравны нэгээ шударгаар төлөх шийдвэрийг яг одоо гарга. Ингэх нь Их Эзэн амлалтуудаа биелүүлдэг гэдгийг мэдэхэд чамд туслах болно.*


**Е**рөнхийлөгч Томас С.Монсон “аравны нэгийг шударгаар төлөх нь аливаа хүнийг бусад зарлигуудыг сахих дотоод хүч чадлаар болон шийдвэр төгс байдлаар хангадаг” хэмээн заасан.<sup>1</sup> Залуу байхдаа энэ зарчмын талаар гэрчлэлтэй болох аз надад тохиосон юм.

Би 14 настай байхдаа анх ажил хийж эхэлсэн бөгөөд барилгын ажил хийж, цагт 2 ам. долларын цалин авдаг байлаа. Анхны долоо хоногийн маань цалин 80 доллар болсон байв. Би тухайн үеийн хамгийн шинэ хөгжмийн технологи болох найман замтай хуурцаг тоглуулдаг хөгжим авахыг хүсэж байв. Миний авахыг хүссэн бүрэн үйлдэлтэй загвар нь 320 долларын үнэтэй байв. Би дөрвөн долоо хоног ажилласны дараа хөгжим авах хүслээ ээж, аав хоёртойгоо баяр хөөртэй хуваалцсан юм.

## **Дөрвөн долоо хоногоос ч илүү**

Эцэг эх маань “Хөгжим авах хангалттай мөнгө олоход дөрвөн долоо хоногоос ч илүү хугацаа шаардлагатай. Чи авсан олон адислалынхаа төлөө Бурханд талархал илэрхийлж,

орлогынхоо 10 хувийг аравны нэг болгон төлөх хэрэгтэй. Мөн орлогынхоо 10 орчим хувийг засгийн газарт татвар болгон өгөх ёстой. Чи санхүүгийн хувьд ирээдүйдээ болон номлолдоо бэлтгэлтэй бай гэсэн бошиглогчдын зөвлөгөөг залуу наснаасаа дагаж сурах хэрэгтэй. Олсон орлогынхоо 30 хувийг хадгаламжийн дансанд хадгал гэж бид чамд зөвлөж байна” гэж мэргэн ухаанаар заасан юм.



**ТЭР АРГА  
ЗАМЫГ  
НЭЭХ БОЛНО**

“Бид бүгдээрээ аравны нэгээ төлж чадна. Бодит байдал дээр, бидний хэн нь ч аравны нэгээ төлөхгүй байж чадахгүй. Их Эзэн бидний шийдвэрийг хүчирхэгжүүлнэ. Тэр үүнтэй нийцэх арга замыг нээх болно.”

**Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Be Thou an Example (Үлгэр дуурайл бол),” Лиахона, 1997 оны 1-р сар, 42.**

Би дотроо хурдхан тооцоолж, хэрэв би эцэг эхийнхээ зааснаар хийвэл долоо хоног бүр 40 доллартай байх бөгөөд хүссэн хөгжмөө авахын тулд доод тал нь хоёр сар ажиллах хэрэгтэй болно гэдгээ ойлгов. Миний өмнө материаллаг зүйлийг эн тэргүүний зүйлээ болгох эсвэл аравны нэгээ төлж, мөнгө хадгалах золиослол хийхийг сонгох шийдвэрлэх мөч ирээд байлаа.

## **Эхлээд аравны нэгээ төл**

*Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд: Бусад хэрэгцээгээ хангах хангалттай мөнгө байхгүй байсан ч үүнийг [аравны нэгээ] эхлээд төл. Ингэснээр хувиа хичээх байдлаас гарахад чинь та нарт тусалж, Сүнснийг сонсоход илүү амархан болно” хэмээн зөвлөдөг.<sup>2</sup>

Би 14 настай байхдаа үлдсэн амьдралынхаа турш аравны нэгийг шударгаар төлөх шийдвэр гаргасан юм. Би бошиглогчийг дагаж, номлолд болон ирээдүйн боловсролдоо зориулан мөнгө хадгалахаар шийдсэн. Энэ туршлага нь надад хүсэл, хэрэгцээ хоёрыг ялгаж сурахад тусалсан юм. Би хамгийн сүүлийн үеийн технологийг авахыг хүссэн





боловч энэ нь надад хэрэггүй байв. Тиймээс би цөөн үйлдэлтэй илүү хямд загварыг нь авахаар шийдсэн бөгөөд энэ хөгжим нь намайг номлолд явах хүртэл үүргээ хангалттай гүйцэтгэж чадсан юм.

### Амлалтууд сахигддаг

Би аравны нэг төлснөөр Их Эзэн амлалтуудаа биелүүлдэг гэдгийг мэдэж авсан үед Түүний бусад зарлигуудыг сахих миний итгэл болон хүсэл илүү хүчтэй болж өссөн юм. Хэрэв би мацгийн өргөлөө өгөөмрөөр төлөх юм бол Тэр миний залбирлуудад хариулж мөн намайг үргэлжлүүлэн удирдах болно гэдгийг би мэдэж авсан юм (Исаиа 58:6–11-ийг үзнэ үү). Хэрэв би Мормоны Номыг уншвал Тэр үүний үнэнийг надад Ариун Сүнсний хүчээр үзүүлнэ гэдгийг ойлгосон (Моронай 10:4–5-ыг үзнэ үү). Хэрэв би мэргэн ухааны үгийг дагавал Тэр надад сайн эрүүл мэнд, мэргэн ухаан ба мэдлэгийг өгч, би “гүйхэд мөн ядрах нь үгүй” байж чадна гэдгийг мөн мэдэж авсан юм (С ба Г 89:18–21-ийг үзнэ үү). Хэрэв би ариун явдлын хуулийг сахивал Ариун Сүнс миний байнгын

хамтрагч байж, Аврагч надад хэзээ нэгэн өдөр Түүний дэргэд ичихгүйгээр зогсох итгэлтэй байдлыг өгнө гэдгийг ойлгож авсан билээ (С ба Г 121:45–46-г үзнэ үү).

Аравны нэг болон өргөлүүдийг төлснөөр өөр нэгэн дотоод хүч чадал ариун сүмийн гэрээнүүдээр дамжин ирсэн юм. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимолд “Ариун сүмд орохын тулд та нар аравны нэгээ бүрэн төлөгч байх ёстой”<sup>3</sup> хэмээн заадаг. Би ариун сүмд орох үедээ Бурханы оршихуйг болон Түүний хайрыг мэдэрдэг. Ариун сүмийн ёслолуудад бид мөнх бус амьдралын бэрхшээлүүдийг даван туулах “тэнгэрийн хүчийг” (С ба Г 95:8) хүлээж авдаг гэдгийг би гэрчилж байна.

### Хадгалагдсан адислал

Аравны нэг болон өргөлүүдийг төлөх нь Их Эзэн Өөрийн амлалтуудыг биелүүлнэ гэсэн миний итгэлийг өсгөсөн. Тэрээр бошиглогч Малахиагаар дамжуулан, “Бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр

шалга” хэмээн тунхагласан байдаг (Малахи 3:10).

Амьдралын минь турш, гэрлээд удаагүй байх үеийн санхүүгийн бэрхшээлтэй үед ч гэсэн Бурхан тэнгэрийн цонхнуудыг үргэлж нээдэг байсан бөгөөд ингэснээр манай гэр бүл амьдралын түр зуурын хэрэгцээт зүйлүүдийг хүлээн авсан юм. Аравны нэгийн хуулийг дуулгавартай дагаснаар та нарын итгэл амьдралд тань агуу хүчний эх сурвалж болон өснө гэдгийг би гэрчилж байна.

Би та нарын хүн нэг бүрийг болон бүх гишүүдийг амьдралынхаа турш аравны нэгээ бүрэн төлж, мацгийн өргөлөө өгөөмрөөр өгөх замаар Есүс Христийг болон Түүний бошиглогчдыг анхааран сонсоход урьж байна. Их Эзэн Өөрийн ариун зорилгын дагуу та нарыг зөв шударга хүслүүдээ биелүүлэхэд чинь хүчирхэгжүүлж мөн дэвжүүлэх болно гэдгийг би амлая. ■

### ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Be Thou an Example (Үлгэр дуурайл бол),” *Лиакхона*, 1997 оны 1-р сар, 42.
2. *Залуучуудын бат бөх байдлын төлөө* (2011), 38.
3. *Залуучуудын бат бөх байдлын төлөө*, 38.

# СҮМД ЭРГЭЖ ИРЭХ ЗАМАА ОЛОХ НЬ



*Би сайн мэдээнээс гадуур хариулт олохыг хичээсэн боловч зөвхөн хоосон байдлыг л олсон юм.*

## Дауг Бояк

**Б**и Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд өсөн боловч коллежид байхдаа сүмээс хөндийрөх шийдвэр гаргасан. Би “үнэнийг” өөр газруудаас олохоор маш гүехэн, хувиа хичээсэн эрэл хайгуул хийсэн. Надад амар амгалан эсвэл баяр баясал авчрах ямар ч хариулт олдоогүй учраас би гүнзгий сүнслэг харанхуй руу унасан юм. Би дахин хэзээ ч аз жаргалтай болохгүй юм шиг мэдрэмжтэй байв.

Гэсэн хэдий ч би сүмд идэвхтэй байх үедээ илүү аз жаргалтай байснаа ойлгож байлаа. Би сүмийн үйл ажиллагаануудад оролцсон нэр зүүж, амьдралыг маань захирч байсан муу нөлөөнөөс ямар нэг зүйл намайг чөлөөлнө хэмээн найдаж байсан. Гэвч миний хагас дутуу хүчин чармайлт их өөрчлөлт авчирсангүй. Би хичээлдээ анхаарал төвлөрүүлж, тэд дотор минь байсан хий хоосон мэдрэмжийг түр ч гэсэн мартуулна гэж найдаж байсан. Энэ нь түр зуур тус болсон боловч жинхэнэ хариулт болж чадаагүй юм.

Би олон дахин бүдэрч мөн гарах гарцгүй болсноо мэдээд сургуулиаа чөлөө авч, аялахаар шийдсэн юм. Би бага зэрэг мөнгө цуглуулсан боловч энэ нь удаан хугацаанд хүрэлцэхээргүй байлаа. Явахаасаа өмнө би итгэлээ бодитоор ашиглаж, багахан хадгаламжныхаа аравны нэгийг төлөхөөр шийдсэн. Энэ нь амар байгаагүй. Би гэрээсээ хол байх бөгөөд удахгүй мөнгө маань дуусах байлаа. Гэсэн хэдий ч би Бурхан байдаг гэдэгт найдаж, надад Түүний тусламж хэрэг болно гэдгийг мэдэж байлаа.

Би аравны нэгээ чекээр бичиж, бишоп руугаа илгээгээд Мормоны Номоо баглаж аваад замдаа гарав. Би бараг тэр даруйдаа Сүнсний дулаан мэдрэмжийг мэдэрсэн. Эргэлзээ болон харуусал маань ойлголт болон өөдрөг үзлээр солигдсонд би гайхаж билээ. Айдахогоос Вашингтон Ди Си хүртэл сүмийн гишүүд надад тусалсан бөгөөд хамгийн чухал нь тэд надад итгэл болон зөв шударга хүслүүдийг бий болгоход

тусалсан юм. Гэртээ байгаа юм шиг эргэн тойрны зүйлүүд тун дотно байв.

Богино хугацааны дараа би аялаа дуусгах хэрэгтэй гэдгээ мэдэж байсан юм. Энэ нь мөнгө байхгүйгээс бус харин илүү сайн аян зам намайг хүлээж байсан учраас л тэр. Гэртээ эргэж ирээд би бишоп болон гадасны ерөнхийлөгчтэйгөө уулзсан. Тэдний тусламжтайгаар би удалгүй номлогч болж, Их Эзэнд үйлчилсэн юм.

Одоо би аравны нэгээ төлөх эсвэл сүмийн удирдагчидтай уулзах бүрдээ өөрийнхөө жинхэнэ хөрвүүлгийн “эхлэлийг” санадаг. Үүнээс хойш надад уруудах, өгсөх зүйл байсан ч би сүнслэг байдлын хувьд хүчтэй хэвээр үлдэхийн тулд хичээл зүтгэл гаргасан юм. Тэнгэрлэг Эцэг миний итгэлийн багахан өргөлийг хүлээн авч мөн хайрын мутраа надад сунгасанд би үргэлж талархалтай байх болно. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Калифорнид амьдардаг.*



# ЭВДЭРШГҮЙ

“Бид арван зарлигийг эвдэж чадахгүй. Бид зөвхөн өөрсдийгөө тэдэнд зориулан эвдэж чадна.”

(Сэсил Б. Дэмиллэ, Америкийн кино найруулагч ба продюссер, “Төгсөлтийн яриа” [Бригам Янгийн Их Сургууль, 1957 оны 5-р сарын 31], 5; [speeches.byu.edu](http://speeches.byu.edu).)





# ЭЭЖИД Зориулсан адислал

Сюзан Баррэтт

Бодит түүхээс сэдэвлэв

*“Санваар сэргээгдсэн, хүмүүнд үнэн илчлэгдсэн, Бурхан дэлхийд хандан ярьсан, Түүний хүч чадал энд дахин байна” (Children’s Songbook, 89).*

**Х**үүхдийн хэсгийн хичээл дуусахад 10 настай Рубэн номлогчдыг хайж байв. Тэд түүнтэй хамт гэр рүү нь явах гэж байлаа. Ахлагч Санчез болон ахлагч Рояс нар Рубэн болон түүний ах Диего хоёрт номлогчийн хичээлүүдийг зааж мөн тэдэнд баптисм хүртээсэн юм. Одоо Рубэн тэднийг хамгийн сайн найзуудаа гэж боддог болсон байна.

Рубэн хаалттай байсан ангийн хаалганы цонхоор харав. Номлогчид тэнд байлаа! Гэхдээ тэд юу хийж байсан юм бол? Тэд тойргийн гишүүн ахын толгой дээр гараа тавиад Рубэнийг гишүүнээр батлагдах үед хэлж байсан шиг залбирал хэлж байгаа юм шиг харагдав.

Тэднийг өрөөнөөс гарч ирэхэд тэр номлогчдоос “Та нар юу хийж байсан бэ?” хэмээн асуув.

“Бид Мэндоза ахад санваарын адислал өгч байсан юм” хэмээн ахлагч Санчез хэлэв. “Энэ нь онцгой залбиралтай адилхан бөгөөд тайтгарал өгч, хэн нэгэнд асуудлаа шийдэхэд нь тусалж эсвэл өвчтэй хэн нэгнийг эдгээж чадна.”





Дараагийн ням гарагт сүмийн цуглааны дараа Рубэн дахиад номлогчдыг хайж байв. “Та нар манай гэрт ирээд ээжид минь адислал өгч чадах уу? Түүний нуруу их өвдөөд байгаа” хэмээн тэр асуув.

Тэд бүгдээрээ Рубэний гэр рүү яаран ирэв. Ахлагч Санчез, Рояс нар Рубэний ээжтэй ярилцлаа. Тэр сүмийн гишүүн байсан бөгөөд удаан хугацааны турш сүмд ирээгүй байжээ.

“Таны бие сайнгүй байгааг бид ойлгож байна, Гарсия эгч ээ” гэж ахлагч Рояс хэлэв.

“Миний нуруу хэдэн долоо хоногийн турш хүнд өвдөж байна” хэмээн тэр тэдэнд хэлэв. “Би олон эмчтэй уулзсан боловч тэд надад тусалж чадсангүй.”

“Рубэн биднийг энд ирж, танд санваарын адислал өгөхийг хүссэн юм. Та биднээс адислал авах уу?” хэмээн ахлагч Санчез асуув.

“Тэгэлгүй яах вэ” хэмээн ээж нь хэллээ.

Номлогчид толгой дээр нь гар тавин, адислал өгөхөд ээжийнх нь хацрыг даган нулимс урсав. Тэднийг адислал өгч дуусахад Рубэн ээжийгээ тэвэрч, “Адислал танд тусална гэдгийг би мэдэж байна” хэмээн хэлэв.

Гурван өдрийн дараа номлогчид

Рубэний ээжийн бие ямар байгааг мэдэхээр буцаж ирэв. “Би та нарыг харсандаа маш их баяртай байна. Та нарыг надад адислал өгсний дараа нурууны маань өвдөлт алга болсон ба одоо зүв зүгээр болсон!” гэж ээж хэллээ.

“Гарсия эгчээ, Тэнгэрлэг Эцэг таныг эдгээсэн” гэж ахлагч Санчез хэлээд “Тэр бидэнд санваарын эрх мэдлээ ашиглан таныг адислах замаар Өөрт нь туслах боломжийг олгосон” гэлээ.

Дараагийн болон түүний дараах ням гараг бүрд ээж нь Рубэн, Диго хоёртой хамт сүмд явдаг болсон юм. Тэрээр санваарын хүч чадал нь бодитой гэдгийг мэдсэн бөгөөд Рубэн ч бас үүнийг мэдэж байлаа. ■

*Энэ өгүүллийг бичигч АНУ-ын Ютад амьдардаг.*



## САНВААР ГЭЖ ЮУ ВЭ?

Санваар бол Тэнгэрлэг Эцэгийн нэрээр үйлдэх эрх мэдэл юм.

Сүм дэх хөвгүүд зөв зохистой үедээ, 12 настайдаа Аароны санваарыг хүлээн авч болно. Мөн тэд зөв зохистой байхдаа, 18 настайдаа Мелкизедек санваарыг хүлээн авч болно.

Аароны санваар нь дикон, багш болон прист гэсэн албан тушаалтай. Мелкизедек санваар нь ахлагч, дээд прист, патриарх, Дал ба төлөөлөгч гэсэн албан тушаалтай.



### Аароны санваартнуудын хийж болох зарим зүйл:

- Ариун ёслолыг бэлтгэж (багш нар ба пристүүд), адисалж (пристүүд) мөн түгээх (бүгд)
- Гэрийн багш нар болох (багш нар ба пристүүд)
- Баптисм хүртээх (пристүүд)
- Мацгийн өргөл цуглуулах (дикон, багш ба пристүүд)
- Бусдыг Аароны санваарт томилох (пристүүд)

### Мелкизедек санваартнуудын хийж болох зарим зүйл:

- Аароны санваартнуудын хийдэг бүх зүйл дээр нэмээд:
- Баптисмын дараа сүмийн гишүүнээр батлах
- Санваарын адислалууд өгөх
- Сүмийн хурлуудыг удирдаж мөн дуудлага өгөх



**Ахлагч**  
**Нийл Л.Андэрсэн**

Арванхоёр Төлөөлөгчийн  
чуулга

*Арванхоёр Төлөөлөгчийн  
чуулгын гишүүд бол  
Есүс Христийн онцгой  
гэрчүүд юм.*

# Би ОДОО ХЭРХЭН НОМЛОГЧ ШИГ БАЙХ ВЭ?

Сайн мэдээг хуваалцах  
арга замуудын төлөө  
залбир

Та сүмд хэнийг урихаа  
мэдэхийн төлөө залбир

Та гадуур хувцсан дээрээ  
номлогчийн энгэрийн тэм-  
дэг зүүсэн бүрэн цагийн  
номлогч биш боловч та зүрх  
сэтгэлдээ номлогч хэвээрээ  
байж чадна.

Номлогчдын төлөө  
залбирч бай.

Гэрлээ тодруулж мөн  
Есүсийн жишээ бай.

*“Энэ бол гайхамшиг,”* Лиахона,  
2013 оны 5-р сар, 77–80.







Ахлагч  
Скотт Д.Вайтинг  
Дал

# Бишрэл хүндэтгэлийн Хурга



*“Амар амгаланг Би  
та нарт үлдээнэ. Би  
Өөрийн амар амга-  
лангаа та нарт өгнө”  
(Иохан 14:27).*

**Н**амайг долоо орчим  
настай байхад манай  
Хүүхдийн хэсгийн ерөнхий-  
лөгч хүүхдүүдэд илүү бишрэл  
хүндэтгэлтэй байхад нь туслахыг

хүссэн юм. Тэр хурга шиг хэлбэр-  
тэй нэг том самбар хийсэн бай-  
лаа. Ямар нэг хүүхэд бишрэлтэй  
байх бүрд тэр хурганы хэлбэртэй  
наадаг цаасыг тухайн хүүхдийн  
нэрний хажууд наадаг байв. Би  
хурга хэлбэртэй наадаг цааснуу-  
даас нэгийг авахыг үнэхээр хүсч  
байлаа. Нэг өдөр би Хүүхдийн  
хэсэгт байхдаа гараа өвдгөн дээ-  
рээ тавиад чимээгүй сууж, миний  
бишрэлтэй байгааг анзаарах болов  
уу гэж Хүүхдийн хэсгийнхээ ерөн-  
хийлөгч рүү ширтэж байлаа. Нэг  
өндөр хөвгүүн миний урд сууж  
байсан бөгөөд би түүний ардаас  
харагдахыг хичээж байв.

Намайг бишрэлтэйгээр сууж  
байхад төгөлдөр хуурч хүүхдийн

нэгэн сайхан, намуухан дууг тог-  
лож эхлэв. Үүнийг сонсож байхад  
амар амгалан мэдрэмж над дээр  
ирж, нулимс хацрыг минь даган  
урсаж эхлэв. Би дотроо яагаад  
тийм их аз жаргалтай байж, амар  
амгаланг мэдэрснээ мэдээгүй юм.

Хүүхдийн хэсгийн хичээлийн  
дараа би ээждээ юу мэдэрснээ  
хэлэхэд ээж минь энэ бол Сүнс  
байсан хэмээн хэлэв. Тэр өдөр  
би Сүнс яаж мэдрэгддэгийг сур-  
сан юм. Надад чухал шийдвэр  
гаргах хэрэгтэй болоход мөн  
Сүнсний удирдамж хэрэгтэй  
болох үед би тэр өдөр хэр зэрэг  
амар амгаланг мэдэрснээ санаж,  
улмаар Сүнс надтай яаж ярьдгийг  
таньж чаддаг. ■







ДЭЛХИЙ ДАЯАР НАЙЗУУДАЙ БОЛОХ НЬ

## Чио, амици!\*

Эми Жэн Лэвитийн  
хийсэн ярилцлагаас

**Ч**иний амьдардаг хот хоч нэртэй юу? Лорэданагийн амьдардаг хот заримдаа мөнхийн хот гэж нэрлэгддэг. Лорэдана Италийн Ромд амьдардаг. Энэ үзэсгэлэнтэй, түүхэн хотод айлчлан очиж болох маш олон сонирхолтой газар байгаа. Жишээ нь, Колоссеум болон Трэви усан оргилуур гэх мэт.

Өглөө бүр Лорэданагийн гэр бүл хамтдаа судраас уншсаны дараа өглөөний хоолоо иддэг (ихэвчлэн эрдэнэ шиш болон сүү). Тэгээд тэр сургуульдаа явдаг. Тэр урлагийн болон компьютерийн хичээлд дуртай. Тэр гэртээ ирээд бяцхан дүү Франческотойгоо тоглох дуртай. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.

\*Италиар "Сайн уу, найзууд аа!"

# Би Италийн ЛОРЭДАНА байна



*Миний ээж сүмд орохоосоо өмнө орой бүр надад Мормоны Номыг уншиж өгдөг байсан. Ээж минь номлогчдоор хичээл заалгахаар шийдсэн үед тэднийг Мормоны Номоос заахад нь би тэр номыг мөн болохыг таньсан.*







Миний ээж Анжэлина гэдэг өндөр настай эмэгтэйг халамжилдаг. За-римдаа бямба гарагт би Анжэлинад түүх ярьж өгч мөн Хүүхдийн хэсгийн дуунуудаас дуулж өгдөг. Би Анжэлина найздаа туслах дуртай.



Зул сараар болон улаан өндөгний баяраар би найзууддаа мөн гэр бүлийнхэндээ өөрийн гараар хийсэн бэлэг өгөх дуртай. Би ил захидал ба онцгой зураг хийх зургийн жаазыг өөрөө хийдэг.

Манай гэр бүлийнхэн далайн эргийн наран шарлагын газар руу явах, Ром дахь түүхэн газруудад очих эсвэл зүгээр л тоглоомын талбай дээр тоглох дуртай.

Би ихэвчлэн оройн хоолонд паста Аматирициана хийхэд нь хойд эцэгтээ тусалдаг.



## БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ

Ээж, хойд эцэг хоёр маань Италийн Ромын ариун сүм онцгойлон адислагдсаны дараа лацдан холбогдохоор төлөвлөж байгаа. Би тэр өдрийг сэтгэл хөдлөн хүлээж байна. Энэ нь манай гэр бүлийн хувьд маш онцгой өдөр байх болно!

## АРИУН СҮМ ЯВАХАД БЭЛЭН БОЛЛОО!

Лорэданагийн цүнх түүний дуртай зарим зүйлээр дүүрсэн байна. Эдгээр зүйлийн алийг нь та нар цүнхэндээ хийх байсан бэ?





# Италийн Массимо

Массимо хөл бөмбөгийн хувцсаа өмссөн байна. Гэхдээ чи түүнд сүмийн хувцсыг эсвэл Италийн үндэсний хувцсыг нь өмсгөж болно. Энэ хуудсыг будаж, хэдэн хэсэг хайчлахаасаа өмнө хатуу цаасан дээр наа. ■







# Тусч бай



## Есүсийн заасан зүйл

Хэн нэгэн биднээс тусламж хүссэн үед бид юу хийх ёстой тухай Есүс Христ нэг өдөр заасан юм. Тухайн хүний гуйснаас илүү зүйлийг бид хийх эсвэл өгөх ёстой гэж Тэрээр хэлсэн. Матай 5:40–42 дээрх Есүсийн үгсийг уншиж, энэ нь яагаад “хоёр бээр явах” гэж нэрлэгддэгийг олж мэд.




## Өнөө үед Есүсийг дагах нь



Нэг орой би ах, эгч нартайгаа хамт гэрээ цэвэрлэж эхэлсэн. Тэгээд аав маань ирээд одоо унтах цаг болсон гэж хэлэв. Өглөө намайг сэрэхэд ээж минь “Тэрээ цэвэрлэсэнд чинь маш их баярлалаа” гэж хэлсэн.  
Канад, Албэрта, Элизабет С., нас 8

Би хүмүүст туслах дуртай. Ээж маань үйлчлэлийн үйл ажиллагаанд оролцоход үед би түүнтэй хамт явж, туслахдаа дуртай байдаг. “Тусламжийн гар,” Мексик, Чихуахуа, Люс Н., нас 6



## Энэ сарын даалгавар:

- Хичээлийн турш Хүүхдийн хэсгийн багшдаа туслах арга замыг хай.
- Ах, эгчдээ гэрийн даалгавар эсвэл гэрийн ажлаа хийхэд нь тусал.
- Хэлүүлэлгүй өрөөгөө цэвэрлэж, эцэг эхдээ гэнэтийн бэлэг барь.
- Би өөрийгөө . . . гэж сорьж байна.

# Угандад хөгжим ТОГЛОХ НЬ

*Хүн болгоны өмнө гарч, хөгжим  
удирдах аа? Жорж үүнийг хийж чадна.*

**Дэвид Диксон**

Сүмийн сэтгүүлүүд

Хүүхдийн ангиа төгсөхөөс  
Хөмнө тийм ч олон хүүхэд  
сүмийн дуудлагад үйлчилдэггүй.  
Харин Уганда улсын Жорж Н.  
салбартаа дууны удирдаачийн  
дуудлагад дуудагдах үедээ дөнгөж  
таван настай байсан.

Дууны удирдаач гэдэг нь дуу  
удирдахын тулд ариун ёслолын  
цуглааны явцад хүн болгоны өмнө  
зогсдог хүн юм. Энэ бол чухал  
ажил!

“Би жаахан байхдаа их сандар-  
даг байсан” гэж Жорж хэлэв. Гэсэн  
хэдий ч тэрээр хамгийн сайнаараа  
хийдэг байв. Тэр долоо хоног  
тутам сайжирч байсан. Удал-  
гүй тэрээр өөртөө итгэл-  
тэй удирддаг болсон.

Жорж дуудлагат  
ажлаа хийхдээ дуртай.  
“Би сайхан мэдрэмжтэй  
байдаг” гэж тэр хэлээд  
“Өрөөн дотор Сүнс  
байгааг би мэдэрдэг”  
гэлээ.

Хөгжим бол Жоржийн амьд-  
ралын нэг том хэсэг юм. Тэр бас  
төгөлдөр хуур болон гитар тог-  
лодог. Мэдээж, Жорж хөгжмийн  
мэдлэгтэй гэр бүлд төрсөн бо-  
лохоор энэ нь түүнд тус болдог.  
Тэд—Жорж, түүний эцэг эх, зур-  
гаан эгч, нэг ах нь гээд бүгдээрээ  
хамтдаа дуулах дуртай. Хамгийн  
ахмадаас хамгийн залуу хүртэлх  
тэдний нэрс нь Росила, Мир-  
риам, Нанси, Ашли, Жорж, Чайэн,  
Онида болон Гидеон нар юм.  
Тэдний гэр бүлээрээ дуулах дур-  
тай дуу бол “Хүүхдийн залбирал”  
(Хүүхдийн дууны ном, 12).

Одоо Жорж 12 настай ба талх,  
усыг түгээхэд туслахаар ариун ёс-  
лолын цуглааны нэг хэсэгт завгүй  
байдаг. Түүний 5 настай эрэгтэй  
дүү Гидеон нь заримдаа дуу удир-  
дахад тусалдаг. Жорж түүнд дуу  
хэрхэн удирдахыг зааж өгсөн.

Ах, дүү хоёр дуу удирдахдаа  
хоёул аз жаргалтай инээмсэглэдэг.  
Цуглаанд Ариун Сүнсийг авчрахад  
тусалж байгаагаа тэд мэддэг. ■








## ЖОРЖИЙН ТУХАЙ


- Хөгжмөөс гадна Жорж хөл бөмбөг тоглох дуртай.
- Түүний дуртай хоол нь будаа, чихэрлэг төмс, вандуй, газрын самар юм.
- Дуртай хичээлүүд нь англи хэл ба математик.
- Жорж гэр бүлийнхэнтэйгээ хамт хөлгөн тоглоомуудаар тоглох дуртай. Түүний дуртай тоглоом бол Скаттергорис юм.



## ХӨГЖИМ ХЭРХЭН УДИРДАХ ВЭ

Чи бас хөгжим удирдахад суралцаж чадна! "Мормоны Номын түүхүүд" (Хүүхдийн дууны ном, 118) дээр хэрхэн удирдахыг суръя:

1. Дууны эхлэлд байгаа хоёр тоог харна уу. Дээд талын тоо нь нэг хэмжээнд буюу дууны богинохон хэсэгт хэчнээн цохилт байгааг хэлж байгаа юм. Энэ дуу нь хэмжээ бүрдээ дөрвөн цохилттой байна.
2. Гараа өргөн, хуруунуудаа нийлүүлээд чөлөөтэй барь. Гараа доош нь болго. Гараа зүүн тийш болго. Гараа баруун тийш болго. Гараа дээш нь болго.
3. Дууны хэмжээ бүр дээр энэ хөдөлгөөнийг давт.
4. Үргэлжлүүлэн давтаад байгаарай. Удахгүй чи гэр бүлийнхээ цуглаан дээр дуу удирдахад бэлэн байх болно.



# Санваарын ёслолтууд ба ариун сүмийн ажил гэр бүлийг адисалцдаг

## Жэннифэр Мадди

Карл завины зогсоол руу гүйж Кочин, аавыгаа харахдаа баяртай байлаа. Карлын аав нь загасчин байсан ба ихэнхдээ Карл орой болгон аавтайгаа уулзахын тулд завь руу гүйж очдог байсан.

“Хурдлаарай аав аа!” гэж Карл дуудав. “Би танд өнөөдөр зурсан зургаа үзүүлмээр байна” гэв.

“Сайн байна!” гэж аав нь хэлээд “Тэхдээ аав нь завиа уях хэрэгтэй” гэв.

Карл аавыгаа завиа зогсоолтой холбон, бүдүүн утсаар уяхыг нь

анхааралтай ажиглав. “Та яагаад завийг сайн уях хэрэгтэй юм бэ?” гэж Карл аавыгаа том уяа татаж байх үед нь асуув.

Аав нь зогсоол дээрх дороо том нүхтэй завийг заагаад “Тэр завь зогсоолд сайн уягдаагүй байсан. Тэгээд өнгөрсөн шуургуанаар энэ завины уяа суларч, зарим чулуунд цохигдсон юм” гэв.

Карл нүдээ том болгон, гайхан харав.

“Бид аюулгүй байж болохын тулд Тэнгэрлэг Эцэгтэйгээ

холбогдоход Тэрээр хэрхэн бидэнд тусалдаг талаар бодож үзэв үү?” гэж аав нь асуув.

“Судрууд?” гэж Карл тааж хэлэв.

“Зөв байна” гэж аав хэлэв. “Тэр бидэнд бас баптисм, ариун ёслол гэх мэт санваарын ёслолуудыг өгсөн. Ээж бид хоёр чинь ариун сүмд гэрлэсэн. Тэгснээрээ манай гэр бүл үүрд мөнх холбогдож чадсан юм.”

Карл олсыг авч, аавдаа хамгийн сүүлийн зангилааг хийхэд туслав. “Бид хамгийн чанга зангилааг хийлээ!” ■

*Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.*

## СУДАР БА ДУУ

- Матай 18:18
- “Би ариун сүм харах дуртай”  
*Children’s Songbook, 95)*

## ГЭР БҮЛЭЭРЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Танай гэр бүл Матай 18:18-ыг уншаад аливаа зүйл “тэнгэрт холбогдох” гэдэг нь ямар утгатай талаар ярилцаж болно. Урт уяаг ашиглан, та нар ээлж ээлжээр зангилаа гаргаж мөн санваарын ёслолууд нь таны амьдралыг хэрхэн адисалсан тухай ярьж болно.








Хүүхдэд нэр өгч адислах



Усанд умбуулалтаар хийгдэх баптисм



Өвчтөнийг адислах



Өвчтөнийг адислах

## ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГТЭЙ ХОЛБООТОЙ БАЙХ НЬ

Энэ хуудсыг салгаж аваад өнгийн цаасан дээр цавуугаар наа. Зурагнуудыг хайчилж аваад тэднийг ширээн дээр юм уу шалан дээр доош харуулан тавь. Ээлж ээлжээр адилхан зургийг олохын тулд хоёр зургийг дээш нь харуул. Хэн нэгнийг адил зураг олох үед зурган дээр дүрслэн харуулсан ёслол биднийг Тэнгэрлэг Эцэгтэй ойр байхад хэрхэн тусалдаг талаар тухайн хүнээр яриулаарай.



Хүүхдэд нэр өгч адислах



Усанд умбуулалтаар хийгдэх баптисм



Ариун ёслол



Ариун ёслол



Ариун сүмийн гэрлэлт



Ариун сүмийн гэрлэлт



Гишүүний баталгаа



Гишүүний баталгаа

# БИДНИЙ ХУУДАС



Сальвадор, Мэрари С., нас 11



Номлогчид, Бразил, Мариа Клара А., нас 9

Филиппинээс ирсэн 10 настай Пауло болон Карло Д. хоёр бол ихэр юм. Тэд хурдхан санваар хүртэх насанд хүрч, ариун ёслол түгээхийг тэсэн ядан хүлээж байна. Тэд бусдад сайн мэдээний талаар заах дуртай бөгөөд одооноос номлолд үйлчлэхээр бэлтгэж байна. Карло амьд бошиглогчийн талаар мэддэг гэдгээ хүн бүрд хэлдэг бол Пауло Мормоны Номоо сургууль дээрээ авчирч, ангийнхаа найзуудтай хамт унших дуртай. Тэд өдөр бүр судруудыг уншиж, ням гарагт сүмд очих нь чухал гэдгийг мэддэг. Карло, Пауло хоёр тагалог ба илокано гэсэн хоёр хэлээр чөлөөтэй ярьдаг бөгөөд тэд сургуульдаа англи хэл сурч байгаа. Тэд найзуудтайгаа сагсан бөмбөг тоглох дуртай.



Нэг өдөр сургууль дээр найзууд маань намайг хоосон ангид ороод нэг муу үгийг чангаар хэл гэж өдсөн юм. Би тэдэнд үгүй гэж хэлэхэд тэд намайг шоолсон. Тэгэхээр нь би за гэж хэлээд тэр үгийг чимээгүй бас хурдхан хэлчихсэн. Дараа нь би хийсэн зүйлдээ их харамссан. Тэр орой би бүх зүрх сэтгэлээрээ залбирч, муу үг хэлсэн алдаагаа наманчилсан юм. Би зөв зүйлийг мэдэхийн тулд үргэлж Тэнгэрлэг Эцэгтээ хандаж болно гэдгийг мэднэ. Хэрэв ямар нэг зүйл буруу байвал, найзууд маань тэр зүйлийг хий гэж хэлсэн ч гэсэн би үгүй гэж хэлнэ. Би наманчлалд талархаж байна!

Мексик, Паола Л., нас 10

## ЕСҮСТЭЙ АДИЛ БАЙХЫГ ХИЧЭЭХ НЬ

Бид сургууль дээрээ бүтэн жилийн турш Фэстиданза гэж нэрлэгддэг нэгэн гайхалтай үйл ажиллагаанд бэлтгэж байсан юм. Жил бүр энэ арга хэмжээ нь бямба гарагт зохиогддог. Тэгтэл энэ үйл ажиллагаа ням гарагт зохиогдохоор боллоо гэж захирал маань нэг өдөр хэлсэн. Бид ням гарагт сүм рүү явдаг шүү дээ гэж би ээждээ хэлсэн бөгөөд би хүндэтгэлийн өдрийг сахихдаа баяртай байдаг.




Перу, Исаиас Р., нас 6





Би *Лиахона* сэтгүүлийн хүүхдэд зориулсан хэсэгт дуртай. Учир нь тэнд байдаг түүхүүд нь Тэнгэрлэг Эцэгийн талаар мэдэж авахад минь надад тусалдаг. Би үргэлж ээжээсээ түүх уншиж өгөхийг гуйдаг. Би эвлүүлдэг тоглоом, тахиралдсан жим, буддаг зургуудад болон ярьсан түүхүүдэд дуртай. Би Хүүхдийн хэсэгт шинэ зүйлүүд сурах дуртай. Тэнгэрлэг Эцэг намайг хайрладаг ба та нарыг ч бас хайрладаг гэдгийг би мэднэ. Би үргэлж Түүнийг санаж мөн зөвийг сонгохыг хичээдэг.

**Никарагуа, Жослин С., нас 4**



Баптисм хүртсэн өдөр маань миний амьдралын хамгийн сайхан үйл явдал байлаа. Баптисм хүртсэнээсээ хойш би бүх үйлдлийнхээ төлөө өөрөө хариуцлага хүлээх болно гэж ээж минь надад заасан. Тэрхүү өдөр аав, бид хоёр хоёулаа цагаан хувцас өмсөв. Би сандарч байсан боловч аавынхаа гараас бариад усан санд орохдоо бүх зүйл зүгээр байх болно гэдгийг мэдсэн. Аав минь баптисмын залбирал хэлээд намайг усанд дүрэхэд би үгээр дүрслэхийн аргагүй гайхалтай зүйлийг зүрх сэтгэлдээ мэдэрч билээ. Тэгээд би гишүүнээр батлагдаж, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авсан. Би баптисм хүртсэндээ маш их баяртай байна. Есүс Христ надад жишээ үзүүлсний адилаар би дүүдээ жишээ үзүүлж байна. Есүс Христ амьд бөгөөд биднийг хайрладаг гэдгийг би мэднэ.

**Гватемала, Ричард Х., нас 8**



**Аргентин, Агустина Б., нас 10**



**Аргентин, Марианэлла Б., нас 7**



**Сантиаго болон түүний дүү Жаиро**

Би бага байхаасаа л Аароны санваар хүлээн авахыг хүсдэг байсан. Би санваар аваад ариун ёслолыг түгээх боломжтой болох бөгөөд ариун сүмийн үүд хаалга надад нээлттэй байх болно. Энэ сэргээгдсэн сүмийн гишүүн байх нь гайхалтай боломж ба би энэ сайн мэдээ үнэн гэдгийг мэднэ. Удахгүй би олон зүйл сурч авсан Хүүхдийн хэсгээсээ явж, Залуу эрэгтэйчүүдийн бүлэгт - өсвөр үеийнхний батальонд шилжин, нэгдэх болно.

**Эквадор, Сантиаго П., нас 11**

“Тэрбээр туйлын тансаг цав цагаан элбэг орхимжтой байв. Энэ нь миний урьд өмнө нь харсан бүхнээс үлэмж цагаан байв. Түүний нэр Моронай байсан.”

Иосеф Смит—Түүх 1:30–33-ыг үзнэ үү.)

**Мексик, Эрик Х., нас 9**



### **ЛИАХОНА-ТАЙ ХУВААЛЦ**

Та зурсан зураг, гэрэл зураг эсвэл болсон явдлаа интернэтэд [liahona.lds.org](http://liahona.lds.org) хаягаар мөн [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар “Our Page” гэсэн гарчигтай хэсэг рүү э-мэйлээр эсвэл 3-р хуудсан дээрх хаяг руу шуудангаар илгээж болно.

Ирүүлсэн материал бүрд хүүхдийн овог нэр, нас (3-11 нас), хүйс болон эцэг эхийн нэр, тойрог эсвэл салбар, гадас эсвэл дүүрэг, хүүхдийн бичсэн материал болон гэрэл зургийг нийтлэхийг зөвшөөрсөн эцэг эхийн бичгээр хийсэн зөвшөөрлийг (э-мэйлээр хүлээж авна) оруулсан байх шаардлагатай. Аврагчийн зургийг зурж явуулахгүй байхыг хүсье. Материалын хэмжээг тохируулах, тодорхой болгох үүднээс хянаж, засварлах болно.

# Виллийн гайхалтай санаа

Лин Грийнвэй

Бодит түүхээс сэдэвлэв

Вилл ариун сүмийн зурагтай болохыг хүсчээ. Тэр үүнийг өрөөндөө өлгөхийг хүсэв. Тэрээр ариун сүмийн зургийг өрөөндөө байлгах нь сайн зүйл хэмээн бошиглогчийн хэлэхийг нь сонссон байв.

“Ээж, та надад ариун сүмийн зураг авч амжсан уу?” гэж Вилл асуув.

“Аваагүй байгаа” гэж ээж нь хэлэв. Ээж нь шинэ төрсөн хүүхдийг асраад завгүй байв.

“За за” хэмээн Вилл хэлэв.

Вилл ариун сүмд дуртай байв. Энэ нь гэр бүлүүд хамтдаа лацдан холбогддог газар гэдгийг мэдэж байв.

Вилл бага зэрэг гунигтай байлаа. Ээж нь дэндүү завгүй



байв. Тэр хэрхэн ариун сүмийн зураг авч болох вэ?

Тэгтэл Виллд нэгэн гайхалтай санаа төрлөө. Тэр ээжийгээ хүлээх хэрэггүй байлаа!

Вилл тосон харандаа, цаас олохоор гүйв. Тэгээд тэр ширээн дээрээ суугаад зурж эхлэв.

Удаан хугацааны дараа Вилл тосон харандаануудаа тавилаа. Тэр гал тогоо рүү гүйн орж, зурсан зургаа өргөн, ээждээ харууллаа.

“Ариун сүмийн гайхалтай зураг байна” гэж ээж нь хэлжээ.

“Үүнийг миний унтлагын өрөөнд өлгөцгөөе” гэж Виллиам хэлэв.

“Энэ чинь ёстой мундаг санаа!” гэж ээж хэллээ. ■

*Зохиогч нь АНУ-ын Пенсилванид амьдардаг.*





# ХЭЗЭЭ ГЭДЭГ ҮГЭЭС ИРДЭГ ХҮЧ ЧАДАЛ

Кэлли Луис Урари

Миний нөхрийн өвчин эмгэг гэнэт илэрсэн. Нэг өглөө тэр зүлэг тайрч байгаад гэнэт бие нь өвдөж эхэлсэн юм. Маргааш нь тэрээр сэхээн амьдруулах тасагт хэвтэж байв. Сэхээнэс мэс заслын өрөөнд шилжүүлэх үед эмч нарын нэг нь миний нөхрийг аварч чадах эсэхэд эргэлзэж байгаагаа хэлсэн юм.

Түүний туссан өвчин нь ховор тохиолддог өвчний нэг байсан учраас түүнд амьд үлдэх боломж тун бага байв. Бүх зүйл ингэж эргэсэнд би итгэж чадахгүй байлаа. Би цөхөрч эхлэв.

Аз болоход Пиэр маань эхний мэс заслаа давж, эрчимт эмчилгээний тасагт шилжлээ. Хэдийгээр хугацаа орох хэдий ч түүний амьд үлдэх боломж нь цаг өнгөрөх тусам нэмэгдэж байлаа. Эхний мэс заслын маргааш өглөө нь нэг сувилагч надтай ярив. Тэрээр Пиэрийг дараагийн шатны эмчилгээндээ чухам хэзээ орсон тухай ярилаа. Би тэрхүү хэзээ гэдэг үгийн нөлөөний талаар бодолд автав. Хэзээ гэдэг үгэнд *яах бол* гэсэн үгнээс хавьгүй илүү найдвар оршиж, энэ үг нь итгэлтэй байдал, хүлээлтийг бий болгож байсан. Би тэр сувилагчид энэ үгийг сонгосонд нь талархахад тэрээр инээмсэглэж билээ.

Пиэр санваарын олон адислал хүлээн авсан бөгөөд тэдгээр нь түүнд агуу дэмжлэг өгсөн. Бид амьдралдаа Их Эзэний гарыг анхааран харахыг мэддэг байлаа. Түүний нөлөө *ирэх болов уу* гэдэг нь биш харин хэзээ ирэх бол гэдэг нь асуудлын гол байдаг байв. Пиэрийн бие муудах бүрд би түүнд адислалуудын талаар мөн бид Их Эзэнд итгэх итгэлээ үзүүлэх ёстойг сануулдаг байв. Энэ явдал нь ариун нандин аян зам байсан ба өдөр бүр нь бэлэг байсан юм.



*Бид амьдралдаа Их Эзэний гарыг анхааран харахыг мэддэг байлаа. Түүний нөлөө ирэх болов уу гэдэг нь биш харин хэзээ ирэх вэ гэдэг нь асуудлын гол байдаг байв.*

Хэзээ гэдэг үгнээс ирэх найдвар нь биднийг эерэг хандлагатай байхад тусалсан. Гэсэн хэдий ч, энэ аян замын 18 дахь өдөр бүх зүйл буруу тийш эргэлээ. Долоо дахь мэс заслын үеэр эмч нар түүний өвчин нь хэт их тархсан байна гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Эмч нарын баг Пиэр тэр шөнийг тэсэн гарч чадахгүй гэдгийг нулимс дуслуулан байж хэлэв.

Мөнхийн хань минь хөшигний цаана одох үед би дэргэд нь байх боломжтой байлаа. Өмнөх эхнэрээс нь төрсөн цорын ганц хүү нь аавтайгаа утсаар ярьж, хайртай гэдгээ хэлсэн нь бидний хувьд адислал байв. Пиэр амар тайван амьсгал хураасан юм.

Хэдэн долоо хоногийн дараа намайг түүний булшны дэргэд зогсож байтал Мозая 2:41 дээрх: “Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай. Учир нь болгоогтун, . . . *хэрэв* тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд тэнгэрт хүлээн авагдах болно” гэсэн тайтгарлын үгс санаанд орж ирэв (онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Пиэр бид хоёр энэ судар дээр гарсан *хэрэв* гэдэг үг нь хэзээ гэсэн утгатай гэдэг дээр санал нийлсэн юм. Гэрээнүүддээ үнэнч үлдсэнээр дахин нэгдэх болно гэдгээ бид мэддэг байсан ба энэ нь хэзээ вэ гэдэг нь л бидний асуух асуулт байсан. Бид Их Эзэний мөнхийн гэр бүлийн болон мөнх амьдралын төлөвлөгөөнд итгэж найддаг. Хэзээ гэдэг үгээс ирдэг хүч чадал бидэнд үргэлжлүүлэн урагш тэмүүлэхэд тусалдаг. ■

*Өгүүллийг зохиогч нь Канадын Бритиш Колумбид амьдардаг.*





## ГОРДОН Б.ХИНКЛИ

Гордон Б.Хинкли багаасаа байгальд дуртай болон өсчээ. Хүүхэд байхдаа тарьж ургуулсан хушганы модоор нь **Чуулганы төвд** байдаг индрийг хийсэн байна. Гордон бага байхдаа олж харж мэдсэн чиглүүлэгч **Алтан гадас** одтой Аврагчийн хайрыг ихэвчлэн зүйрлэдэг байв. Тэрээр сүмд үйлчлэх хугацаандаа хоёр сая гаруй бээр (3.2 сая км) **аясан** байна. Түүний гэрчлэлийг **хиймэл дагуу** дэлхий даяар нэвтрүүлсэн билээ. Түүнийг ерөнхийлөгч байх хугацаанд дахин баригдсан **Наву Иллиной ариун сүмийг** оролцуулаад нийт 70 гаруй ариун сүм онцгойлон адислагдсан байна.

# Энэ дугаарт

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ



### АЗ ЖАРГАЛД

хүргэх замыг дага

Бишоп Жэралд Коссэй нөхцөл байдлаасаа  
үл хамааран аз жаргалаа бий болгох гурван  
зарчмыг заасан.

42

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



52

Хэрэв би **ЦЭЭЖИН**  
догтроо **ШАТАХ** мэт  
мэдрэмжийг мэдрэхгүй  
байвал яах вэ?

Бүү санаа зов. Ариун Сүнсийг  
мэдрэх нэгээс илүү арга зам байдаг.

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

### Виллийн гайхалтай санаа

Гэртээ өлгөх ариун сүмийн  
зураг хэрэгтэй байна уу?



78

